

ГҮНЗГИЙ МЭД

# MONGOLIAN ECONOMY

2015 оны 06 сар. № 13 (092)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

**БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**

Эмээ ба Оюутолгой

**ЕРТӨНЦ**

Шагнал ба шаналал

Тэд хэн бэ

**БИЗНЕС**

Өмчийг үржүүлэх ухаан

## ГҮНИЙ УУРХАЙН ГҮН УХААН



МЭДЛЭГ  
МЭДЭЭЛЭЛ  
ИНФОГРАФИК  
НИЙТЛЭЛ  
ВИДЕО  
ХАДГАЛАМЖ  
ЭРСДЭЛ  
ЗӨВЛӨГӨӨ  
АШИГ  
САНХҮҮ  
БОЛОВСРОЛ%

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН  
ЦОГЦ САЙТ



[www.golomtbank.com](http://www.golomtbank.com)  
ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД

БАНК  
ЗЭЭЛ  
ХУВЬЦАА  
ХАДГАЛАМЖ  
ХАРИЛЦАГЧ  
МОНГОЛД ₮  
МӨНГӨ  
ӨРХИЙН САНХҮҮ  
АНХ  
төлөвлөгөө  
БИЗНЕС  
ЗЭЭЛИЙН ХҮҮ  
УДАА  
төсөл  
төсөв  
ХУВЬ ХҮН



**summit**  
computer technology

## ВИРТУАЛ КОМПЬЮТЕРИЙН ДЭД БҮТЭЦ



VIRTUAL DESKTOP  
INFRASTRUCTURE  
(VDI) SOLUTIONS

### Increase endpoint security

VDI шийдэл нь эцсийн хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг төрөл бүрээр ханган ажиллаж чаддаг. Жишээ нь: Та өөрийн болоод байгууллагын мэдээллийг гадагш зөөх, алдагдахыг сэргийлэх гэж нэмэлт вирусны эсрэг програм хангамж авах шаардлагагүй. Зөөврийн бүхий л төрлийн төхөөрөмжид хяналт тавих боломж.



### Reduce the time & Cost of managing user desktop

Урьдаас бэлдсэн виртуал орчинг ашиглан хэрэглэгчийн компьютерийг болоод шинэ ажлын байр бэлдэх, зохион байгуулах, суурьлиулахад хялбар бөгөөд хурдан. Ингэснээр мөн мэдээллийн технологийн ажилтаны цагийг ихээр хэмнэх, үр ашигтайгаар илүү их ажиллах боломжийг олгодог.



### Reduce energy usage by up to 90%



Wyse



Dell Wyse Thin Client/Zero Client нь энгийн уламжлалт суурин компьютертай харьцуулахад эрчим хүч бага зарцуулж халалт бага үзүүлдэг. Ердийн дундаж үзүүлэлттэй компьютер ачааллаж байх үеийн үзүүлэлт 150-250 Ватт хэрэглэдэг байхад Клинтүүд нь 4-15 Ватт зарцуулдаг байна.

Төхөөрөмжийн нэр	Нэгж тог зарцуулалт	100 төхөөрөмж			
		Нийт зарцуулалт	Тогны үнэ (төг/кВт.ц)	Цагт төлөх дүн (төгрөг)	Жилд төлөх дүн
Dell Wyse ThinClient 3012-T10D	10 ватт	1000 ватт	124.2	124.2	260,323.2Т
Dell OptiPlex 3020	150 ватт	15,000 ватт		1863	3,904,848.0Т

Жишээ нь: 2 төхөөрөмжийн асаалттай байх үеийн жилд төлөх ажлын 2096 цагийн бүтэн асаалттай байх үеийн тогны харьцуулалтыг харуулав.

### Centralized IT Management



VDI нь Citrix® Microsoft® VMware® зэрэг виртуалчилалын платформуудын тусламжтайгаар төвлөрсөн удирдлагын системийг бий болгож чаддаг. Мөн эдгээр хүчирхэг програм хангамжийн бүхий л боломж, чанаруудыг өөрсдийн шийдэлдээ өргөнөөр ашиглах боломжтой.

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.БЭХБАЯР / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.ҮҮРИЙНТУЯА

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.ТҮВШИН

ВЭБ РЕДАКТОР:

Б.ЭНХЦЭЦЭГ

СЭТГҮҮЛЧИД:

А.БҮРЭНЖАРГАЛ

Г.ОРХОН

Э.ЗОРИГТ

Ц.ЭЛБЭГСАЙХАН

ДИЗАЙНЕР:

С.ЭРДЭНЭЦОГТ

ОРЧУУЛАГЧ:

Б.ЭНХМӨНХ

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904

Ч.ҮҮРИЙНТУЯА / 9409 2905

## ХАЯГ

УЛААНБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ.

I ХОРОО, ЭНХТАЙВНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ.

ЭКСПРЕСС ТАУЭР. 1101 ТООТ

15160 УЛААНБААТАР, ТӨВ ШУУДАН,

Ш/ Х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“УЛААНБААТАР ПРИНТ” ХХК-д ХЭВЛЭВ

WWW.UBPRINT.MN

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

“ИНТЕР НОМ”

“ЦЭЦЭГ ТӨВ”

“МИНЖ ПЛАЗА”

“АЛТАНТҮЛХҮҮР” НОМЫН ДЭЛГҮҮР

“НОМИН” СУПЕРМАРКЕТИЙН БҮХ САЛБАР

“МАКС” СУПЕРМАРКЕТИЙН БҮХ САЛБАР

“ФРЕСКО” СУПЕРМАРКЕТ

BTSI СУПЕРМАРКЕТ

“АЗ ОРЧЛОН” НОМЫН ДЭЛГҮҮР

“БИЛЭГ” ИХ ДЭЛГҮҮРИЙН НОМЫН ТАСАГ

“ГРАНД ПЛАЗА” ДАХЬ СУПЕРМАРКЕТ

“МИР” НОМЫН ДЭЛГҮҮРИЙН

“GRAND PLAZA”

“METRO MALL”

“SKY” СУПЕРМАРКЕТ

“УЛААНБААТАР” ИХ ДЭЛГҮҮР

“MAX MALL” ДЭХ САЛБАРУУД

## ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Манай сэтгүүл өмнөх дугаараа “Монголын эдийн засаг дашийн шог” гэсэн нүүр гарчигтайгаар явуулсан. Эдийн засаг улам уналаа, компаниуд улам хүндэрлээ, ажилгүйдэл ихэслээ, иргэд мөнгөгүй боллоо хэмээн бодит байдлыг харуулсан сурвалжлага, нийтлэл хийсэн юм. Ер нь л эдийн засаг дордлоо, цаашаа яах вэ гэсэн утгыг илэрхийлж, дашийн шог гэдэг үгийг хэрэглэсэн билээ.

Харин сэтгүүлийг маань хэвлэлтэд явж байх үеэр Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд гарын үсэг зурсан мэдээ олон нийтэд тарав. Манай сэтгүүлийнхний хувьд цохилтод орсон гэх үү дээ. Харин бидний эдийн засаг дашийн шог боллоо гэсэн шинэхэн дугаарын маань үнэ цэнэ жаахан буурсан юм. Хүмүүс эдийн засаг одоо дашийн шог болохгүй ээ, сэргэнэ гэсэн итгэлтэй болчихсон байлаа.

Мэдээж бид уг мэдээг мөн л бусдын адил эерэг сайн мэдээ гэж хүлээн авсан. Тийм учраас энэ дугаараа Оюутолгойн асуудалд зориулав. Олон нийтэд баримт дээр тулгуурласан зөв мэдээлэл өгөхийг хүсэв. Гүний уурхайн төлөвлөгөөгөөр ямар бүтээн байгуулалт босгох юм, талууд ямар асуудлууд дээр буулт хийсэн, татвар, зардлын хэтрэлтийн асуудлыг хэрхэн шийдсэн, цаашаа яаж явах, эдийн засагт ямар нөлөө үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдын байдал зэрэг асуудлыг нэг дор цогцоор хөндөхийг хичээлээ. Тус төлөвлөгөөнд гарын үсэг зурсан “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэс Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирлуудыг редакцидаа урьж ярилцлаа. Сайны хажуугаар саар гэдэг дээ. Асуудалд өөр өнцгөөс хандаж, нөгөө талаас харсан шүүмжлэгчид гарч ирэх нь мэдээж.

100 жилийн настай, дэлхийд эхний аравт орох хэмжээний том төсөл шүү дээ. Улстөржүүлэхгүйгээр асуудалд бодитой хандаж, шүүмжилж, бас дэмжиж ажиллаасай.

**Д.БЭХБАЯР**



facebook.com/Mongolian.  
Economy



twitter.com/  
EconomyMongolia



SOYOL  
Wellness Center

MONGOLIAN FIRST WELLNESS CENTER

GRAND OPENING 2015.06.19



SAUNA | HOTEL | SPA | MASSAGE | RESTAURANT | MORE ...

TEL: 77009966

WEB: WWW.SOYOL.MN

ТА ӨӨРИЙН ГЭР БҮЛ,  
ҮР ХҮҮХЭД, ӨМЧ ХӨРӨНГӨ,  
БИЗНЕСИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД  
**САНАА ЗОВИНОДОГ УУ?**

ТЭГВЭЛ ОРОН ЗАЙ ЦАГ ХУГАЦААГ ҮЛ ХАМААРАН БҮХНИЙГ ХЯНАХ  
БОЛОМЖИЙГ “ДУВАСОХОР НӨ” КЛОУД КАМЕР ТАНЬД ОЛГОЖ БАЙНА



**HD**  
720p

Дуу болон Дүрсийг HD чанартайгаар дамжуулна



Камерны чанга яригчийг ашиглан харилцан ярилцах боломжтой



Univision, Skymedia болон бусад бүх төрлийн интернет түгээгчийн WiFi төхөөрөмжтэй шүүд зохицон ажиллана



WiFi болон 3G холболттой бүх төрлийн төхөөрөмжөөс хянах боломжтой



7-30 хоногийн бичлэг хадгалах клоуд үйлчилгээг камер түс бүрт сонгон хэрэглэнэ



Таны эзгүйд хөдөлгөөн илэрсэн тохиолдолд гар утас руу тань анхааруулах мессеж зургийн хамтаар илгээнэ



Та нэмж бичлэгийн төхөөрөмж, хард диск, хяналтын компьютер, статик IP хаяг зэргийг худалдан авах шаардлагагүй ба мэргэжлийн үгсралт суурилуулалт, техникийн үйлчилгээ, хөглөрсөн утас кабельгүйгээр хүссэн газраа суурилуулан мөн зөөж ашиглах боломжтой

“ДУВА СОХОР НӨ” КЛОУД КАМЕР: **950 000₮**

MONGOLIAN ECONOMY СЭТГҮҮЛИЙН ЧНШИГЧДАД ТУСГАЙ БЭЛЭГ

**LIVE UB.MN**

Cloud video surveillance  
Mongolian Economy June 2015

Вэб: [www.liveub.mn](http://www.liveub.mn)  
Facebook: [www.facebook.com/www.liveub.mn](http://www.facebook.com/www.liveub.mn)  
Утас: 94242564  
И-мэйл: [info@liveub.mn](mailto:info@liveub.mn)  
[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

**50 000₮**

## ЭДИЙН ЗАСАГ

10 ОЮУТОЛГОЙ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ

12 ОЮУТОЛГОЙ ТӨСӨЛ МОНГОЛД АШИГТАЙ  
ГЭДЭГТ ИТГЭЛТЭЙ БАЙНА .....

20 ОНЦЛОХ 20 ЭШЛЭЛ

24 МӨНГӨӨР ҮНЭЛШГҮЙ ҮНЭ ЦЭНЭ

28 ЗАРДЛЫГ ЮУНД ЗАРЦУУЛАВ?



## УУЛ УУРХАЙ

30 ТООН МЭДЭЭЛЭЛ: ОРДЫН НӨӨЦ

32 ГҮНИЙ УУРХАЙН ГҮН УХААН .....



## ЕРТӨНЦ

34 ШАГНАЛ БА ШАНАЛАЛ

36 ТУРКОЙЗ ХИЛЛ РЕСУРС

## БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

38 ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ

40 “ЭРДЭНИЙН ГОВЬ”-ИЙН ЭЗЭД ИЙН ЯРЬЖ  
БАЙНА .....

44 ЭМЭЭ БА ОЮУТОЛГОЙ



## БИЗНЕС

46 МОНГОЛЫГ АЖИЖ СУУГАА ЕВРОПЫН  
“АКУЛУУД” ИНГЭЖ ХЭЛЭВ .....

48 ӨМЧИЙГ ҮРЖҮҮЛЭХ УХААН

50 САЛХИ ХААШАА ЧИГЛЭНЭ ВЭ



### Эрдэс баялгийн бирж байгуулна



Сүүлийн жилүүдэд төмрийн хүдэр, баяжмалын үнэ дэлхийн болон өмнөд хөршийн зах зээл дээр унасаар буй. Түүхий эд үйлдвэрлэгч компаниудын экспортын орлого, санхүү мөнгөний хувьд хүндхэн байдалтай байна. Иймд дотоодын төмрийн хүдрийн уурхайнууд нэгдснээр үнээ унагахгүй борлуулалт хийх боломж бүрдэнэ гэж салбарын мэргэжилтнүүд үзэж байна. Үүнд уул уурхайн яамнаас боловсруулж буй “Эрдэс баялгийн бирж”-ийн төсөл чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байгаа учир тус биржийг байгуулах асуудлыг судалж, богино хугацаанд шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа талаар холбогдох яамнаас мэдээллээ.

### Хөрөнгө оруулалт




Гадаадын шууд хөрөнгө оруулалт энэ оны эхний гурван сарын байдлаар 31.8 сая ам.долларын сөрөг дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 94 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн толгой компаниасаа авсан зээлийн эргэн төлөлт их хэмжээгээр хийгдсэн тул 2015 он гарсаар шууд хөрөнгө оруулалт сөрөг дүнтэй хэвээр буй.

Гэсэн ч Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт эхлэх болсонтой холбоотойгоор гаднын хөрөнгө оруулалт сэргэнэ хэмээн эдийн засагчид хэлж байна.

### Татвар

Энэ оны эхний гурван сарын хугацаанд “Оюу Толгой” компани улсын төсөвт 66.4 сая ам.долларын татвар төвлөрүүлж, 78.3 сая ам.долларын бараа үйлчилгээг үндэсний ханган нийлүүлэгчдээс худалдан авсан байна. Мөн 14.1 сая ам.долларын бараа үйлчилгээг Өмнөговь аймгийн аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс худалдан авчээ. Өнгөрсөн 2010-2014 оны хооронд төлсөн татварын хэмжээгээрээ улсын хэмжээнд эхний хоёрдугаарт жагсаж буй.

### Тусгай зөвшөөрөл



Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгож эхэлсэнээс хойш нийт 956 аж ахуйн нэгж Ашигт малтмалын газарт бүртгүүлээд байна. Бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдийн 899 нь дотоодын хөрөнгө оруулалттай бол 45 нь гаднын хөрөнгө оруулалттай /БНХАУ-17, Сингапур-9, Австрали-4, Канад-3, Люксембургийн вант улс-3, бусад-9/ компани байна. Харин 12 нь хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгаа юм. Өнгөрсөн сарын эцэс гэхэд цахим хэлбэрээр 1686 өргөдлийн дугаар олгосон байна. Үүнээс Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хянан үзэж 234 тусгай зөвшөөрөл шинээр олгосон бөгөөд тусгай зөвшөөрөл олгох боломжтой 496 өргөдлийг холбогдох аймгийн Засаг даргаас санал авахаар мэдэгдэл хүргүүлсэн талаар Ашигт малтмалын газраас мэдээллээ. Түүнчлэн энэ оны эхнээс өнгөрсөн сарын 26 хүртэлх хугацаанд тусгай зөвшөөрлийн төлбөрөөр 12.42 тэрбум төгрөг, үйлчилгээний хөлс 488.35 сая төгрөг, хайгуулын тусгай зөвшөөрлийн эрх олгох үйлчилгээний хөлсөөр 477 сая төгрөг, өргөдлийн дугаар олгох цахим системд нэвтрэх эрхийн төлбөр 728 сая төгрөг, нийтдээ 14.1 тэрбум төгрөгийг

улсын төсөвт төвлөрүүлжээ.

### Эрчим хүч



“Оюу Толгой” компани хөрш зэргэлдээ сумдын иргэдийг цахилгаан эрчим хүчээр хангах боломж бүрдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж буй. Тухайлбал, 2013 оны арваннэгдүгээр сард Оюутолгойн уурхай Ханбогд сумын хооронд 40 км урт, 35 кВт-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станцын туршилт, тохиргооны ажлыг гүйцэтгэж, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д хүлээлгэн өгсөн. “Оюу Толгой” компани энэхүү ажлыг нийт 7.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. Ингэснээр Ханбогд сумынхан байнгын цахилгаан эрчим хүчээр хангагдсан юм. Түүнчлэн Эрчим хүчний яамнаас Ханбогд, Баян-Овоо сумын хэрэглэгчдийг Төвийн эрчим хүчний системээс цахилгаанаар хангах зорилго тавьж энэ хүрээнд “Рио Тинто”, “Оюу Толгой” компаниас 270 сая төгрөгийн дэмжлэгийг “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д үзүүлэхээр болсон байна. Үүнийг Оюутолгойн уурхайн цахилгааны дэд станц болон төвийн эрчим хүчний дэд станцын хооронд 5.1 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам барихад зарцуулах аж. Тус агаарын шугамын барилгын ажил өнгөрсөн сард эхэлсэн бөгөөд энэ оны долдугаар сарын сүүлээр дуусах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм. Ингэснээр Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумын иргэд, хэрэглэгчид Оюутолгойн уурхайн цахилгааны үүсвэрээс хамааралгүй болж төвийн эрчим хүчний системээс цахилгаанаар хангагдаж эхлэх юм.

### ДЭЛХИЙД

#### Тэгш бус байдал

2014 онд нэгэн дуулиан тарьсан “21-р Зууны Капитал” номын зохиолч



Томас Пиккети Лондонгийн Эдийн Засаг Улс Төр Судлалын их сургуулийн Их Британийн улс төр-бодлогын блог дээр нийтлэл бичсэн байна. Уг нийтлэлд хувийн хөрөнгөөс прогрессив татвар авах хэрэгтэй хэмээн дурьджээ. Мөн хэдийгээр үүнийг хэрэгжүүлэхэд хэцүү ч хэрэв дэлхийн нийт бүтээгдэхүүний дөрөвний нэгийг үйлдвэрлэдэг АНУ болон Европын холбоо дэмжих аваас энэ нь боломжтой гэсэн байна. Пиккети хэлэхдээ дэлхийн баялаг АНУ-аас илүүтэй Европын хөрөнгөтнүүдийн гарт түлхүү төвлөрч байсан бол өнөөдөр Европт, тэр дундаа Их Британид тэгш бус байдал оршисоор байгаа бөгөөд үүнийг шийдвэрлэх хамгийн тохиромжтой арга бол хувь хүний хөрөнгөөс татвар авах гэжээ.

**БНХАУ-ын орон сууцны зах зээл**



БНХАУ-д шинэ орон сууцны үнэ найман сарын турш дараалан буурч байгаа аж. Шинэ орон сууцны үнэ Бээжин хотод өнгөрсөн дөрөвдүгээр сард өссөн ч Хятадын бусад томоохон хотод дундаж үнэ өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад зургаа буюу түүнээс дээш хувиар буурсан байна. Дэлхийн хоёр дахь том зах зээл болох тус улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг Хятадын эдийн засгийн хамгийн том эрсдэлүүдийн нэг гэж үзэж байгаа юм. Орон сууцны үнэ жижиг хотуудад мөн буурах хандлагатай байгаа. БНХАУ-ын эдийн засгийн тавны нэгийг эзэлдэг үл хөдлөх хөрөнгийн салбар нь сүүлийн 25 жилд байгаагүй хамгийн удаан өсөлттэй байх төлөвтэй байна. Хятадын Төвбанк зээлжилтийг дэмжихийн тулд зургаан

сарын дотор гурав дахь удаагаа зээлийн хүүгээ буруулжээ.

**Ашигт малтмал**



Европын парламент зэвсэгт мөргөлдөөний бүс дэх ашигт малтмалын хуулийг илүү чанга болгохыг дэмжин санал өглөө. Зэвсэгт мөргөлдөөний бүс, тэр дундаа Африкийн алт, тантал (гар утасны чичиргээнд ашигладаг), гянт болон тугалгын импортод хатуу хяналт тавьж зэвсэгт мөргөлдөөнийг санхүүжүүлэхээс сэргийлэх аж. Энэ шийдвэр ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулдаг Европын 800 мянга гаруй компанид нөлөөлөх юм. Ингэснээр импортлогчид хайлуулах болон боловсруулах үйлдвэрүүд төдийгүй гар утас, таблет болон компьютер үйлдвэрлэгчид бүгд өөрсдийн бүтээгдэхүүнд хэрэглэж буй ашигт малтмалаас олсон орлого нь дайн санхүүжүүлэх хэрэгтэй болох юм. Ашигт малтмалын зөрчилтэй олборлолтод Африкийн 27 зэвсэгт мөргөлдөөний бүс хамарч байгаа аж.

**"FIFA"**



Дэлхийн хөлбөмбөгийн удирдах байгууллагын 14 албан тушаалтныг Швейцарийн эрх баригчид баривчилсан бөгөөд хэрэгтнүүдийг АНУ-д шилжүүлж өгөх магадлалтай байна. 2022 онд болох хөл бөмбөгийн Дэлхийн аваргыг зохион байгуулах улсын сонгон шалгаруулалтад Катар улс тэргүүлснээс хойш "FIFA"-г тойрох маргаан улам хүндэрсэн юм. Дээд түвшний албан тушаалтнуудын авлигын хэргээс гадна хүний эрхийг хамгаалах байгууллагууд

Катарыг цагаач ажилчидтай зүй бус харьцдаг хэмээн буруутгаж байгаа бөгөөд 2022 оны дэлхийн аваргын нэг тоглолт тутамд 62 хүн амь үрэгдэнэ гэсэн тооцоо байгаа юм. Хүний эрхийн төлөө байгууллагууд "FIFA" болон Катарт өргөдөл гаргасан ч тэднээс хариу сонсоогүй тул Кока-Кола, "Visa", "Adidas" болон "McDonald's" зэрэг ивээн тэтгэгчтэй холбогдох нь илүү хялбар хэмээн үзэж тэдэнд анхаарлаа хандуулаад байгаа аж.

"Visa" хэрвээ "FIFA" авлигын асуудлаа дахин авч хэлэлцэхгүй аваас санхүүгийн дэмжлэг өгөх тал дээр дахин дүгнэлт хийхээс өөр аргагүй гэж мэдэгджээ. Харин цагаач ажилчдын эрхийг зөрчиж буй асуудлыг ивээн тэтгэгчид, "FIFA" болон Катарын Засгийн газар үйл ойшоосоор байна.

"FIFA" -аас зохион байгуулдаг хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн нь дэлхийн хамгийн том спортын арга хэмжээ бөгөөд Бразил улсад зохиогдсон 2014 оны хөлбөмбөгийн дэлхийн аваргын тэмцээнийг дэлхийн долоон хүн тутмын нэг нь үзжээ.

**Жон Нэш**



Алдарт математикч Жон Нэш болон түүний эхнэр 2015 оны тавдугаар сарын 23-нд автын ослоор нас баржээ. Тэрбээр 1994 онд Нобелийн Эдийн засгийн шагналыг тоглоомын онолын ажлаараа хүртэж байсан. Өдгөө түүний онолыг эдийн засгийн салбарынхан тогтмол ашигладаг. Тэрбээр математик болон эдийн засгийн тайлагдашгүй хэмээгдэж байсан асуудлуудыг тайлж, олон шагнал хүртэж байсан. 1959 онд сэтгэцийн өвчний жинж тэмдэг илэрч, улмаар даамжирч байсан. Олон жилийн турш шизофрений эмчилгээ хийлгэж байжээ. Тэрбээр математикийн салбарын хүндтэй шагнал болох Абелийн шагналыг гардсаны дараагаар харих замдаа ийн осолджээ. ■



## ӨӨР ӨНЦГӨӨС

Оюутолгойн гүний уурхайн төлөвлөгөөнд "Эрдэнэс монгол" ХХК -ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, "Эрдэнэс оюутолгой" ХХК-ийн гүйцэтгэх захирал Да.Ганболд болон "Рио Тинто" компанийн Зэс, нүүрсний группын гүйцэтгэх захирал Жан Себастьян Жак нар гарын үсэг зурав. АНЭУ. Дубай хот. 2015 он. 05. 19

## Оюутолгой Монголын эдийн засагт

Д.Бэхээ

Монголын эдийн засагт тэнгэр цэлмэх шиг л мэдээ Дубайгаас сонсогдсон юм. Үнэндээ бүх л түвшний хүмүүст мэдрэгдсэн байх. Одоо л нэг... гэж. Саарал баргар амьдрал Монголын эдийн засагт үргэлжлээд байлаа шүү дээ. Хаашаа ч үгүй гацаанд орсон бүрхэг өдрүүдийг иргэд тэвчээртэй өнгөрүүлсээр тэвчээр нь барагдах дээрээ тулаад байсан юм. "Ард түмэн мөнгөгүй болж, амьдрал нь доошлоод ирэхээр миний буруу юу, төрийг жолоодож буй хүмүүсийн буруу юу гэдгийг бодож, шүүж эхэлдэг" хэмээн эдийн засагч, доктор Д.Цэрэндорж ярьсан билээ.

Үнэхээрийн иргэд төр, засаг руу анхаарлаа хандуулж, тэдний алдаа оноог цэгнэн, хариуцлага тооцох байдал

ажиглагдаж ирсэн. Төрийн ордон дотор ч өнөөгийн засгийг огцруулах, улмаар УИХ-ыг хугацаанаас нь өмнө татан буулгах асуудлаар яриа хүчтэй явж байсан юм. Харин Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд гарын үсэг зурсан мэдээ байдлыг нэлээд өөрчилсөн гэж хэлж болно.

Ялангуяа бизнесмэнүүд мэдээг баяртайгаар хүлээн авч, дэмжиж буйгаа онлайн ерөнцөөр илэрхийлж байсан бол иргэд ч талархан хүлээн авсан. Яагаад гэвэл хоёр толгойн нэг нь хөдөлчихвөл ажил амьдрал дээшилж, хямрал гэдэг үгийг мартаж, амар ажиллаж, амьдарна гэсэн бодол тэдний тархинд хэдийнэ сүүчихсэн. Тийм ч учраас Ерөнхий сайдын санал

асуулгад том төслүүдээ хурдан явуулья гэж хариу өгсөн шүү дээ. Компаниуд илт сэргэж ирсэн. Гэхдээ мөнгө санхүүгийн хувьд биш л дээ. Үйл ажиллагаагаа түр зогсоосон нь ажилдаа орж, халсан ажилтнаа эргэж авах, зогссон төслөө эргэж харах, холбоо харилцаагаа тасалсан байгууллагуудтайгаа ярих зэргээр ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж, унтаа байдлаас нэлээд идэвхтэй хөдөлгөөнд орсон. Зуны улирлыг гадаадад өнгөрөөхөөр явсан танил бизнесмэн маань "Хонгилын үзүүрт гэрэл харагдаж эхэлсэн учраас өчигдөр хүрээд ирлээ" хэмээн яриу. Ажилтнуудаа хурдан амраа гэж байсан компаниуд байдлыг харзнахаар шийдэж.

Харин Саарал ордны түшмэдүүд Дубайн гэрээг гайхан хүлээн авчээ.

Засгийн газрын тэргүүнд баяр хүргэхээсээ илүүтэй яагаад Дубайд гэж, яагаад Оюутолгойг явуулахаар шийдчихэв хэмээн улстөрийн үүднээсээ хандаж эхэлснээс харж болно. Хилийн чанадад гарын үсэг зурсан нь “но”-той гэж үзэн “но” илрүүлэх ажилд цагаа зарцуулж, төлөвлөгөөнд биш Гэрээнд гарын үсэг зурчихаж, монголчуудын өмчийн гэрээг харийн оронд биш эх орондоо зурах байсан, Сангийн сайддаа ч хэлээгүй явсан байна гэсэн асуудал үүсгэсэн. Харин Дубайд гарын үсэг зурсан талаар “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан “Ерөнхий сайдын айлчлалын үеэр Рио Тинтогийнхонтой дараагийн хэлэлцээрийг амжилттай хийж чадсан тул тэр дор нь баталгаажуулахыг л хүссэн. Бид явахдаа гарын үсэг зурна гэж төлөвлөөгүй байсан. Дубай бол орчин үеийн санхүүгийн төв хотуудын нэг шүү дээ” гэсэн хариу өгсөн.

Ийнхүү сонгуулийн чимээ ойртсон үед тэд ард түмнээс яаж оноо авахаа мэдэх тул сөрөг зүйлс ярьж, иргэдийн тархийг угаах ажилдаа ханцуй шамлан орлоо. “Эрдэнэс Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Д.Ганболд “Оюутолгой бол сонгуулийн сүүлийн өдөр хүртэлх халуун сэдэв байсаар байх болно. Харин сонгуулийн маргаашнаас Оюутолгойг хүмүүс бараг ярихгүй” гэсэн юм.

Энэхүү том төслийг хөдөлгөх чимээ манай эдийн засагт эерэг дохио болж, үр дүн ч эхнээсээ гарч буйг бид сонсож байгаа. Мэдээж төлөвлөгөөнд гарын үсэг зурснаар маргааш эдийн засаг

сайжирчихгүй, нөгөө сонсогдоод буй их хэмжээний ноён долларууд хийсээд ороод ирэхгүй. Цаг хугацаа шаардагдахыг мэргэжилтнүүд хэлж байгаа. Гэхдээ л эерэг мэдээлэл болж чаддаг ажээ. Том төсөл араасаа том л зүйл дагуулдаг гэдэг. Наад захын жишээ нь бизнесмэнүүд болоод иргэдийн сэтгэлийг тайвшруулсан гэхэд болно. Гадаадынхны хувьд Монголыг зорих томиллоотоо авч эхэлжээ. Улсын баяр наадам үзэнгээ ажил төрлөө амжуулаад явдаг гадны зочид гийчид, албаны хүмүүс онгоцны тасалбараа захиалж, зочид буудлуудад захиалга өгч эхэлсэн байна. За тэгээд улс орнууд Элчин сайдын яамаа нээлээ, нээхээр ч ярьж байна. Гадны томоохон санхүүгийн байгууллагууд манайд хөрөнгө оруулалт хийх гэж байна.

Мөн түүнчлэн “Оюу Толгой” компани цомхотгосон ажилтнуудаа аваад эхэлж. Ажлаасаа халагдсан, цомхотголд өртсөн ажилтнууд руугаа компаниуд нь ярих болж. Хамгийн ойрын жишээ гэвэл манай сэтгүүлийн холбоо харилцаа ч сэргэж ирлээ. Хилийн чанадаас хамтран ажиллах тухай ярьж байна. Дотоодын компаниуд сурталчилгаа нийлүүлэх графикаа тохирч байна. Энэ бүхэн эерэг дохио биш гэж үү.

“Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөний тайланг Сангийн яам өнгөрсөн долоо хоногт хүлээж авсан. Одоо хамгийн түрүүнд ашигт малтмалын нөөц ашигласны татвар 20-иод сая ам.доллар, дээр нь татварын 30 сая ам.доллар төсөвт орно. Наадмаас

өмнө улс 30-40 сая ам.доллартай болно. Ядарсан хүнд багагүй мөнгө” хэмээн Д.Ганболд захирал ярилаа.

Мөн Монголын хөрөнгө оруулалтын банк групп болон “Ресорс Инвестмент Капитал” компани хамтран Монголын уул уурхайн салбарын судалгааг гаргажээ. Энэхүү судалгаа нь Оюутолгойн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтыг урагшлуулснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, Монгол Улсын хөрөнгө босгох чадамж ч нэмэгдэж, эдийн засаг хурдацтай өсөх талаар онцолсон байна. Түүнчлэн өнөөдрийн эдийн засгийн 3-4 хувийн өсөлт оны эцэст өсөх магадлалтай тухай судлаачид, олон улсын байгууллагуудын мэргэжилтнүүд ярьжээ. Оюутолгой хөдлөх чимээнээр шүү дээ. Хэрвээ энэ толгой таг байсан бол өсөлт оны эцэст дөрвөн хувиас буурах ч дүгнэлт гараад байлаа.

Ийнхүү Оюу гэх толгойн төсөл улсад ямар их ач холбогдолтойг зөвхөн чимээнээр нь харж байна. Тэгвэл мөнгө нь орж ирж, бүтээн байгуулалт нь босоод ирвэл манай эдийн засаг ямар болох уу. Ил уурхайнх нь ажил явсан, манай эдийн засгийн өсөлтийн оргил үе 2012 он байлаа. 17 хувийн өсөлт. Гаднынхны нүдийг орой дээр нь гартал гайхуулж, дотоодод бизнесийнхний ашиг орлого ихэссэн, ард иргэдийн амьдрал сайжирч ирснийг үл мартам.

Оюутолгойг улстөржилтийн сэдвээс үл мөргүй хасаж, гүний уурхайн ажлыг нь дэмжин явуулж ажиллавал дээрх өсөлт рүү богино хугацаанд эргээд ойртох магадлал тун өндөр буй билээ. ■





Фотог. Б.Бямба-Очир

РЕДАКЦИЙН УУЛЗАЛТ

## Оюутолгой төсөл Монголд ашигтай гэдэгт итгэлтэй байна

Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнд Дубай хотноо гарын үсэг зурсан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн гүйцэтгэх захирал Да.Ганболд нарыг редакциядаа урьж, энэхүү том төслийн эргэн тойрон дахь сэдвээр ярилцлаа.

**-Оюутолгой төслийг эхлүүлэхийг иргэд дэмжиж байгаа. Төсөл хэрэгжсэнээр олон зүйл сайн тал руу гаа өөрчлөгдөнө гэсэн хүлээлт гадуур байна. Бас сөрөг шүүмжлэл ярьж хэлэх нь ч байна. Харин та хоёрын хувьд энэ байдлыг яаж харж байна вэ?**

**Да.Ганболд / "Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн гүйцэтгэх захирал/:**

-Гэгээлэг талаас нь харвал олон давуу тал бий. Товчхондоо хэлэхэд хүн бүр бүх салбарын талаар нарийн

мэдээлэлтэй байх албагүй. Мэдэх юмаа л мэднэ. Гэтэл хүмүүс зайлшгүй мэдэх ёстой өөрийн эрүүл мэндээ мэддэггүй шүү дээ. Элэг, ходоод, зүрх ямар байгаагаа тэр бүр мэддэггүй. Насанд хүрэгсэд жил бүр шинжилгээ өгч, даралт, сахар зэргийг үзүүлж байх хэрэгтэй гэдэг. Гэтэл эрүүл мэндээс бусад зүйлсэд хэтэрхий мэдэмхийрч ханддаг тал байна.

Миний хувьд нэг зүйл дээр санал нийлдэг. Оюутолгой бол хүссэн ч хүсээгүй ч Монголын ард түмний өмч. Мэдсэн ч мэдээгүй ч ард түмэнд өгөөжөө өгөх том орд учраас л сонирхоод байна. Хүмүүс мэдэхгүй зүйлээсээ эхэндээ айж бишүүрдэг. Шинэ юм бүхэн айдас дагуулдаг. Анхны автомашин явж эхлэхэд урд талд нь хүн яваад "Энд машин явж байна шүү, зам тавиарай" гэдэг байсан. Харин өнөөдөр урдаа явган хүн явуулах юм бол машин унахын хэрэг юу байна. Машины түгжрэлийг цагдаа зохицуулна. Хүн замчилдаг

цаг байхгүй болсон. Үүнтэй л адилхан Оюутолгой өөрөө шинэ зүйл.

Сүүлийн 30-аад жилийн хугацаанд Оюутолгой шиг том төсөл манайд хэрэгжээгүй. Эхний жилүүдэд үл ойлголцол, тохиромжгүй зүйл их гарсан. Энэ бүгдийг зөв талаас нь шийдсэн гэж хатуу итгэлтэй байгаа учраас л төсөл хэрэгжиж эхэлсэн. Эерэг талаас нь харвал энэ төслийн үр өгөөжийг зөвхөн төр, засаг гэлтгүй нийт монголчууд, гурван сая иргэн ямар нэг байдлаар хүртэнэ. Монголтой харилцаж байгаа улс орнууд болон дэлхийн бүх хүнд эерэг дохио болж сайн үр дүн авчирна.

**-Ялангуяа бизнес эрхлэгчдийн зүгээс Оюутолгойг ихэд дэмжиж, энэхүү том төслийг урагшлуулах, Засгийн газрыг тогтвортой ажиллахыг хүсэж байгаа. Тэд нэгдэн нийлж, улстөржихөө болих цаг ирсэн талаар уриалга гаргалаа.**

## **Б.Бямбасайхан /“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал/:**

-Хамгийн чухал нь Оюутолгой өөрөө хоёр эзэнтэй бизнес гэдгийг ойлгох. Олон жилийн хугацаанд бүтээн байгуулалт нь үргэлжлэх том төсөл. Бизнесийн байгууллагуудын хувьд Оюутолгой бол үнэхээрийн хэрэгтэй төсөл. Учир нь гүний уурхайн бүтээн байгуулалт зогссон өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулалтын олон төсөл зогссон. Янз бүрийн л тоо байна. Тухайлбал, 50 гаруй компанийн шинэ төслүүд хэрэгжих боломжгүй болсон. Хамгийн багаар бодоход л хоёр тэрбум гаруй долларын хөрөнгө оруулалтын шинэ төслүүд зогссон байгаа юм. Мөн Тавантолгойн цахилгаан станц, Цагаан суварга, Тавдугаар цахилгаан станц гэх мэт. Эдгээр том төслийн хөрөнгө оруулалтыг тооцвол дөрөв орчим тэрбум ам.доллар буюу найм орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт зогссон байдалтай байна.

Бизнесийн өрсөлдөх чадварт санхүүжилтийн зардал чухал зүйл. Аливаа бизнесийг хийхэд мөнгө босгох хэрэг гарна. Сүүлийн 2-3 жилд санхүүжилтийн өртөг дор хаяж таван хувиар нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, Монголын компаниудын гаднаас зээлэх мөнгөний хүү нь нэмэгдэн хоёр дахин их болсон гэсэн үг. Тэгэхээр бизнес хийж байгаа хүмүүс ашиггүй ажиллаж, үүнийг дагаад өртөг нэмэгдэж, ажлын байр олноор буурсан. Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалттай шууд болон шууд бус холбоотойгоор өнгөрсөн хоёр жилийн хугацаанд 3000-4000 ажлын байр байхгүй болсон. Үүнийг цалин гэж үзвэл 100 сая ам.долларын мөнгө иргэдийн гар дээр очсонгүй. Том төсөл араасаа том өсөлт дагуулдгийг бид ойлгосон. Дэлхий дээр Монгол шиг өндөр өсөлттэй эдийн засагтай орон байсангүй. Том төсөл жижиг бизнесүүдийн өрсөлдөх чадвар, санхүүжилтийн өртөг, ажил, ашиг орлогод нь сайнаар нөлөөлдөг.

Засгийн газар энэ хоёр жилийн хугацаанд олон зүйл дээр алдсан. Тухайлбал, татваруудаа авч чадаагүй. Гүний уурхайн бүтээн байгуулалт үргэлжилсэн бол 250-300 сая долларын НӨАТ болон гаалийн татвар улсад орох байлаа. Мөн 40-50 сая долларын нийгмийн даатгал зэрэг бусад татвараа

аваагүй өнгөрөөсөн. Энэ алдсан боломж иргэн, аж ахуйн нэгжид өнөөдөр хэрхэн нөлөөлж байгааг бид харж байна.

**-Цаг хугацаа алдсаны бас нэг хамгийн гол учир бол төслөөс ашиг хүртэх талуудын хүсэл эрмэлзэл байсан шүү дээ. Тэгвэл өнөөдөр хэсэг бүлэг хүмүүс Оюутолгой Монголд ямар ч ашиггүй гэж л эсэргүүцээд байгаа. Та нар болохоор ашигтай гэдэг. Иргэд хэн нь зөв яриад байгааг мэдэхээ байлаа. Янз бүрийн мэдээлэл хүмүүсийг төөрөлдүүлж байна?**

-Да.Г: Ашиг гэдэг нэр томъёо нь өөрөө их сонин. Зах дээр яваа хоёр хүн наймаа хийж байгаа юм биш л дээ. Хоёр талдаа л ашигтай. Ашиггүй ажил хийхээр сэтгэл санаагаар төдийгүй олон талаар хохирно. Хямрал, алдагдал, сөрөг үр дагавар гарна.

Зуун жил ажиллах уурхай дээр ашиг, алдагдал ярих нь их хийсвэр яриа болоод хувирчихдаг. Яагаад гэвэл нэг ч улстөрч, эдийн засагч бодит жишээгээр тайлбарлаж томъёолж гаргаж ирж чадахгүй. Тооцоолол, томъёо, хүснэгт, тохиролцооны зүйлүүдийг зөв ойлгож уншиж, зөв төсөөлж, дэлхийн бусад жишигтэй зөв харьцуулж чаддаг хүмүүс л ямар нэгэн зөв дүгнэлт, үнэлгээ хийж чадна. Тийм харьцуулалт хийж чадахгүй хүн энэ талаар хэзээ ч мэдэхгүй. Бодит мэдээллийг нь аваагүй тохиолдолд зөв тооцоо, дүгнэлт хийж чадахгүй. Тэгэхээр үүнтэй жишихэд өмнө нь манай улсад машинтай хүн хэд байв. Зураг харвал Улаанбаатарын гудамжууд хоосон, машинтай хүн тун цөөн байсан. Явж байгаа нь нийтийн тээвэр эсвэл алба, амины цөөн машин. Ихэнх нь үеэ өнгөрөөсөн, улсын албанд явж байгаад актлагдчихсан машин байв.

Үүнтэй адилхан тэр үед “Эрдэнэт” гээд нэг үйлдвэр нээгдсэн. Тухайн үед Монгол нэг намтай, босоо удирдлагатай орон байсан. Хэдий тийм ч дотроо өөр үзэл бодолтой хүмүүс олон байв. “Эрдэнэт үйлдвэрийн гэрээ ашиггүй боллоо. Зөвлөлт холбоот улс буурай орныг хэтэрхий их шүлж байна. Шударга бус гэрээ хийснээр Монгол Улс энэ их өрнөөс үүрд салахгүй. Яагаад гэвэл 51 хувиа зээлээр авсан” гэж ярьж байсан удаатай. Тэгээд тухайн үеийн улс төрийн системийн аргаар хүмүүсийн амыг тагласан байдаг. Ажлаас нь

халж, ямар нэгэн улс төрийн торгууль, шийтгэл оногдуулж, дахиж юм ярих эрхгүй болгосон. Түүнээс хойш улс орон маань ч өөр боллоо. 40 жил өнгөрчээ. Өнөөдөр “Эрдэнэт” үйлдвэр Монгол Улсыг дампууруулсан уу, тэжээсэн үү гэдгийг хүн бүхэн мэднэ. Тэр үед ч шүүмжлэх зүйл байсан. Одоо ч байсаар байна. Магадгүй 10 жилийн дараа ч байсаар байх болно. Анх 1974 онд байгуулсан гэрээнээс үүдэлтэй зарим нэг заалт ашиггүй, шүүмжлэл дагуулсан байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ нэг муу юм нь нэг сайн зүйлээр нөхөгддөг. Олон талын хамтын ажиллагаа нэг нэгнийхээ дутууг нөхдөг.

Бид сүүлийн хэдэн сар тоо баримт, тооцоо дээр сууж ажиллалаа. Оюутолгой Монголд, ард иргэдэд ашигтай гэдэгт итгэлтэй байна. Үүнд Бямбасайхан захирал бид хоёр л сохроор итгэж хийгээд байгаа зүйл бас биш юм аа. Нэг гоё зүйр үг байдаг. Өөрийн нутагт бурхан байдаггүй гэж. Монголчуудын дотроос нэг нь босож ирээд юм ярихаар “За энэ юугаа мэддэг юм, майжиг гутал өмсчихөөд гудамжинд явж л байсан шүү дээ” гэдэг. Дан ганц монголчууд өөрсдөө анализ шинжилгээ хийгээд сайн, муу, ашигтай, ашиггүй гэж хэлэх нэг хэрэг. Тийм учраас дэлхийн түвшний мэдлэгтэй, том төслүүд дээр ажиллаад үзчихсэн, яаж шалгадаг, яаж тооцоолол хийдэг, ойрын болон дунд, урт хугацааны ашиг, алдагдлыг мэргэжлийн үүднээс задлан шинжилдэг хүмүүсээр хийлгүүлэхэд “Энэ нь танайд ашигтай гэрээ байна. Монгол Улс эндээс хожноо” гэсэн дүгнэлт хийсэн. Олон үзүүлэлтээр эдийн засаг, улс төр, нийгмийн талаасаа дунд болон урт хугацаандаа ашигтай гэж гарсан.

Бидний бодолтой нийлсэн. Зарим таарахгүй зүйл байсан ч ярьж, тайлбарлаад ойлголцсон. Тэгээд л явж байна. Одоо бол итгээд явна. Шалгадаг хүмүүс нь шалгаж байна. Манайд ч өөрийн шалгадаг байгууллагууд байгаа. Сангийн яам, татварын алба, статистикийн газар, зохих шийдвэрүүдийг цаг хугацаанд нь гаргаад явсан.

**-Олон зүйлд ашигтай гэлээ. Баримтаар баталж өгнө үү?**

**Б.Б:** Гүний уурхай яагаад Оюутолгойн бизнест хэрэгтэйг тайлбарля. Тус ордыг дэлхий дээр хамгийн том өрсөлдөх

чадвартай уурхай болгох боломж нь гүний уурхайд л байгаа юм. Гүний уурхайг ашигласнаар Оюутолгойн орлого нэмэгдэж, зардал багасна. Өөрөөр хэлбэл, ил уурхайг ашиглахад хэдэн жилийн дараа нөөц дуусчихна. Тэндээс хүртэх манай өгөөж сайндаа л 6-7 тэрбум доллар. Харин гүний уурхайн бүтээн байгуулалтыг хийснээр хүртэх өгөөж хэд дахин нэмэгдэнэ. Өнөөгийн үнэ цэнээр 50 тэрбум хүртэлх долларыг хүртэх боломжтой. Бизнес учраас аливаа зардлыг өөрийн хөрөнгө эсвэл зээлээр санхүүжүүлж болно. Энэ зарчим болон 2009 онд байгуулсан Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу банкнаас зээл авч, компани хөрөнгө оруулалтын өртгийг багасгаад илүү ашигтай ажиллах нөхцөлөө бүрдүүлээд явж байгаа бизнес.

Бизнес эрүүл явбал "Оюу Толгой" ХХК-ийн үнэ цэнэ Монголд мэдээж сайнаар нөлөөлнө. Тухайлбал, шинэ хөрөнгө оруулалтууд татна. Эдийн засаг сайжирна. Монголын хөрөнгийн хэмжээ Эрдэнэт, Оюутолгой гэсэн том компаниудын чансаагаар тодорхойлогдоно. Засгийн газар болоод бизнесийнхэн гаднаас мөнгө босгох том боломж нээгдэнэ. 2009 онд Оюутолгойн гэрээг байгуулж 2010 онд хүчин төгөлдөр болоод бүтээн байгуулалтын ажил хийгдэх үед Монголд олон шинэ бизнес төрсөн. Оюутолгойн нэг онцлог нь бизнесийн шинэ стандартыг Монголд нэвтрүүлсэн. Тэр нь тухайн компани Оюутолгойд нийлүүлэх бараа бүтээгдэхүүнээ чанартай сайн үйлдвэрлэж чадах юм бол хамтран ажилладаг зарчим тогтсон.



"Эрдэнэт" үйлдвэртэй Оюутолгойг их харьцуулж байна.

Бизнес эрхлэгчдийн хувьд Оюутолгой юугаараа онцлог вэ гэхээр тус компанитай хамтран ажиллахын тулд Саарал ордонд тухлах хэн нэгнийг таньдаг байх албагүй. Эзэн өөрөө л бүтээгдэхүүнээ сайжруулж, чанартай, стандартын түвшинд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадаж л байвал Оюутолгойтой гэрээ хийж хамтран ажиллах боломжтой. Харин "Эрдэнэт" үйлдвэртэй гэрээ хийхийн тулд танил тал хэрэгтэй болох гэх ч юм уу. Тэгэхээр Оюутолгойг дагаад бизнес сэргэж эхэлнэ.

### УИХ-ын сонгуулийн маргаашнаас Оюутолгойг ярих хүн бараг байхгүй болно

#### -Улс төрд ямар ашигтай төсөл вэ?

**Да.Г:** Монгол Улс их том газар нутагтай. Харамсалтай нь манай хоёр хөрш гүрэн илүү том газар нутагтай учраас газрын зураг дээр манайх жижиг харагдаад байгаа юм. Дэлхийн 200 гаруй улс үндэстэн дотор эхний 15,16-д ордог газар нутагтай улс. Нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээ, газар доорх баялгаараа дэлхийд эхний байруудад жагсах орон. Улс төрийн өнцгөөс аваад үзвэл Монголын нэр хүнд дэлхийд улам өсөж байгаа. Хоёр том хөршийн харилцаанаас даваад Англи, Америк, Япон, Солонгос, Герман улсуудын том бизнесүүд Оюутолгой төсөлтэй уялдаж орж ирэх гээд байна. Гүний уурхайн үйл ажиллагаа явж эхлэхэд Финлянд, Солонгос. Японы зэс хайлуулах

технологи манайд баталгаатай орж ирнэ. Цахилгаан, эрчим хүчний олон төсөл хэрэгжинэ. Бидний мэддэг нүүрс шатаадаг уламжлалт цахилгаан станц биш шүү. Ус, салхи, нар, газ зэрэг орчин үеийн технологиуд орж ирнэ.

Өнөөдөр "Оюу Толгой" ХХК-д 2500 гаруй ажилтан байнгын орон тоонд ажиллаж байна. Төсөл эхлэх үед гадаадын хэдэн зуун мэргэжилтэн байсан. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд сайн, муугаараа хэлүүлэн ажилласан гадаадынхан эрс цөөрч монголчууд нийт ажилчдын 95 хувийг эзэлсэн. Монголчууд ажиллаад явж чадах юм байна гэсэн улс төрийн дүгнэлт хийж байна. Итгэлцлийг мөнгөөр хэмжиж болдоггүй юм.

Улс орнууд Элчин сайдын яамаа манайд нээж эхэллээ. Улсууд визийн журмаа хөнгөвчилж байна. Цаашдаа визгүй ч болох байх. Ам.долларын ханш буурч ирлээ. Энэ улстай хамтарч ажиллах боломжтой юм байна гэсэн ойлголт яваад байна. Энэ бүхэн Монголд эерэгээр л тусна. Энэ бүхэн зүгээр л наад захын жишээ.

**Б.Б:** Хөрөнгө оруулалт гэж их ярьж байна. Эдийн засаг өндөр өсөлттэй байх 2011-2012 онд бид Монголд салхин цахилгаан станц хүртэл барьж байгуулсан. Өндөр эрсдэлтэй төслүүдэд хөрөнгө оруулалт татаж чадсан. Өнөөдрийн зээлжих зэрэглэл буурсан, итгэл алдарсан нөхцөлд том төслүүд хэрэгжих боломжгүй. Харин Оюутолгойн гүний уурхай хөдөлж эхэлснээр өөр салбаруудад хөрөнгө оруулалт татах боломж бүрдэнэ.

Эдийн засгийн асуудлууд хоорондоо уялдаатай нэгийгээ дагаад сэргэдэг. Эдийн засаг өсөлттэй үед гадаадын том компаниудын захиралтай очоод уулзахад улаан хивсээ дэлгээд хамгийн том дарга нь хүлээж аваад дайлж, цайлдаг байсан. Яг тэр компаниудынхаа захиралтай өнгөрсөн хоёр жилд уулзъя гэхэд цаг ч гаргахгүй болж байлаа. Найзууд учраас кофе үүх 15 минут олгоё, харин ажил ярихгүй шүү гэж тохирч байх жишээтэй.

**-Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөө нь өгөөж өндөртэй биш, харин төслийг дагаж орж ирж буй өгөөж нь өндөр юм гэх тайлбар байгаа?**

**Да.Г:** Өгөөж нь өөрөө юу юм бэ

гэдгийг хэн ч нарийн тодорхойлж чадахгүй. Өөрийгөө мундаг эдийн засагч гэж бодож, хүнд ярьсан ч би үүнийг мэдэхгүй. Яагаад гэвэл, Монголын нэг зүйр үг бий. Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг гэж. Маргаашийн өөх үү, өнөөдрийн уушиг яриад байна уу. Мөн тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусалсан нь дээр гэж бас ярьдаг. Юмны үнэ цэнэ өөр нөхцөл, өөр цаг үед өөр өөр байдаг. Өгөөж гэдэг нь эдийн засгийн нэр томъёо биш. 100 жил явах уурхайн өгөөжийг хүн мэдэхгүй. Учир нь өнөөдрийн нүдээр, өнөөдөр гар өргөж шийдвэр гаргадаг хүмүүс л маргаад байна шүү дээ. Өнөөдрийн энэ сэдвээр зуун жилийн дараахыг дүгнэхэд хэцүү. Өгөөжийн хувьд.

Тэгэхээр хамгийн эхэнд ярьсан тооцоо гэж байдаг. Тооцоог олон өнцгөөс хардаг. Хүн нийгмийг үнэлдэг. Уулын мухарт сууж буй малчин зөвхөн тэр хавийгаа л дурандаж харна. Мал нь алга болчихвол дараагийн довон дээр очоод харна. Байхгүй бол буцаад ирнэ. Сансар дээрээс бол хүн өөр юм харна. Хаана хуй салхи ирж байна. Монголд аадар бороо ороод үер болох юм байна гэх мэт. Тэрийг бол өөр хүн харахгүй.

Өвөг дээдсийнхээ ачаар монголчууд газар доороо арвин баялагтай үлджээ. Энэ чинь маргаашийн өөх. Гэтэл "Рио Тинто" гэх мөнгөтэй компани орж ирээд "Би мөнгийг нь олоод газрын дорх зэсийг гаргаад ирье. Борлуулалт хийсний дараа танай улс мөнгөний талыг манайд өгөх үү" л гэдэг асуудал яригдаад байна л даа. Манайхаас бол нэг ч төгрөг гараагүй. Эсвэл 500 жил хүлээе. Үр хүүхдүүддээ үлдээе гэж ярьдаг ч хүмүүс байдаг. Тэгээд өөрсдөө гүйлгачин царайлаад сууж л байж гэж байгаа бололтой. Талууд энэ асуудал дээр наймаалцсан л хэрэг шүү дээ. 50:50, 70:30 байх үү гээд л ярилцана. Гэхдээ эцсийн дүндээ өнөөдрийн зах зээл дээрх зэс, шатахууны үнэ зэрэг олон талын асуудлыг тооцохоор 53 хувийн өгөөж нь Монголд ирэхээр боллоо. Хөрөнгө оруулагч тал мөнгөө гаргасны хувьд 47 хувиа авч байна. Улс төрийн хувьд тохирлоо. Гэтэл арай бага гэж юу яриад байгаа юм бэ.

**Б.Б:** Мөнгөний өнөөдрийн үнэ цэнэ "Time value of money" гэх ойлголт

байдаг. Тэр тухай л бид яриад байгаа юм. Зах зээл, бизнест маш чухал ойлголт. Өнөөдрийн нэг төгрөг маргаашийн нэг төгрөгөөс илүү үнэтэй. Тэр нэг төгрөгийг л олж авах нь чухал гэдэг ойлголт. Оюутолгой татвар төлсөөр байгаа. Өнөөдрийг хүртэл 1.3 тэрбум долларын төрөл бүрийн татвар Монголд төлжээ. Үүн дээр Оюутолгойгоос цалин авдаг хүмүүсийн төлдөг шимтгэл бүх юмыг нэмбэл бүр их тоо гарна. Засгийн газар тийм хэмжээний их орлогыг сүүлийн таван жилийн хугацаанд Оюутолгойгоос авсан байна.

Тэгвэл Оюутолгой ирээдүйд бидэнд юу өгөх вэ. Тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлдөг болно. Аливаа компани ашигтай ажиллаад ирэхээр энэ татварыг төлж эхэлдэг. Өнөөдрийн үнэ цэнээр 15, 16 тэрбумын хэмжээтэй татварыг төлөх нь. Роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 8-10 тэрбум долларыг Оюутолгойгоос авна. Мөн компанийн эзэн учраас ногдол ашгаас бас авна. 8-10 тэрбум ам.долларын ашиг манайд өгнө. За тэгээд бусад төрлийн олон татвар байгаа.

Оюутолгой өөрөө бизнес учраас бусад бизнестэй адил хөрөнгө мөнгөө босгоод явж байгаа компани. Хөрөнгө оруулсан буюу хувьцаа эзэмшигч нь бусад бизнесийн эзэдтэй адилхан эрсдэлийг үүрч байгаа. Зэсийн үнэ унаж, Оюутолгой ашиггүй ажиллаад байвал энэ бизнес ашиггүй байна. Өнөөдөр "Оюутолгой" компани борлуулалт хийж эхлээд хоёрхон жил болж байгааг бид мэднэ.

**-Оюутолгойг бизнес гэж та хоёр дахин давтаж хэлээд байгаа. Тэгвэл Оюутолгойг улс төр гэж хардаг хүмүүс бас байна шүү дээ?**

**Да.Г:** Бүх юм улс төр юм аа. Эхнэр, нөхрийн хоорондын харилцаа ч улс төр. Гэр бүлийн хуулиар зохицуулдаг. Аль өнцгөөс хараад байгаагаас хамаарна. Улс төр гэдэг зарим хүний оноо цуглуулдаг ярианы сэдэв. Тэр зүйл удахгүй өнгөрчихдөг юм. Яагаад гэвэл тэр хүмүүсийн ярианы сэдэв мундахгүй. 2016 оны сонгуулийн яг маргаашнаас



Оюутолгойг ярих хүн бараг байхгүй болно. Харин УИХ-ын сонгууль дуусах сүүлийн өдөр хүртэл Оюутолгой бол хамгийн чухал сэдвүүдийн нэг байсаар байх болно.

**-УИХ-ын зарим гишүүн болон эвсэл Оюутолгойн гүний уурхайн төлөвлөгөөний тодорхой заалтуудыг үгүйсгэсэн. Энэ тал дээр ямар нэг үндэслэлтэй хариу байна уу?**

**Да.Г:** Улс төр талаас нь энэ хүмүүс яагаад ингэж яриад байгааг би ойлгож байна. Миний хувьд илэрхий утгагүй юм ярилаа гэж хэлмээргүй байна. Жишээлбэл, дөрвөлжин үү, хар уу гээд хэлээд байх юм бол би хэлбэрийг нь дөрвөлжин гэж маргана, нөгөөх нь хар өнгөтэй хэмээн өөр өнцгөөс өөр юм яриад явна. Зарим хүний ярьж буй зүйлүүд дотор зөв юм бий. Бүх юм нь ашигтай юу гэж. Үгүй. Нэгэнтээ дан ганц Монгол Улс өөрөө хөрөнгөө гаргаад зэсээ олборлож чадахгүйгээс хойш хүртэж болох ашгийнхаа тодорхой хэсгийг нөгөө талд өгч л таарна. Нөгөө тал мөнгөө зараад манай газар дорх баялгийг маань гаргаад өгье гэж байна. Тэгэхээр нөгөө талын авах зүйлсийн араас "Миний хоолыг идчихлээ" гээд уйлаад байж боломгүй. Маргаж болно. Зарим улс төрийн шийдвэрийн үр дүн удаан хугацааны дараа мэдэгддэг. Дэлхийн хоёрдугаар

дайд ОХУ хорин хэдэн сая хүнээ үхүүлэн байж өнөөдрийн том гүрнийг аваад үлдэж, дэлхийн лидер улс болоод явж байна. Шүүмжлэе гэвэл олон асуудал байгаа. Юу ч ярьж болно. Гэхдээ ямар нэг юмыг өгч байж нөгөөг авдаг. Бид Оюутолгойн гэрээг цааш нь үргэлжлүүлээд явбал Монгол Улсын эдийн засгийг аварч байна гэж үзэж байгаа.

**Б.Б:** 2009 онд Хөрөнгө оруулалтын гэрээг УИХ-аар хэлэлцэж баталсан. Зах зээлээс хөрөнгө оруулалт татах том нөхцөл бүрдсэн. Үр дүнд нь манай эдийн засаг өссөн. 17 хувийн өсөлттэй эдийн засаг өнөөдөр дөрвөн хувьд уналаа. Гэрээг сөрөг талаас нь хардаг хүмүүс бий.

Гэхдээ сайныг нь өнөөдөр хараад, өгөөжийг нь хүртээд явж байна. Хөрөнгө оруулалтын гэрээг бид дэлхий нийтэд зарлачихсан шүү дээ. “Энэ компаниудтай бид гэрээ байгууллаа, Монголд итгээрэй” гэж. Үүний үр дүнд наад захын жишээ “Чингис бонд”-ыг босгож чадсан. Яагаад том төслүүд дээр олон улсын компаниуд орж ирэх нь зөв бэ гэхээр мэргэжлийн хөрөнгө оруулалтын болоод уул уурхай, эрчим хүчний том компаниуд энэ бизнесийн эрсдэлийг хамгийн сайн ойлгодог. Эрсдэлийг ойлгож байгаа учраас хамгийн хямд зардалтайгаар уг бизнесийн үйл ажиллагааг явуулж чадах хүмүүс.

Тэр хүмүүстэй хамтраад явбал хэдэн жилийн дараа бид нэг км-ийн доор, 200 гаруй км-ийн туннелүүдийг барьж байгуулна. Тэндээсээ олборлолт хийгээд явах энэ бүх процессыг Монгол хүн ашиглаад сурчихна. 20 жилийн дараа “Эрдэнэс Монгол” компани “Рио Тинто”-той адил өөр газар уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт хийх боломжтой болж байгаа юм. Чадавхи, хөрөнгөтэй болчихно гэсэн үг.

### **Манай команд хоёр фронтоор байлдаж байсан**

**-Талууд харилцан буултууд хийсэн. Монголын тал арай илүү буулт хийчихэж гэсэн шүүмж гараад байгаа. Ямар буултууд хийсэн юм бэ?**

**Б.Б:** Монголын тал хоёр жилийн өмнө хөрөнгө оруулалтын гэрээгээ өөрчилж гэдэг байр суурьтай байсан.

Харин өнөөдөр бид зарчмын байр сууринд хүрсэн. Хөрөнгө оруулалтын гэрээ нь маш чухал зүйл юм байна. Үүнийгээ дагаж мөрдье. Монголд Оюутолгой баригдчихсан байна. Ил уурхай, баяжуулах үйлдвэр нь ашиглалтад орчихсон, олон монгол хүнийг ажиллуулаад явж байна. Өмнө нь барилгын үйл явцад олон хүн ажиллаж байсан. Энэ бол батлагдсан хэрэгсэл байгаа юм. Үүнийгээ цаашид төслийнхээ үргэлжлэх хугацаанд бариад явна гэх зарчмын байр суурь дээр бид зогссон. Хэлэлцээр амжилттай болсны үр дүнд өнөөдөр төлөвлөгөө гэдэг баримт бичгээ тохирч чадсан. Цааш явах дүрмээ маш тодорхой болгоо гэсэн үг.

Хөрөнгө оруулалтын гэрээ дээр хоёр утгатай ойлгож байсан заалтуудаар нэг мөр ойлголцож чадсан. Талууд нэлээд зарчимч байр сууринаас хандсан гэдгийг хэлмээр байна. Монгол Улсад хэрэгжиж байгаа бүх хууль, мөн гэрээгээ дагаж мөрдөх байр сууринаас хандсан учраас бид хэл амгүй ойлголцсон. Тэгэхээр хөрөнгө оруулалтын гэрээ бол хүчин төгөлдөр. 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн газар, хувь нийлүүлэгчдийн гэрээг “Эрдэнэс Монгол” ХХК, “Туркойз Хилл Ресурс” компанитай байгуулсан.

Мөн бүтээн байгуулалтын дараагийн ажилд ийм дүрмээр оролцоно гэдгээ маш тодорхой болгож өгсөн. Жишээлбэл, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой зардлуудыг хасч тооцох гэдэг байр суурьтай байсан бол Монголд өнөөдөр байгаа бүх жишгийн дагуу зардлуудыг хасахгүйгээр мөрдөхөөр болсон.

Түүнчлэн ВНР ком-панийн хоёр хувийн роялти татварыг шийдвэрлэсэн. Оюутолгойн хувьд маш өндөр энэ зардлыг байхгүй болгосон. Мөн татварын маргаантай асуудлуудыг цэгцэлж, төсөвт Оюутолгой компани 40 гаруй сая долларыг өнөөдрийн байдлаар нөхөөд төлчихсөн байгаа. Мөн 30 сая долларын татварын маргаан олон улсын арбитрын шүүх рүү очихоор байсан. Бид зарчмаа, хөрөнгө оруулалтын гэрээгээ барьж хэлэлцээр хийсний дүнд энэ татварын актыг хүлээн зөвшөөрөөд төлсөн.

Одоо бидний гол анхаарах ёстой зүйл бол хийх ажил. 4.2 тэрбум

ам.долларын дэлхийн хамгийн том уул уурхайн зээлийн багцыг Монголдоо татах боломжтой болсон. Үүнд “Рио Тинто” баталгаа гаргасан тул “Оюу Толгой” компани өөрийн санхүүжилтын өртгийг багасгаж өгч байгаа юм. Хоёр орчим хувиар багасгах нөхцлийг бүрдүүлсэн. Ингэснээр компани илүү ашигтай ажиллана. Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил явна. Бидний хариуцлага энэ бүх ажлыг дуусгасны дараа “Оюу Толгой” ХХК өөрөө ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх явдал.

**-Гүний уурхайн аюулгүй байдал хамгаас чухалд тооцогддог. Монголд гүний уурхайг ашиглах хууль эрх зүйн орчин бүрдсэн үү?**

**Б.Б:** Дэлхийн шилдэг уурхайг Ханбогдод бий болгох гэж байна. Хамгийн орчин үеийн, дэвшилтэт техно-логи ашиглана. Уурхайн аюулгүй байдал нэгдүгээрт тавигддаг. Бид их ашиг, том тоонууд яриад байгаа. Нөгөө талдаа энэ чинь хүний амьтай зүйрлэх юм биш. Аюулгүй байдлыг чанга мөрдөх бүх стандартыг мөрдөж ажиллах асуудал их чухал. Оюутолгойгоор Монголын бизнест ирж буй бас нэг шууд бус өгөөж нь Монгол компаниуд өнөөдөр аюулгүй байдалд анхаарлаа ихэд хандуулж эхэлж байна.

**Да.Г:** Эрдэнэтийн үйлдвэртэй гэрээ байгуулахад хамгийн том заалт нь аюулгүй ажиллагаа байсан. Техник, технологийн хувьд өөр л дөө. Нэг нь ил, нөгөө нь гүний уурхай. Гэхдээ Оюутолгойгоос сурах юм нь аюулгүй ажиллагаа. Аюулгүй ажиллагаа, машин техник гэдэг нэг хэрэг. Ямар ч хүнгүй техник байсан ч тэртээ тэргүй цаана нь заавал хүний оролцоо байж л таараа. Хүн шатаахууныг нь хийнэ, тогийг нь залгана. Хүн заавал оролцоно. Зуун хувь роботын нийгэм хол байна. Хэвшиж чадаагүй олон зүйлийг “Рио Тинто” Монголд сургаж байгаа.

Нэг ажилтан нь хуруугаа юмаар цохихиход гадны компанид бөөн асуудал болдог. Гэтэл манай ямар ч байгууллага тэрийг осол боллоо гэж бүртгэхгүй, анзаарахгүй. Алив зүйл багаас эхэлдэг юм байна. Энэ бол аюулгүй ажиллагааны талаас соёл. Байгаа юмаа хэвшүүлэх нь том соёл юм байна. Үүнийг манайхан удахгүй ойлгож, мөрддөг болно.



Зүүн гар талаас "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан,  
"Эрдэнэс Оюутолгой" ХХК-ийн гүйцэтгэх захирал Да.Ганболд

**-Төрийн өмчит компаниудын хариуцлагыг сайжруулах, хувийн компани шиг ажиллуулах асуудлыг сүүлийн үед нэлээд ярьж байна. Сингапурын Темасекийн туршлагыг Монголд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Хэзээ үр дүн гарах бол?**

**Б.Б:** Темасекийн загвар маш энгийн. Ерөөсөө л Темасек бол компани шиг үйл ажиллагаагаа явуулдаг. Хөрөнгө оруулалтын компани ямар байх ёстой вэ, түүний дагуу л ажилладаг. Ямар нэг илүү, дутуу давуу эрх эдэлдэггүй. Бизнесийн гол зорилго нь эзэндээ ашиг хүртээх. Бизнесийн ашгийг зөвхөн ногдол ашгаар хэмждэг дутуу ойлголт байна. Энэ бол эзэндээ өгч буй ашгийн нэг л хэлбэр. Компани өөрөө том байж баланс нь том байна. Жишээлбэл, тухайн компанийг зарахад ашиг нь гараад ирнэ.

Дахиад хэлэхэд бизнес өөрөө тогтмол мөнгөн урсгалтай байх нь хамгийн чухал. Мөн тухайн компани үр ашигтай менежмент явуулбал тэр компанийн үнэ цэнэ зах зээл дээр үнэлдэг аргачлалын дагуу нэмэгдэнэ. Тийм учраас бизнес шиг бизнес байхыг зорьж байгаа. Түүнийг зохицуулдаг эрх зүйн орчин бүрдсэн. Тэр нь Компанийн тухай хууль.

Ер нь хөрөнгө оруулалт буюу эзэн байна гэдэг нь огт эрсдэлгүй зүйл биш. Эзэн бол тэр эрсдэлийг байнгын үүрээд явдаг. Энэ утгаар бид Оюутолгойд эзэн шиг нь ханддаг байх тэр зам рүү эргээд гарчихлаа. Хүний юм гэж хэсэг

ярьсан. Хараад байсан чинь өөрийн юм байсныг ойлгосон.

**-Оюутолгойн хэлэлцээрийг олон сарын хугацаанд хийсэн. Халширмаар хэцүү үе байсан уу?**

**Б.Б:** Хоёр эзэн хоорондоо асуудлуудаа тохиролцохоор ажиллаж буй бизнесийн процесс шүү дээ. Гол нь цээжний пангаар биш, тооцоо, судалгаа, санхүүгийн загвар зэрэг бүгдийг хийж, хууль болоод гэрээгээ урдаа тавьж байгаад л хэлэлцээрийг үргэлжлүүлсэн. Улс орныхоо хувь заяаны асуудлыг ярьж байгаа болохоор цаг наргүй ажилласан. Гэр бүлийнхэнд маань л хүнд байсан байх. Оройтлоо, ажил дээрээ хонолоо гэж гэр бүлийнхэн маань жаахан уурласан байх даа.

**Да.Г:** Лондонгийн цагийн зөрүүнээс шалтгаалан бид ажилласаар өглөөний 05.00 цагт гэртээ орох тохиолдол олон байсан.

Ерөнхий томъёоллыг нь зөв олоод хэлчих ёстой байх. Зөвхөн "Рио Тинто," "Түркоиз Хилл Ресурс" гэхээс гадна манайхнаас хамаатай зүйлүүд ч байсан. Хүнд суртал, өөр дээрээ хариуцлага хүлээж авахаасаа айх, зугтах зайлсхийх гэх мэт. Зарим түргэн шийдэх боломжтой асуудлуудыг цаг тухайд нь шийдэж өгөхгүйгээс болоод асуудал хойшлогдож байсан. Нэг ёсондоо манай команд хоёр фронтоор байлдаж байсан гэсэн үг. Нөгөө талтай, эргээд өөрийнхөнтэйгээ бас хэл амаа ойлголцоход цаг зарсан. Яах вэ бүрэн ойлгох цаг нь ирнэ. Гэхдээ энэ нь нэг

талын амьдрал, нөгөөтэйгүүр ажилд их садаа болдог.

**-Гүний уурхайн бүтээн байгуулалт хэр удаан үргэлжилж, олборлолт нь эхлэх вэ?**

**Б.Б:** Барилга, угсралтын ажил 6-7 жил үргэлжилнэ. Энэ нь Оюутолгойн орлого нэмэгдэх цагийг л хүлээж байгаа юм. Гэхдээ энэ хугацаанд бас огт олборлохгүй гэсэн үг бас биш.

**Да.Г:**Туннел барих явцад олборлолт хийгдэж л байна. Учир нь туннел орд дотроо баригдах учраас замд таарсан баяжмалуудаа олборлож, боловсруулна. Гэхдээ энэ нь үндсэн олборлолт биш. Тэргүүн зорилго нь туннел ухах. Мэдээж хэрэг олон зуун километрийг 20,30 жил ч ухах байх. Ямар ч байсан эхний 5-7 жилийн дотор жигд олборлолт эхэлнэ.

**Б.Б:** Гүний уурхайн гол онцлог нь зардал багасч байгаа. Яагаад гэхээр хүдэрт байгаа зэсийн агууламж нэмэгдэнэ. Энэ нь хаягдал шороо нь бага гарч, Оюутолгойн бүтээгдэхүүн үнэтэй болж байна гэсэн үг. Гүний уурхай дахь хүдрийн агууламж ил уурхайгаас хоёр дахин их юм.

**-Зардлын хэтрэлттэй холбоотой нэг асуулт байна. 1.2 тэрбум ам.долларын зардлын хэтрэлтийг хүлээн зөвшөөрсөн. Энэ тоог зүгээр санаанаасаа бичихээгүй болов уу. Ямар хэлэлцээ хийгдэж энэ дүнд хүрсэн бэ?**

**Да.Г:** Улс төрд хэрэгтэй сэдэв л дээ. Эдийн засагт бол хоёр өнцөгтэй асуудал. Өртгийн хэтрэлт ямар ч тохиолдолд муу. Таван саяын үнэтэй барааг авах гэтэл 10 сая болчихвол ашиггүй. Харин эргүүлээд 15 саяар зарчихвал ашигтай болно. Өнөөдрийн уушиг уу, маргаашийн өөх үү гэдгийг би өнөөдөр мэдэхгүй. Бодитой юу, үгүй юу гэдгийг түүх, цаг хугацаа харуулдаг. Өнөөдөр жишээлбэл, монголчууд ихэнх машин техникээ Японоос авч байна. Нэг ч эд ангийг нь Монголд хийдэггүй. Дэлхийн дундаж жишиг үнээр л авч байгаа. Тэр үнээрээ Монголын тайланд бүртгэгдэнэ. Тайланд тусгагдсан үнээрээ л хөрөнгийн баталгаа болно. Өнөөдрийн уушиг гэж харвал энэ нь муу мэдээ. Яваандаа үнэ хүрнэ, ажил нь өргөжинө, илүү их бүтээмж, ашиг авч ирнэ гэж харвал хэтрүүлсэн үү, хассан үү гэдэг нь хэнд ч сонин биш.

**Б.Б:** Монголын талын эзэмшдэг

34 хувийг бид 2010 онд зээл аваад санхүүжүүлсэн. Энэ тоо өөрчлөгдөхгүй. Зардал хэтэрлээ гээд бид нэмж зээлээгүй. Ахиад хоёр дахь шатны хөрөнгө оруулалтыг томоохон банкуудаас зээлж байгаа. Сая баталсан төлөвлөгөө дээр Монголын талын эзэмших 34 хувиа хадгалж үлдэнэ гэдгийг маш тодорхой болгосон. Цаашид “Оюу Толгой” ХХК ямар ч зээл авсан энэ тоо өөрчлөгдөхгүй.

**-Монголын бизнесийнхэнд Оюу-толгойн ханган нийлүүлэгч болж, ямар нэг байдлаар тус компанитай хамтран ажиллах хүсэл, хүлээлт бий болсон байгаа. Гүний уурхайн бүтээн байгуулалтыг дагаад ямар төрлийн бизнесийн боломж нээгдэх бол?**

**Да.Г:** Түмэн бизнесийн боломж нээгдэнэ. Монголд дангаараа хөрөнгө босгож том үйлдвэрлэл эхлүүлэх, явуулах чадвартай компани байхгүй. Заавал хэн нэгэнтэй хамтрах хэрэг гардаг. Оюутолгой төсөл явах эсэх нь тодорхойгүй үед азнасан, хүлээсэн олон төсөл байгаа. Надад байгаа мэдээгээр 30 жил ажилласан “Эрдэнэт үйлдвэрийн бараа, ажил үйлчилгээг аваад үзэхэд 30 гаруй мянган бизнесийн боломжууд байдаг. Тэгвэл Оюутолгойг хамгийн муугаар бодоход үүнээс дутахгүй. Өнөөдөр Оюутолгойд ханган нийлүүлэгч компаниудын жагсаалт гэхэд хэдэн мянга давсан. Үүнээс 500 гаруй нь монгол компани байна.

**Б.Б:** Сүүлийн хоёр жилд дотоодын ханган нийлүүлэгч буюу монгол компаниуд бараг тэрбум орчим долларын боломжоо алдсан. Одоо эргээд боломжууд нээгдэж байна.

**- Бид зуун жилийн настай төслийн тухай ярьж байна. Зуун жилийн дараах Монгол Улсыг төсөөлж үзсэн үү. Ямар байх бол?**

**Да.Г:** Ойрын энгийн жишээг ярихад 20 жилийн өмнө малчид малаа оторлуулж яваад дэлхийн өнцөг булан бүрт гар утсаараа холбоо барьдаг болно гэхэд “Мөн залж байна даа” гэдэг байсан. Төсөөлөхийн аргагүй байсан шүү дээ.

**Б.Б:** Таван жилийн дараахийг л ярья. Манай эдийн засгийг хурдтай өсөх боломжтой гэцгээж байна. Манай дэд бүтцийн хөгжил олон улсад хол хаягдсан, өрсөлдөх чадвар ямар байгааг бид мэднэ. Өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

Түүнийг дагаад дэд бүтцийн салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалтууд орж эхэлнэ.

Том төслүүдээ явуулчихвал жилд 15 орчим хувийн өсөлт байх болов уу гэж төсөөлж байна. Арав, тав, гурав, нэг жилээр бизнесээ төлөвлөдөг ерөнхий зарчим бий. Үүний дагуу жилд 10-15 хувийн өсөлттэй байна гэж бодохоор эдийн засгийн багтаамж өнөөдрийнхөөс хоёр дахин, сайнаар бодоход гурав дахин нэмэгдэх боломжтой. Тэгэхээр өнөөдрийн 10 тэрбум ам.долларын эдийн засагт байгаа зовлон өөр асуудлуудаар солигдоно. Гэхдээ тэр үед хүн бүр аюулгүйн бүсээ зүүдэг, гэрээ хэлцлээ хариуцлагатай хийдэг, хүлээсэн үүргээ биелүүлдэг болно. Бидний засгаас хүлээдэг зүйл бол хууль бүх хүнд шударгаар үйлчилдэг байх. Таван жилийн дараахыг мэргэжлийн талаас нь, хувь хүн талаас харсан ч нэлээд их өөрчлөлт гарах байх.

**Да.Г:** Жаахан цаашлаад 10 жил гэж ярья. Төв аймаг, Улаанбаатартай нийлчих болов уу. Хөшигийн хөндий Налайх, Багануураас дутахгүй том дүүрэг болчихсон байна. Цэвэрлэх станц баригдаад одоогийн зовлонгоосоо сална. Багануур дүүрэг нэлээд томорч, Ханбогд 20 гаруй мянган хүн амтай хот суурин болчих байх. Хар зам дутуу орсон аймгууд сайн чанарын засмал замаар Улаанбаатартай холбогдохно. Сургууль завсардалт үгүй болно. Гадагшаа явж эмчлүүлдэг хүмүүсийн тоо эрс буурч, өнөөдөр үнэтэй эмнэлгүүд хэвийнд тооцогдоно. Дээд сургуулиудын чанар сайжирч, иргэд дотооддоо нэр хүндтэй сургуульд сурах сонирхолтой болно гэж харж байна.

**-“Оюу Толгой” ХХК-д “Рио Тинто”, “Эрдэнэс Монгол” гэсэн хоёр үндсэн эзэн бий. Гүйцэтгэх захиралаар монгол хүн томилогдох цаг ирэх болов уу?**

**Да.Г:** Урьдчилан таамаглахад хэцүү. Боломжтой зүйл. Гэхдээ хоёр хувилбар байна. Эхнийх нь Монголын Засгийн газрын мандаттай хүн томилогдох магадлал ойрын жилүүдэд байхгүй болов уу. Хоёр дахь нь монгол, монгол угсааны, монгол цустай ч юм уу хүн томилогдох магадлал харин илүү өндөр байх. “Оюу Толгойн” ТУЗ-ийн дарга нь монгол хүн ажилладаг. ЕР НЬ компанийн хувьцааны олонхийг эзэмшиж байгаа нь л захирлыг томилдог зарчим үйлчлээд

явах байх аа.

**Б.Б:** Бизнесийг хамгийн их хувьцаа эзэмшигч нь удирдах үүрэг хүлээж, хүнээ томилдог. Хэнийг томилох вэ гэдэг тэр талын л мэдэх хэрэг. Шалгуурыг нь хангавал боломж өнөөдөр ч байгаа. Ер нь дэлхийн хэмжээний том уурхайг удирдах чадавхийг бүрэлдүүлж, туршлага хуримтлуулж яваа, бид.

**-Гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд Дубайд гарын үсэг зурсан нь бас л сэдэв боллоо. Монголдоо зурж болоогүй юм уу?**

**Д.Г:** Бидний хэлэлцээр зөвхөн Улаанбаатарт болоод байгаагүй юм аа. Лондон, Сингапур гээд өөр газруудад үргэлжилсэн. Ер нь монголчууд бид хорин нэгдүгээр зуунд амьдарч байна. Цаг үе өөр болсон. Мэдээлэл, технологийн хөгжил маш эрчимтэй, танигдахын аргагүй хөгжиж байна. Глобачлал, даяаршлал бол зөвхөн хүн хоорондын харилцаа биш болжээ.

Зарим улстөрч Дубайд очоод ямар нэгэн юмыг нууж, зориуд бултаж байгаад Оюутолгойн гэрээг зурчихлаа гэж хардаад байх шиг. Хэрэв нууцаар гэрээ байгуулья гэвэл заавал Дубай явах шаардлагагүй. Улаанбаатарын хаа нэгтээ нууц гэрээ байгуулчихаж болно. Нэгэнтээ техник, технологийн эрин зуунд амьдарч буйн хувьд ялангуяа цаасан дээр бууж байгаа баримт бичиг, гэрээнүүд, бизнесийн хэлэлцээрүүд хаана ч хийгддэг болсон цаг.

Нэгдүгээрт, Лондон-Улаанбаатарын хооронд дундын орон зайг ашиглаж, хоёрдугаарт, гадаадад хүрэх мессэжийг зөв, хурдан шуурхай өгөх үүднээс Ерөнхий сайдын айлчлалыг тохиолдуулан Дубайд Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөг баталсан юм. Эндээс явахдаа зурна гэсэн төлөвлөгөө байгаагүй. Хэрэв зарчмын гол, гол асуудлаа хөрөнгө оруулагчтай тохирч чадвал зурж болох юм гэсэн бодолтой явсан.

Дубайн хэлэлцээний үеэр талууд үлдсэн асуудал дээрээ ярьж тохирсон учраас монголчуудын хэлдгээр “ямааны мах халуун дээрээ” гээд төлөвлөгөөнд гарын үсгээ зурсан. Тэр даруйдаа олон нийтэд мэдээлсэн. Энэ бол олон улсын стандарт. Түүнээс нууж хаагаад байсан асуудал байхгүй. ■



MONGOLIA  
BUSINESS  
SUMMIT 2015

## БИЗНЕСИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ 2015

2015 ОНЫ 6 ДУГААР САРЫН 18-20, ИХ ТЭНГЭР ЦОГЦОЛБОР, УЛААНБААТАР

“Бизнесийн дээд хэмжээний уулзалт”-ын гол зорилго нь дотоодын компаниуд болон бусад бизнесийн боломжуудыг гадны хөрөнгө оруулагчдад танилцуулах, түншлэл тогтоох явдал юм.



### Хөтөлбөрт:

- ✓ Бизнесийн зохицуулалт
- ✓ Дэд бүтцийн төслүүд
- ✓ Хөрөнгийн зах зээл
- ✓ Салбаруудын мэдээлэл



### Бусад боломж:

- ✓ 400 гаруй удирдах төвшний мэргэжилтнүүд
- ✓ 20+ төслүүдийн танилцуулга
- ✓ Танилцах аяллууд



Цахим бүртгэл: <http://bizsummit.mn/registration/>

## Ерөнхий сайдын

Онцлох  
20  
ЭШЛЭЛ

Ерөнхий сайд Ч.Сайханбилэг АНЭУ-д айлчлал хийгээд ирснийхээ дараа

**1** Өнөөдрөөс эхлээд Оюутолгой, Засгийн газрын ч, улс төрийн ч асуудал биш болсон. Өнөөдрөөс эхлээд эдийн засгийн, компани хоорондын асуудал боллоо.

**2.** Эх орноо боддог л юм бол улстөрчид Оюутолгойн асуудалд хутгалдах шаардлагагүй.

**3.** Одоо Оюутолгойг зүгээр л орхих хэрэгтэй. Эрдэнэт үйлдвэртэй адилхан цаашаа өөрөө үргэлжлээд ажиллах болсон.

**4.** Бүх зардлыг Монголын тал хянах боломжтой болсон. Хоёр талаасаа хоёр, хоёр хүн гаргаад, Монголын

талын хүн ахлаад цаашид Оюутолгойд хийх бүх зардалд Монголын Засгийн газар хяналтаа тавих боломжтой болсон явдал юм.

**5** Өмнө нь хоёр тал янз бүрийн тоо ярьдаг байсан. Одоо бол хоёр талын тооцсон тоонууд нэгдсэн нэг тоон дээр очсон. Энэ дагуу тооцоход түрүүний 53:47 гэдэг харьцаа өөрчлөгдөж Монголын талд 54.9 хувь болохоор бүх тохиролцоогоо хийсэн.

**6.** 2009 оны гэрээгээр Монголын талд үүнээс илүү ашигтай байх нөхцөлгүй гэдгийг шууд хэлэх хэрэгтэй байх.

тэрбум ам.долларын асуудлыг шийдэж чадлаа.

Эцэст нь нэг зүйлийг ойлгоцгооё.

**10** Энэ бол УИХ гишүүдэд ч юмуу, улстөрчдөд ч юмуу хамаатай асуудал бишээ. Энэ бол цэвэр эдийн засгийн, бизнесийн харилцаа, компани хоорондын асуудлууд. Бид том төсөл, бүтээн байгуулалтаа бүгдийг нь ингэж улстөржүүлж явах юм бол хэзээ ч тамын тогооноосоо гарахгүй.

**11.** Оюутолгойн гүний уурхайн ажил явна гэсэн мэдээллийн дараа эдийн засагт ямар зэрэг өөрчлөлтүүд

гарч байгааг хэлье. Манай Засгийн газрын бондын хүү "Чингис бонд"-ын хүү рүү дөхөж очсон. Өнөөдөр дөрвөн хувь руу ороод ирлээ. ХХБ-ны гаргасан бонд ес гаруй хувиас долоон хувь руу буурлаа. Ам.долларын ханш 1920 төгрөг рүү орлоо. Бид үүнийг л хүсч байсан.

**12** Ер нь Монголын талын хүртэх ашиг 54.9 хувь байна гэдэг нь дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ 5000 ам.доллар руу буусан ч доош хэлбэлзэж унахгүй байх ашгийн хэмжээ юм. Хэрвээ дэлхийн зах зээлд зэсийн үнэ өсч 7000 ам.долларт хүрвэл Монголын

**7** Оюутолгойн гэрээ манай гадаадын хөрөнгө оруулалтыг яаж хааж, боож байсан, Монголын талаар ямар буруу сэтгэгдэл төрүүлж байсныг одоо хар. Тиймээс Оюутолгой хөдөлснөөр Монгол Улс л хожино.

**8.** Хувь улстөрч өөртөө оноо цуглуулах гэсэн ажлаа Монгол орны хувь заяаг шийдэхээс дээр тавьдгаа больё. Бүгдээрээ ажлаа хийх цаг болсон.

**9.** Тавхан өдрийн дотор Энэтхэгийн нэг тэрбум зээлээр, Оюутолгойн нэг тэрбум хөрөнгө оруулалтаар, АНЭУЛсаас хөрөнгө оруулалтын сангаар дамжуулж нэг тэрбум ам.доллар, ингээд найман

талын хүртэх ашиг 56.1 хувь болж өснө. Өнөөдөр бид татвараа аваад үр ашгаа хүртээд явж байгаа, үүнийг үгүйсгээгүй шүү.

Сүүлийн 2-3 жил бид эдийн засгаа хэтэрхий борцоллоо.

**13** **14.** Оюутолгойгоос авах роялти татвар Монголынхоо хуулиар таван хувь хэвээрээ байна.

**15.** Монголын Засгийн газарт 1.3 тэрбум ам.долларын татвар өгчихөөд өөрсдөө хасахтай сууж байгаа шүү дээ гэдгээ тэд хэлсэн.

**16** Төлөвлөгөөг баталсан цагаас эхэлж талууд нэг завинд суусан хамтрагч болсон тул хэн хэнийгээ дэмжиж ажилля гэсэн. Тэд ч хүлээн зөвшөөрсөн.

**17.** Олон улсын нэр хүнд бүхий 14 банк, санхүүгийн байгууллагаас хамгийн багаар бодоход 4.2 тэрбум, нийтдээ зургаан тэрбум ам. долларын санхүүжилтийг татах болно.

Төслийн санхүүжилтээр хийх бүтээн

**18** байгуулалтын ажлын хүрээнд жил бүр дунджаар 1.2 тэрбум ам.доллар, нийт есөн тэрбум ам.долларын нэмэлт өгөөж манай улсын эдийн засагт орно гэж үзэж байна.

**19.** 2015 оны есдүгээр сар гэхэд "Оюу Толгой" компани зэс хайлуулах үйлдвэрийн судалгааг боловсруулах үүрэг хүлээж, Монгол Улс өөрийн зэс хайлуулах үйлдвэртэй болно.

Манай зарим хэвлэлээр Ерөнхий

**20** сайд Оюутолгойн гэрээнд гарын үсэг зурлаа гэсэн мэдээлэл цацагдаж байна. Ямар нэгэн гэрээнд гарын үсэг зураагүй. Гүний уурхайг үргэлжлүүлж ажиллуулах төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Хоёрдугаарт, Ерөнхий сайд гарын үсэг зураагүй. Холбогдох байгууллагын дарга нар гарын үсэг зурсан. ■

## Оюутолгой Засгийн газрын ч, улс төрийн ч асуудал биш болсон



Шог зургийг А.Амарсайхан

# Оюутолгой ба татвар

Ц.Сайхан

Гадаадын хөрөнгө оруулалттай зарим компаниуд татварын асуудалд орж, удирдах албан тушаалтнууд нягтлан бодогч нар нь Монгол Улсаас гарах эрхээ хасуулсан тухай мэдээ дэлхий нийтээр тархсан. Үр дүнд нь хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгөтэйгөө буцах болсноор "Hotel Mongolia" гэдэг өргөмжлөл олон улсад Чингис хаан шиг "алдаршаад" байна. Энэ нэршлийн улмаас Монгол Улс хэр сайн түнш вэ гэдэгт гаднын хөрөнгө оруулагчид дүн тавих болжээ. Тэд асуултынхаа хариуг Оюутолгойгоос хайж байгаа. Мега төслүүд дээрээ хэрхэн хамтарч байгааг ажиг суугаа. Энэ үед Оюутолгойн 130 сая ам.долларын татварын асуудал гарч ирсэн нь тийм ч сайхан мэдээ байгаагүй биз. Тиймээс хоёр дахь шатны хөрөнгө оруулалтыг эхлүүлэхээс өмнө хөрөнгө оруулагчид татварын асуудлаа шийдэх нь аль аль талын сонирхол байлаа.

Өмнө нь "Оюу Толгой" ХХК татвартай холбоотой асуудлууд хөндөгдөж байсан. Эхнийх нь "Оюу Толгой ХХК татвар төлдөггүй" гэх яриа. Гэтэл 2011-2013 онд тус компани Монгол Улсын топ татвар төлөгчдийн жагсаалтын эхний зургаад багтаж ирсэн. Ил уурхай ашиглалтад орж, бүтээгдэхүүний экспорт эхлэн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх болсонтой холбоотойгоор өнгөрсөн онд жагсаалтын гуравдугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Түүнээс гадна 2010-2011 оны хооронд Монголын




Фотог Б.Бямба-Очир

Засгийн газрын хүсэлтээр 250 сая ам.долларыг "Оюу Толгой" компани Засгийн газарт зээлдүүлсэн. Үүнээс 150 сая ам.долларыг татварын урьдчилгаа болгож, ирээдүйд төлөх татвараас суутгахаар тохиролцжээ. Дараагийнх нь давхар татварын гэрээтэй холбоотой. Канад улсад бүртгэлтэй "Айванхоу Майнз" болон "Туркойз Хилл Ресурс" нь охин компани Нидерланд улсад "Turquoise Hill Netherlands Cooperative", "Oyu Tolgoi Netherlands B.V.", "Ivanhoe Mines Aruba Holdings LLC" нэрээр

гэрээг цуцалснаар хуулийн цоорхойг эдгээр компани ашиглаж чадаагүй юм.

"Оюу Толгой" ХХК 2009 оны гэрээнд тусгаснаар тухайн үед мөрдөгдөж байсан бүх татварыг төлөх үүрэгтэй. Үүнээс Аж ахуйн нэгжийн орлогын, Гаалийн, Нэмэгдсэн өртгийн, Онцгой, Ашигт малтмалын нөөц ашигласны /роялти/, Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн, Үл хөдлөх эд хөрөнгийн зэрэг албан татварын хувь хэмжээг тогтворжуулсан буюу өөрчлөгдөхгүй. Харин эдгээрээс



\* Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн экспортод гаргадаггүй Оюу Толгой ХХК-ийн хувьд бэлтгэн нийлүүлэгчдэд болон импортод төлсөн НӨАТ-ыг буцаан авдаггүй.

Оюу Толгой ХХК-ийн татвартай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг [www.ot.mn](http://www.ot.mn), [www.facebook.com/oyutolgoi](http://www.facebook.com/oyutolgoi) хуудсаас үзнэ үү.

бүртгүүлснээр Монгол Улсад татвар төлөлгүй "Оюу Толгой" ХХК-иас ногдол ашиг хүртэх хуулийн цоорхой бий болсон байв. Гэхдээ 2012 онд тус улстай байгуулсан давхар татварын

бусад татварыг үл тогтворжуулсан буюу хувь хэмжээг өөрчилж болно. Гэхдээ гэрээ байгуулснаас хойш бий болсон татварыг төлөхгүй байхаар тохиролцсон байдаг.

Дээр дурьдсан 130 сая ам.долларын 30 саяыг татвар болгон төлөхөөр харилцан шийдсэн юм. Үүний дагуу “Оюу толгой” ХХК дээрх татварыг улсын төсөвт тушаагаад буй. Чухамдаа энэ тоо хэмжээ төлөвлөгөөнд гарын үсэг зурахаас нэлээд урьд тодорхой болсон гэж хэлж болно. Татварын

Тэрбээр “Татварын ерөнхий газар байцагчдаадаа гаргасан шийдвэрээ хамгаалах боломжийг олгохгүй байна” хэмээж байлаа. Асуудал шийдэгдэхгүй олон сарыг үдэж “Рио Тинто” компанийн гүйцэтгэх захирал Сэм Уольш “Шаардлагатай гэж үзвэл арбитрын шүүхэд бид хандана” хэмээн

салбар компани. Гэтэл толгой том компаниуд нь олон улсын зах зээлд мөрддөг нягтлан бодох бүртгэлийн стандартаар санхүүгийн бүртгэлээ хийдэг. Үүнээс үүдэн зөрүүтэй ойлголт бий болж байгаа харагддаг” хэмээн НИТХ-ын гишүүн Ц.Алтанцэцэг хэлсэн юм. Хэрвээ бид аргачлалаа дэлхийнхтэй нийлүүлэхгүй бол цаашид ч гаднын хөрөнгө оруулагчидтай татварын маргаан үргэлжилсээр байх аж. Төлөвлөгөөнд “Оюу Толгой” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн стандартад жилд нэгээс доошгүй удаа монгол компаниар аудитын шалгалт хийлгэж байхаар тусгасан нь анхаарал татаж байгаа гэнэ. Дотоодын аудитын компаниудын хувьд нэр хүндээ өсгөх, туршлага хуримтлуулах сайхан боломж.

Гэхдээ аргачлал нь зөрүүтэй хэвээр цааш явбал хоёр тал стратегийн ордыг ашиглаж дуусах хүртэл хэдэн ч удаа олон улсын арбитрын шүүх дээр уулзах байсан юм билээ. “Рио Тинто”-той тохиролцож чадсан туршлагаа бусад хөрөнгө оруулагчидтай ч хуваалцах хэрэгтэй биз ээ. Компани 2010-2012 онд 1.6 их наяд төгрөг (804 орчим сая ам.доллар)-ийг Засгийн газарт төлжээ. Үүний 437 тэрбум төгрөг нь улс, орон нутгийн төсөвт шууд төлсөн татвар. Үлдсэн нь төрөл бүрийн хураамж, нийгмийн даатгалын шимтгэл, бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн НӨАТ, Засгийн газрын урьдчилгаа төлбөр болон бусад санхүүжилт, шууд бус төлбөр аж. Харин өнгөрсөн онд 300 тэрбум гаруй төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төлсөн байна.

Гүний уурхай ашиглалтад орж, үйл ажиллагаа нь тогтмолжихын хэрээр татвараас олох төсвийн орлого үлэмж нэмэгдэж, улмаар эзэмшил хувисаа хүртэх ногдол ашиг өснө. “Гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд Оюутолгойн ордоос Монголын талын хүртэх өгөөж 54.9 хувь байхыг тохиролцсон тухай Ерөнхий сайд мэдэгдээд байгаа. Хөрөнгө оруулалтын таатай орчин гэдгээрээ дэлхий нийтэд танигдахыг хүсч байгаа манай улсын хувьд татварын маргаануудаа шийдэж чадахгүй байх нь сөрөг үр дагавартай. Тиймээс шийдвэртэй арга хэмжээ авч, тодорхой нэг стандарт мөрдөхөд анхаарах цаг иржээ. ■

#### МОНГОЛ УЛСАД ТӨЛСӨН ТАТВАР, ХУРААМЖ, ТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ

№	Төлбөрийн төрлүүд	/мянган төгрөгөөр/			
		2010	2011	2012 (эхний 8 сард)	Дүн
<b>I</b>	<b>Борлуулалтын орлогод ногдох шууд татвар:</b>				
	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-	-	-
<b>II</b>	<b>Зардалд ногдуулсан татвар, шимтгэл:</b>	<b>31,981,130</b>	<b>246,506,732</b>	<b>143,254,447</b>	<b>421,742,310</b>
	Импортын барааны гаалийн татвар, хураамж	9,217,585	60,847,614	25,694,313	95,759,512
	Импортын барааны НӨАТ*	19,356,929	127,485,177	53,796,506	200,638,612
	Оршин суугч бусын үйлчилгээний НӨАТ*	518,046	50,510,686	49,486,377	100,515,109
	Ажил олгогчийн төлсөн НДШ	2,888,571	7,663,255	14,277,251	24,829,076
<b>III</b>	<b>Бусад татвар, төлбөр, санхүүжилт:</b>	<b>4,252,184</b>	<b>21,856,275</b>	<b>13,763,405</b>	<b>39,871,865</b>
	Тээврийн хэрэгсэлийн татвар	16,794	26,940	45,332	89,066
	Газар, ус, түгээмэл тархацтай а/а-н төлбөр	575,348	2,841,559	3,520,589	6,937,496
	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар	84,359	117,052	87,642	289,052
	Бусад татвар хураамжууд /агаарын бохирдлын г.м/	-	30,507	17,662	48,169
	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамж	272,257	288,601	-	560,858
	Нөхөн сэргээлийн санд төвлөрүүлсэн барьцаа	-	193,445	170,080	363,525
	Гадаад ажиллагсдын зөрүүгийн төлбөр	631,800	6,339,332	992,628	7,963,760
	Гадаад ажиллагсдын зөвшөөрөл, хураамж	1,011,927	3,136,477	1,724,452	5,872,856
	Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн санхүүжилт	1,659,700	8,882,362	7,205,020	17,747,082
<b>IV</b>	<b>Бэлтгэн нийлүүлэгчдээр дамжуулан төлсөн НӨАТ:</b>				
	Дотоодын бараа үйлчилгээ нийлүүлэгчдээр дамжуулан төлсөн НӨАТ*	<b>24,009,405</b>	<b>93,841,075</b>	<b>113,744,960</b>	<b>231,595,440</b>
<b>V</b>	<b>Харилцагч болон ажиллагсаас суутган төлсөн татвар, шимтгэл:</b>	<b>6,058,014</b>	<b>10,202,100</b>	<b>22,220,687</b>	<b>38,480,801</b>
	Оршин суугч бусын үйлчилгээний суутган татвар	3,297,986	3,042,931	5,173,160	11,514,077
	Ажиллагсад ба зөвлөхүүдийн цалингийн ХХОАТ	2,320,863	5,822,424	12,690,418	20,833,705
	Даатгуулагчаас суутгасан НДШ	439,165	1,336,745	4,357,109	6,133,019
<b>VI</b>	<b>Орлогын албан татвар:</b>				
	Хүүгийн орлогод ногдуулсан татвар	431	66,719	68,679	135,829
	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	-	-	-	-
<b>VII</b>	<b>Засгийн Газрын бонд, урьдчилгаа төлбөр:</b>	<b>211,693,500</b>	<b>125,369,000</b>	<b>(10,662,160)</b>	<b>326,400,340</b>
	Бондын төлбөр	143,420,000	-	-	143,420,000
	Урьдчилгаа төлбөр	68,273,500	125,369,000	-	193,642,500
	Урьдчилгаа төлбөрийн суутган тооцоо	-	-	(10,662,160)	(10,662,160)
<b>УЛСАД ТӨЛСӨН ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>		<b>277,994,665</b>	<b>497,841,902</b>	<b>282,390,018</b>	<b>1,058,226,585</b>

#### ТАТВАР, ХУРААМЖ, ТӨЛБӨР ХҮЛЭЭН АВСАН БАЙГУУЛЛАГА

Төлбөр хүлээн авагч байгууллагаар:	2010	2011	2012 (эхний 8 сард)	Дүн
Сангийн Яам	211,693,500	125,369,000	-	337,062,500
Татварын Ерөнхий Газар	3,816,463	53,620,336	44,716,261	102,153,061
Гаалийн Ерөнхий Газар	28,574,514	188,332,791	79,490,819	296,398,125
Нийслэлийн Татварын Газар	761,252	2,603,809	7,090,492	10,455,554
Өмнөговь Аймгийн Татварын Газар	1,660,763	3,393,114	5,100,356	10,154,233
Ханбогд сумын ЗДТ	1,207,148	9,180,891	4,513,217	14,901,256
Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар	272,257	288,601	-	560,858
Нийгмийн Даатгалын Газар / Чингэлтэй дүүрэг/	3,327,736	9,000,000	18,634,359	30,962,095
Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газар	2,671,627	12,018,839	8,929,473	23,619,938
Байгаль Орчны Яам	-	193,445	170,080	363,525
Дотоодын бэлтгэн нийлүүлэгч ААН-үүдээр дамжуулан төлсөн*	24,009,405	93,841,075	113,744,960	231,595,440
<b>УЛСАД ТӨЛСӨН ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>277,994,665</b>	<b>497,841,902</b>	<b>282,390,018</b>	<b>1,058,226,585</b>

ерөнхий газрын дарга Т.Батмагнайн тайлбарласнаар “Оюу Толгой” ХХК Татварын улсын байцаагчийн актыг эс зөвшөөрч гомдол гаргасныг Татварын маргаан таслах зөвлөл өнгөрсөн оны есдүгээр сарын 10-нд хэлэлцээд дүнг бууруулах тогтоол гаргасан аж. Харин УИХ-аас томилогдсон ажлын хэсгийн ахлагч С.Ганбаатар татварын байцаагчдын тавьсан акт хууль эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэн.

татвартай холбоотой асуудлаар үг унагасан. Ийнхүү үл ойлголцол бий болж байгаа шалтгааныг эдийн засагчид тайлбарлахдаа нягтлан бодох бүртгэлийн стандарт, аргачлалын зөрөөтэй байдлаас үүдсэн гэж буй. Манай улсын татварын тайлан бодох аргачлал олон улсынхаас олон талаар ялгаатай. Түүнийг олон улсын жишигт нийцүүлэх цаг болсон гэгцээж байна. “Уул уурхайн компаниудын ихэнх нь



## Мөнгөөр үнэлшгүй үнэ цэнэ



Хөрөнгө оруулалтын үржүүлэх нөлөө гэсэн ойлголт бий. Олон улсад “Investment multiplier” гэж тодорхойлогдоно. Манай улс шиг чөлөөт эдин засагтай орнууд энэхүү аргачлалыг түлхүү хэрэглэх нь бий. Үүний зорилго нь төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын эдийн засаг дахь нөлөөг зөв гаргахад орших аж. Өөрөөр хэлбэл, төр хувийн хэвшилтэй хамтарч төсөл хэрэгжүүлж буй нөхцөлд тухайн төслийн эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өгөөжийг бодитоор гаргаж ирэх.

Манай улсын хувьд ийм төрлийн төсөл тийм ч түгээмэл хэрэгжиж эхлээгүй бөгөөд одоогоор зөвхөн Оюутолгойг нэрлэж болохоор байна. Тавантолгойн төслийн хувьд хэлэлцээрийн шатанд явж буй. Монголчуудад томоохон төслүүдэд хөрөнгө оруулалтын үржүүлэгч нөлөөгөөр хэмжиж байсан түүх үгүй. Шууд өгч буй мөнгийг л хөрөнгө оруулалт гэж үзсээр иржээ. Тэгвэл хөрөнгө оруулалтын өгөөж хөгжингүйд нь бага, хөгжиж буйд нь илүү хүртээмжтэй байдаг талаар олон улсын шинжээчид онцолдог. Энэ нь хөрөнгө оруулалтын өгөөж манай улсад их байна гэсэн утга илэрхийлж байгаа юм.

Хөрөнгө оруулалтын үр нөлөөг “татвар ба хөгжил” гэсэн аргачлалар хэмждэг аж. Татвар нь шууд хэмжиж

болох орлого бол хөгжил нь мөнгөн үзүүлэлтэд шилжүүлсэн шууд бус эдийн засгийн үр нөлөө. Манай улсын хувьд татварыг онцлоод шууд бус үр өгөөжийг нь орхичихдог. Ер нь баялгаа гаргаж буй орнуудын хувьд хөрөнгө оруулагчаас авсан татвараа чамлах хандлага гаргадаг нь хөрөнгө оруулалтын шууд бус өгөөжийг ойлгодоггүйтэй холбоотой ажээ.

Оюутолгойн бүтээн байгуулалтад нийтдээ 6.49 тэрбум ам.доллар зарцуулсан гэсэн статистик бий. Гэхдээ эдийн засаг талаас харвал мөнгөн дүнгээс илүү өгөөж үлдсэн гэж болно. Хөрөнгө оруулалтын үржүүлэгч нөлөө нь их байсан гэсэн үг. Тодруулбал, бүтээн байгуулалт ид өрнөж байх үед өмнийн говьд 3000 орчим хүн ажиллаж байв. Ийм тооны гэр бүл энэ төслөөс амьжиргаагаа залгуулж байлаа. Нэг хүний ард гурван хүн бий гэж бодвол бараг 10 мянган хүнийг Оюутолгой “тэжээж” байж. Тэдний олонх нь байр, машины зээл авч амьдралаа дээшлүүлсэн. Тогтвортой орлоготой учраас л амьдрал ахуйгаа дээшлүүлсэн хэрэг. Цалин багатай, урьдчилгаагаа өгч чадахгүй иргэдийн хувьд байрны зээл асуудал болдог. Орлого нь хүрсэн ч урьдчилгаагаа төлж чадахгүй учраас байрны зээлд

хамрагдаж чадахгүй яваа залуус бий. Харин Оюутолгой тэргүүтэй томоохон төслүүд хөдөлж эхлэх сургаар дээрх асуудалд гарц болж байсныг ипотекийн зээлийн статистикаас харж болно. Үүнийг л хөрөнгө оруулалтын үржүүлэгч нөлөө гээд байгаа юм. Дээрх жишээ бол хөрөнгө оруулалтын үржүүлэгч нөлөөний наад захын өгөөж.

Тавантолгой, Цагаан суварга зэрэг уул уурхайн томоохон төсөл хэрэгжиж эхлэх үед мэргэжлийн боловсон хүчин хэрэгтэй болно. Тэднийг сургах, мэргэшүүлэхийн тулд их хэмжээний санхүүжилт хэрэгтэй болох бөгөөд үүнийг мега төслүүдээс орж ирэх хөрөнгөөр дэмжиж болох юм. Ингэснээр монголчуудыгаа чадавхжуулах боломж бүрдэж, энэ хэрээр тухайн хөрөнгө оруулалтын үржүүлэгч нөлөө өсөх аж.

Монголтой адил байгалийн баялаг ихтэй, ирээдүйд хөгжих өндөр боломжтой улсууд олон. Тэднээс ялгарч өрсөлдөх давуу тал бидэнд бий. Оюутолгой тэргүүтэй их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан төслүүдэд хөрөнгө оруулалтын үржүүлэгч нөлөөгөөр хэмжиж, бодитой үр дүнг нь тооцоод сурчихвал Монгол уул уурхайн салбартаа түшиглээд хөгжилд хүрч чадах билээ. ■

# Оюутолгой төслийн талаарх таны бодол. Одоогоор та ямар мэдээлэлтэй байна вэ?

**Д.Жаргалсайхан /Эм Ай Эйч группын ерөнхийлөгч, эдийн засагч/:**



- Хүмүүс сайнаар хүлээж авч байна. Тэдгээрийн нэг нь би. Ойрын үед сонсогдоогүй гэрэл гэгээтэй

мэдээ. Нөгөө талаасаа Шийдлийн Засгийн газар иргэний эр зориг гаргаж хийж байгаа урт хугацаанд эерэг үр дүн авчрах эрүүл саруул шийдвэр болж байна уу гэж харж байна. Үзэглэсэн тохиролцооны бичиг баримтыг нь "Туркойз Хилл Ресурс"-ийн вэб сайт руу орж харахад миний төсөөлж байсан хэмжээнд хүрч чадахаар өөрөөр хэлбэл, Монголын эдийн засагт дорвитой нөлөө үзүүлэхүйц нөхцөл харагдаж байна лээ. Оюутолгойгоос жилдээ 1.1-1.2 тэрбум ам.долларын мөнгө урсаж ороод байх юм байна. Энэ нь эдийн засгийг хүндрэлээс гарах чухал зүйл болж байна. Ер нь уул уурхайн аль ч төслийг манай улсын эдийн засагт, иргэдэд ямар хүртээмжтэй гэдгийг улсын төсөвтэй харьцдаг үзүүлэлтүүдээр дүгнэж болмооргүй санагдаж байгаа юм. Мэдээж роялтигийн асуудал, хуучин ВНР-ээс уламжлагдаж ирсэн асуудлуудаа шийдсэн нь сайн. Гэхдээ бид томоор нь хармаар байна. Энэ төсөл Монголын эдийн засагт үр өгөөжөө яаж өгөх ёстой юм бэ? Ард түмнээ төлөөлж ярьж байгаа зарим хүн энэ уурхайгаас улсын төсөвт хэчнээн төгрөг нэмүү авах уу, үгүй юу гэдэг ганцхан өнцгөөс яриад байна. Түүнээс биш эдийн засгийн бусад салбарт яаж нөлөөлж байна гэдэг өнцгөөс огт ярихгүй байна.


**П.Уранбилэг /СЭЗДС-ийн Экономиксийн тэнхимийн багш/:**

- Төслийн гэрээнд 2009 онд гарын үсэг зурснаас хойш нөхцөл байдал тогтворгүй, хувирамтгай байна. Эдийн засгийн өсөлт удааширч, таагүй



байгаа өнөө үед гацаанд орсон гэрээ зурагдсан нь сайшаалтай боловч энэ талаарх ойлголт төдийлэн нээлттэй, ойлгомжтой биш байна. Төсөл цаашид үргэлжлэх нь нэгэнт тодорхой боллоо. Тиймээс уг төслөөс хүртэх өгөөжид анхаарлаа хандуулах л үдлээ. Эдийн засгийн утгаараа төслийн өгөөж их байх нь мэдээж. Хэдийгээр өнөө, маргаашдаа үр өгөөжөө өгөхгүй байж болох ч хоёр гурван жилийн дараа эдийн засгийн өсөлт хурдсах, ажилгүйдэл буурах, дэд бүтцийн хөрөнгө оруулалт өсөх, бусад салбарын үйлдвэрлэлийг дэмжих гэх мэт ихээхэн өгөөж хүртээх нь тодорхой. Харин түүнийг дагаад ямар сөрөг үр дагавар гарах талаар одоохондоо таамаглал хийхэд тодорхой мэдээлэлгүй байна.

**Жим Двайер /Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал/:**



-Оюутолгойн нөөцийн 80 хувь газрын гүний уурхайд оршдог, олборлолтын 100 жилийн нөөцтэй. Ирэх таван жилийн хугацаанд Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтад нийт 7-8 тэрбум ам.долларын санхүүжилт хийгдэх болно. Ойролцоогоор олон улсын томоохон 15 банк энэхүү том төслийн санхүүжилтэд оролцох бөгөөд тэдний ихэнх нь Монголын хөрөнгийн зах зээл дээр анх удаа хөл тавьж байгаа.

Оюутолгой болон түүний нийлүүлэгчид маш олон ажлын байр бий болгоно. 2020 онд буюу гүний уурхайн үйлдвэрлэл явагдаж байх үед Оюутолгой Монголын ДНБ-ий 30 хувийг эзлэх болно. Дүгнэж хэлэхэд Оюутолгойн гүний уурхайн Монголын

эдийн засаг болон нийгэмд маш том эерэг нөлөөг олон жилийн турш үзүүлнэ гэж бодож байна.

**Ц.Түмэнцогт /"Женерал Электрик" ХХК-ийн гүйцэтгэх захирал/:**



-Оюутолгойн төслийг эерэгээр, урт хугацаанд өгөөжөө өгөх бололцоотой төсөл гэж харж байна. Ер нь

том төсөлд санхүүжилт, технологи болон боловсон хүчин гэх гурван хүчин зүйл ихээхэн шаардлагатай байдаг.

Оюутолгой нь газрын гүнээс бүтээгдэхүүн олборлоход орчин үеийн технологи, маш их хэмжээний санхүүжилт, боловсон хүчин шаардсан төсөл. Гэтэл энэ гол гурван хүчин зүйлийн аль нь ч Монголд байхгүй. Эдгээрийг авч ирж буй "Рио Тинто" компани нь Монголын хувьд стратегийн маш том хөрөнгө оруулагч. Тэгэхээр бид энэ хөрөнгө оруулагчтайгаа маш сайн ойлголцож, харилцан хүндэлж хамтарч ажиллах ёстой. 2009 онд анх байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний дагуу энэ үйл ажиллагааг явуулах ёстой.

**Ч.Намжаа /ХУД-ийн XI хорооны иргэн/:**



- Мэдээллийг ард түмэнд сайн өгөх хэрэгтэй. Мэдээлэл муу байгаагаас нэг нь энэ зөв, нөгөө нь буруу гэхээр ард түмэн учраа олохгүй байна. Төр хариуцлагатай байж ард түмэнд зөв мэдээллийг өгөх хэрэгтэй.

Бид нэг үнээтэй айл. Үнээнийхээ сүүг бусад газартай хувааж авах гэсэн ийм л улс юм гэж ойлгож байна. Үнээгээ үнэлдэггүй, зөвхөн сүүг нь үнэлдэг улс Монголоос өөр байхгүй. ■

## ТАНИЛЦУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Сэрэлт” ХХК нь “Сэрэлттакс ТМЗ” ХХК-ийг үүсгэн байгуулж Сангийн сайдын 2015 оны хоёрдугаар сарын 16-ны өдрийн 37 тоот тушаалын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчиддаа татвараа хуулийн дагуу үнэн зөв тодорхойлоход нь туслах үндсэн үүрэгтэй манай хамт олон татварын эрх зүйн орчныг тасралтгүй судалж шинжлэн, харилцагчдынхаа үйл ажиллагаанд учирч болох татварын аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлгүй ажиллуулах үндсэн зорилт тавин ажиллаж байна.

Бид харилцагчдаа шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр цаг тухайд нь бүрэн хангах, аливаа эрсдлийг богино хугацаанд арилгах, заавар зөвлөмжийг хууль тогтоомжын хүрээнд хамгийн энгийн ойлгомжтой хувилбараар хүргэхийг зорьж, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлүүдийг анхааралтай судалж мэдээллэн ажиллаж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ
- Татварын зөвлөх үйлчилгээ
- Бусад зөвлөх үйлчилгээ

Хаяг: Чингэлтэй дүүрэг 1-р хороо  
Энхтайваны гудамж, Denver оффис, 304 тоот  
Утас/Факс: 99093541, 88002321

## Зардлыг юунд зарцуулав?

Ц.Элбэг

Гүний уурхайн бүтээн байгуулалт зогссон гол шалтгаан нь ил уурхайн бүтээн байгуулалтын зардал хэтэрсэнтэй холбоотой. Сангийн сайд асан Ч.Улаан, Шадар сайд асан Д.Тэрбишдагва, Уул уурхайн сайд асан Д.Ганхуяг нар “Шалгалтаар “Оюу Толгой” ХХК 2009 оны техник эдийн засгийн үндэслэлээс даруй хоёр тэрбум ам.доллараар зардлаа хэтрүүлсэн болох нь тогтоогдсон” хэмээн мэдэгдсэн юм. Энэ нь техник эдийн засгийн үндэслэлээс 30-40 орчим хувиар өссөн гэсэн үг.

“Оюу Толгой” компанийн зүгээс хөрөнгө оруулалтын гэрээг батлах гэж хугацаа алдсанаас шахуу төлөвлөгөөтэй ажилласан, Засгийн газарт өгөх татвар нэмэгдсэн, Хятадаас эрчим хүч авах асуудал хойшилсон, дэлхийн санхүүгийн хямралаас болж салбарын зардал өссөн зэрэг компанийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаан зонхилон нөлөөлсөн гэж тайлбарласан.

Харин өссөн нийт хөрөнгө оруулалтын хоёр хувь нь нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалтын зардал, таван хувь нь үйл ажиллагааны цар хүрээ өссөн, таван хувь нь батлагдсан барилгын ажилд шаардлагатай ажиллах хүч, материалыг доогуур тооцсон, гүний уурхайн цар хүрээ нэмэгдсэн зэргийг өөрсдөөсөө шалтгаалсан гэж үзэж байгаа юм. Гэхдээ маргаан бий болсон асуудал нь зардлын хэтрэлт хоёр тэрбум бус 0.9 тэрбум ам.доллар гэсэн баримтыг “Оюу Толгой” дэлгэсэн. Тухайлбал, бүтээн байгуулалтын зардал 0.6 тэрбум, гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар 0.2 тэрбум, менежментийн төлбөр 0.1 тэрбум ам.доллараар тус тус хэтэрсэн гэж буй.

Хоёр тэрбум ам.долларын зардал хэтэрсэн, хэтрээгүй гэж нэлээд удаан

маргалаа. Харин зардал хэтрэх нь ямар үр дагавартай тухай бага хөндөж байна. Нэгдүгээрт, техник эдийн засгийн үндэслэл гэдэг заавал баримтлах ёстой үүрэг, хариуцлага биш. Ерөнхийдөө тухайн ажлыг тийм хэмжээний зардалтайгаар ийм түвшинд гүйцэтгэж болно гэсэн тооцоо юм. Тухайлбал, 2009 онд техник эдийн засгийн үндэслэлийг батлахад Оюутолгойгоос хил хүртэлх хатуу хучилттай замыг барихдаа замын зөвхөн зарим хэсгийг хатуу хучилттай барихаар тусгасан байсан. Үүнийг экологид сөрөг нөлөө их гэж үзсэн тул бүх замыг хатуу хучилттай болгожээ.

Хоёрдугаарт, зардал хэтэрсэн гэдэг нь мөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж тайлбарлах үндэс болохгүй. Зардлын хэтрэлтэд бүтээгдэхүүн худалдан авах, шинэ байгууламж барих зэрэг шалтгаан зонхилж байна. Эдгээр нь эргээд “Оюу Толгой” ХХК-ийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, үнэлэмжийг өсгөж байгааг бас бодолцох хэрэгтэй аж.

“Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Да.Ганболд “Өнөөдрийн уушги гэж харвал энэ нь муу мэдээ. Яваандаа үнэ хүрнэ, ажил нь өргөжнө, илүү их бүтээмж, ашиг авч ирнэ гэж харвал хэтрүүлсэн үү, хассан үү гэдэг нь хэнд ч сонин биш” хэмээн тайлбарлав.

Монголын тал “Оюу Толгой” компанийн 34 хувийг эзэмших хөрөнгийг зээлж авсан. Тэр мөнгөн дүнд зардал хэтэрсэнтэй холбоотой ямар нэгэн өөрчлөлт орохгүй. Учир нь зардлын хэтрэлт бол “Рио Тинто” болон “Эрдэнэс Монгол”-ын хамтарсан “Оюу Толгой” ХХК-ийн хариуцлага юм. Тус компанийн өгч буй тайлбараар зардал өссөн шалтгаануудыг дурдвал ажиллах хүчний цалин хөлс болон ажилчид, машин

тоног төхөөрөмжийн тоо нэмэгдсэн. Тухайлбал, хүнд даацын авто машины тоог техник эдийн засгийн үндэслэлд 19 ачааны машин гэж тусгасан ч 27 машин худалдан авсан байна. Мөн цахилгаан эрчим хүчний нийлүүлэлттэй холбоотой зардал өссөн, төслийн сул зогсолтын үеийн ажилчдын зардал хэтрэлтэд орсон нь өөрсдөөс шалтгаалсан хүчин зүйл болж буй аж. Түүнээс гадна бүтээн байгуулалтын явцад олон өөрчлөлтийг төслийн хүрээнд хийхийг “Оюу Толгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр баталж, гүйцэтгэжээ. Үүнд тоног төхөөрөмж, хэрэгслийн тоог үйлдвэрлэлийн чадавх өргөжсөн, хөрс хуулалтын өмнөх өөрчлөлтөд нийцүүлэн нэмсэн гэсэн тайлбар өгч буй.

Мөн баяжмалыг талбай дээр савлах зорилгоор Савлах үйлдвэр байгуулсан, нисэх онгоцны буудал, хил рүү татсан хатуу хучилттай зам, Гашуун сухайтын хилийн боомтын байгууламжуудыг сайжруулах ажлууд ил уурхайн техник эдийн засгийн үндэслэлд тусгаагүй юм.

Өнөөдөр зардлын хэтрэлтийн шалтгаан, задаргааг “Оюу Толгой”-оос өөр эх сурвалж олон нийтэд мэдээлээгүй, шинэ баримт дэлгээгүй байна. Харин гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд зардлын хэтрэлттэй холбоотой асуудлаар талууд тохиролцоонд хүрснийг тусгажээ. Мөн төлөвлөгөөний 2.4-ийн (а) дахь заалт “... жилд нэгээс доошгүй удаа “Оюу Толгой” компанийн ТҮЗ-өөс Монгол Улсын хуулийн дагуу томилсон хөндлөнгийн аудитын Монгол компаниар шалгуулна” гэсэн буй. Үл ойлголцол, үл итгэлцлээс болж энэхүү том төсөл гацаанд орсон. Тэгвэл өнөөдөр үл ойлголцол арилж, итгэлцэл бий болгох шийдэл тодорхой болжээ. ■

# MONGOLIAN ECONOMY

MONGOLIAN ECONOMY

Mongolia's Economy and Business Magazine

May, 2013, №09 (043)

"Don't expect others to ask to dance"

Partners Linked Through History

[www.mongolaneconomy.mn](http://www.mongolaneconomy.mn)

MONGOLIA: HEART OF DEMOCRACY


Here Comes Cash Floods

# Гүнзгий мэд

## Ордын нөөц



Оюутолгойн нөөц Эрдэнэтийн уурхайгаас долоо дахин их 2010 оны гуравдугаар сард батлагдсан Оюутолгойн ордыг ашиглах ТЭЗҮ-д тусгагдсанаар тус ордын үр ашигтай буюу олборлолтын нөөц нь



Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт 5-7 жил үргэлжилнэ. Энэ төсөлд Монгол 34 хувь эзэмшдэг, 34 хувиа ногдох ноогдол ашгаар төлнө.

Түүний дараа ашиг хүртэнэ.

Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд жил бүр дунджаар 1.2 тэрбум ам.доллар

Монголд орж ирэх боломжтой хөрөнгө оруулалтын нийт дүнг 20 тэрбум ам.доллараар яригдаж байна.



1.Хөрөнгө оруулалтын зардал



Нийт дүнгээрээ 6.8 тэрбум ам.долларын зардал гарах нь.



2.Гүний уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын зардал



Нийт дүнгээрээ 4.7 тэрбум ам.доллар



3. Монгол Улсад шууд зарцуулах хөрөнгө оруулалтын тухайд



Нийт дүнгээрээ 9 тэрбум ам.доллар аж.

Мөн Хөрөнгө оруулагчдын гэрээ болон Хувь нийлүүлэгчдийн гэрээнд тусгагдаагүй байсан Оюутолгой төслийн нийт өгөөжийн 54 хувийг Монголын тал хүртэх асуудлыг баталгаажуулж, Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаа болон санхүүд Монголын тал хяналтыг тавьж ажиллах тогтолцоог бий болгож чадсан. Менежментийн төлбөрийг гүний уурхайн бүтээн байгуулалтын үед гурван хувь болгосон байна.

“Оюу Толгой” компанийн 2015 оны гуравдугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон нэгдүгээр улирлын

гүйцэтгэлийн тайланд дурьдсанаар

Баяжмалын борлуулалтаас 2015 оны нэгдүгээр улиралд 426.2 сая ам. долларын орлого олж, борлуулсан баяжмалын хэмжээ 2015 оны нэгдүгээр улирлын үйлдвэрлэлийн хэмжээнээс илүү байв. 2015 оны нэгдүгээр улирлын үйлдвэрлэл бага байхаар таамаглаж байсан бөгөөд энэ хугацааны орлого, борлуулалтын дүн нь үйлдвэрлэлийн хэмжээтэй уялдаж байна.

“Оюу Толгой” компани энэ улиралд 66.4 сая ам.долларын татвар, хураамж төлж, дотоодын худалдан авалтад

78.3 сая ам. доллар,үүнээс Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалтад 14.1 сая ам. доллар зарцуулав.

Одоогийн мөрдөж буй уурхайн төлөвлөгөөнд тулгуурлавал “Оюу Толгой” компани 2015 онд 175-195 мянган тонн зэс,600-700 мянган унци алтны агуулгатай баяжмал үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байна.

2015 онд үйлдвэрлэхээр төлөвлөсөн баяжмалыг 100 хувь борлуулах борлуулалтын гэрээг байгуулсан болно. ■

Эх сурвалж: “Оюу Толгой” ХХК



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

## Гүний уурхайн “гүн ухаан”

Б.Үүрийнтуяа

Том нэрс зүүлгэж, тоймгүй олон тэгээр үргэлжлэх тодорхой тооны зээлийг Монгол Улс асар богино хугацаанд өрийн дансандаа нэмж бичүүлсэн. Ингээд олсон хамгаараа иргэдээ “халамжилж”, хотоо цэцэгжүүлэхийн хажуугаар “888” хэмээн төсөл нэртэй цаас цуглуулсан бүхнийг эрхлүүлээд дуусахад эдийн засаг бас л дагаад “дуусав”.

Хоёр чихнээсээ хагацах дээрээ тултлаа хоосорсон монголчууд өрийн дарамтад орж дампуурах тухай бодож суутал Ойрхи Дорнодын баянбүрд гэгдэг тэртээх Дубай хотоос таатай мэдээ дуулдах нь тэр. Гэрээ биш төлөвлөгөө, нууц байгаагүй ил тод мэдээлсэн гэх мэтээр өдгөө маргасаар байгаа ч олон улсын хөрөнгө оруулалтын тавцанд навс

унаад байсан Монголын нэр хүндийг хэдэн алхам өөд ахиулав. “Discovery Channel”, “National Geographic” тэргүүтэй олон улсын томоохон сувгууд Монголын тухай нэвтрүүлгүүдээ ээлж дараалан цацаж эхэлсэн нь манай орон бусдын анхаарлыг ахин татаж эхэлсний хамгийн энгийн жишээ.

Амь тавихад ойр ирээд байсан Монголын эдийн засаг “Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-р сэхэл авсан гэж болох. Орж ирэх “ногоон”-ы сургаар зарцуулалт хийх жагсаалт ч гараад амжсан. Гэвч “Оюутны 70” гэх мэтээр бас л үрээд дуусах вий гэсэн болгоомжлол бий.

Монголын эдийн засгийн өсөлтөд хүчилтөрөгч болохуйц бүтээн байгуулалт

Оюутолгой нэрээр олны танил болоод өдгөө зургаан жилийг үджээ. Хүний насаар бол бага ангийн “сурагч” болох нь. Гэтэл монголчууд энэхүү хүүхдээ сургана, сургахгүй хэмээн талцаж, чангаасаар байгаа нь шалдаа буусаар буй Монголын нэр хүндийг эргээд шаварт хутгаж мэдэх юм. Ийм учраас үлстөржих бус асуудлын гүн юу болохыг сийрүүлэхийг оролдлоо.

### Төлөвлөгөөнд юу тусгав

Тус орд газартай холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ анх 2009 онд хүчин төгөлдөржсөнөөс хойш ил уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагаа чамлахааргүй их өгөөжийг Монгол Улсад өгсөн гэдэг. Гэвч Оюутолгойн



уурхайн баялгийн 80 хувь нь буюу “алтан авдар” нь газрын гүнд оршиж буй. Гүний уурхайн бүтээн байгуулалт, цаашлаад үйл ажиллагааг эхлүүлснээр манай улсын эдийн засаг хэрхэн сэргэх талаар дотоод, гадаадын эдийн засаг, судалгааны байгууллагууд дүгнэлт, анализ гаргасаар байгаа. Түүнчлэн “Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд “Гүний уурхайн техник, эдийн засгийн үндэслэлд /ТЭЗҮ/ дурьдсанаар Оюутолгой төслийн эдийн засгийн үр ашгийн хуваарилалт нь 2010 оны ТЭЗҮ-д тооцсон тооцоололтой нийцэж байгаа ба үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар Оюутолгой төсөл хэрэгжих хугацаанд төслийн нийт үр ашгийн 53 гаруй хувийг татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг хэлбэрээр авахыг цохон тэмдэглэж байна” гэжээ. Түүнчлэн гүний уурхайн үе шатны бүтээн байгуулалт, үйл ажиллагааны зардал, Монгол Улсын Засгийн газарт төлөх төлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт зарцуулагдах зардлын тооцоо, бүтээн байгуулалтын ажлын болон зардлын төлөвлөгөөг тоймлон гаргажээ.

### Төлөвлөгөө юу авчрах вэ


Гүний уурхайн бүтээн байгуулалт зөвхөн мөнгөний хүүдий биш. Амьдралын шинэ стандарт, шинэ туршлагыг Монголд нэвтрүүлэх шинэлэг өөрчлөлт хэмээн төсөл хэрэгжүүлэгч талаас хэлж буй. Тус уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнөөс эшлэн дурьдвал “Оюу Толгой” ХХК Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, тэр дундаа Өмнөговь аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгож, тэдний нийлүүлж буй бараа, үйлчилгээг болон Монгол Улсад үйлдвэрлэсэн тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, сэлбэг хэрэгсэл зэргийг цаг хугацаа, тоо хэмжээ, чанарын хувьд өрсөлдөхүйц байх нөхцөлтэйгөөр тэргүүн ээлжинд худалдаж авна” гэжээ. Үүнээс үзэхэд, Оюутолгойн төслийг дагаад үндэсний ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхжих, улмаар ажлын байр шинээр бий болох гээд олон давуу тал ундрахаар байгааг онцлох нь чухал. Гэвч эдгээр боломж, бололцоо зохих шаардлагуудыг хангасан нөхцөлд хөрсөнд буух боломжтой аж. Тодруулбал, “Оюу Толгой” ХХК гүний уурхайн үе шат (гүний уурхайн ТЭЗҮ-д заасны дагуу Хойд Хюго ордыг ашиглах гүний уурхайн нэгдүгээр давхрын бүтээн байгуулалтын ажил, далд уурхайгаас олборлох хүдрийг боловсруулах зорилгоор баяжуулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцэд хийх өөрчлөлтийг ойлгоно)-ыг санхүүжүүлэх гуравдагч этгээдийн төслийн санхүүжилтийг авах шаардлагуудыг хангахын зэрэгцээ оролцогч талуудын ТУЗ тус бүрээр батлуулсан байхаар заажээ. Биеллээ олох ээлжээ “хүлээж” буй мега төслүүдийн нэг Оюутолгой дээрх мэтээр өгөөжөө хүртээх учиртай. Гэвч ордын 34 хувийг эзэмшиж буйн хувьд Засгийн газар өөрийн зүгээс хийх ёстойгоо хийх нь бизнест оролцох тэргүүний зарчим. Тэгвэл үүний илрэл гэж болох эхний алхам бол гацаах биш урагшлуулах. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайханы хэлснээр Оюутолгойн орд дэлхийд өрсөлдөхүйц томоохон уурхай болоход гүний уурхайн бүтээн байгуулалт тун чухал үүрэгтэй төдийгүй өнөөгийн үнэ цэнээр тооцвол гүний уурхайн бүтээн байгуулалтаас

50 орчим тэрбум ам.долларын өгөөж хүртэх боломжтой аж. Бизнесийн ийм зарчмаар явах учиртай энэ төслийг “эрүүлээр” үргэлжлүүлбэл Монгол Улсад шинэ хөрөнгө оруулалт татах, эдийн засаг сайжрах гээд эерэг нөлөө их гэдгийг тэрбээр хэлсэн юм. Тэгвэл “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Да.Ганболдын үзэж буйгаар гүний уурхайн үйл ажиллагаа эхлэхтэй уялдан гаднын дэвшилт технологи Монголд нэвтрэх боломж бүрдэх аж. Түүний онцолсноор монголчууд хоёр хөршөөсөө хоол горьдож суух биш дэлхийн бусад томоохон гүрэнтэй бизнес түншлэл бий болгох гарц үүснэ.

Монголын эдийн засгийг сэхээн амьдруулах төлөвлөгөө гарсан нь сайн. Хэрэгжвэл бүр ч сайн. Гэвч цаасанд буулгаснаа амьдрал дээр хэрэгжүүлэхэд хэдэн хүний гарын үсэг хангалтгүй. Тоглоомын дүрмээ маш тодорхой болгох нь эхний алхам. Энэхүү шаардлагыг ч хангасан, нэг мөр ойлголцсон гэдгийг “Эрдэнэс Оюутолгой” болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагууд хэлсэн. Удаах алхам долоо орчим жил үргэлжлэх бүтээн байгуулалтын ажил. Үүнд уурхайн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан уул уурхайн “диваажин” бий болгох асуудал багтаж буй. Гүний уурхайн бүтээн байгуулалтын чухал хэсэг болох туннел барихдаа нэг сумаар хоёр туулай буудах төлөвлөгөөтэй байгаа аж. Энэ нь туннел ухахын зэрэгцээ тодорхой хэмжээний олборлолт хийнэ гэсэн үг. Хэдийгээр төлөвлөсөн хугацаанаас хавьгүй олон жил шаардлагатай байж болох ч ирэх долоон жилийн дотор гүйцээх зорилго тээн жигд олборлолтыг эхлүүлэхээр “Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд тусгажээ.

Мөнгө хөөсөн хүн мөнгө хөөсөөр үхдэг гэдэг үг бий. Иймд Оюутолгойн гүний уурхайг зоосны нүхээр харах нь учир дутагдалтай. Эл ордыг тойрсон асуудалд мөнгө гэсэн нэг талыг хэт барьж, мэдээлж, тайлбарлаж буй нь тус ордыг мөнгөний гахай мэтээр ойлгоход хүргэж байгаа юм.

Гэвч эл орд зөвхөн байгалийн баялгийн уурхай биш дэлхийн стандартад стандарт тогтоох бүтээн байгуулалтын асар том “соёл” гэдгийг ойлгох цаг нэгэнт болжээ. ■



ЗЭСИЙН ИРЭЭДҮЙ

## Шагнал ба шаналал

Б.Энхцэцэг

Дэлхийн хамгийн сэтгэл татам металлуудын нэг болох зэсийн тухай сайн, мүү мэдээ байна.


Өдгөө зэсийн ертөнцөд хүнд хэцүү цаг үе тохиож байна. Зэсийн үнэ энэ жилийн хувьд тав дахь жилийнхээ хамгийн доод ханшид хүрч буурлаа. Энэ сарын эхний байдлаар зэсийн үнэ гурван сарын дунджаар Лондонгийн металлын бирж дээр нэг тонн нь 5995 ам.доллар байна. Харин зэс олборлогчид Хятад хэмээх томоохон үйлчлүүлэгчийнхээ суларч буй эрэлтийн төлөө хоорондоо тэмцэлдэн арсалдаж байна. Хятадын эдийн засгийн өсөлт сулрахтай зэрэгцэн зэсийн үнэ төмрийн хүдэр, нүүрсний үнэтэй “хөтлөлцөн” хамтдаа огцом уруудлаа, энэ жил. Гэхдээ зэсээр овоглогддог бүх хүн хоол үнднаасаа салчихмаар тийм гамшгийн

хэмжээнд нөхцөл байдал хүрсэн гэж хэлэх боломжгүй.

Олон улсын зэсийн судалгааны группын гаргасан зах зээлийн төлөвт энэ жил боловсруулсан зэсийн үйлдвэрлэл эрэлтээсээ 365 мянгаар ирэх жил 230 мянгаар давахаар байна гэх тооцоо гаргажээ. Дэлхийн

тонн болохоор байгаа аж. Ирэх онд Хятадын боловсруулсан зэсийн эрэлт таван хувиар өсөхөөр байгаа бол бусад улсын хэрэглээ тогтонги байхаар байгааг тэд мөн гаргажээ.


Металлын үйлдвэрлэлээрээ хамгийн томд тооцогддог “Freeport-McMoran” компани гэхэд л долоон жил тасралтгүй



зэсийн үйлдвэрлэл энэ онд таван хувиар өсч 19.5 сая тонн, ирэх онд 20.5 сая

ногдол ашиг хуваарилж ирсэн бөгөөд энэ жил анх удаа зэсийн доогуур

ханшаас үүдэн ногдол ашгийнхаа хэмжээг багасгахаар боллоо. Өнгөрсөн сард Чили улсад болсон Дэлхийн зэсийн чуулганд оролцогчид зэс хэмээх бүтээгдэхүүн төмрийн хүдэр шиг удаан хугацаанд уруу царайлах уу үгүй юу гэдэг дээр хуваагдмал байр суурьтай байлаа. Учир нь, зэс бол төмрийн хүдэртэй харьцуулахад илүү олон төрлийн үйлдвэрлэлд ашиглагддаг бүтээгдэхүүн бөгөөд тухайлбал, барилга,автомашин үйлдвэрлэлд өргөн хэрэглэдэг билээ. Мөн бас нэг ялгагдах онцлог нь зэс нь төмрийн хүдэр адил илүүдэл эрэлтээс үүдэн хэцүү байдалд ороод байх нь бага. Энэ жилийн хувьд ч таваарын шинжээчид илүүдэл төдийлэн өндөр хэмжээнд үүсэхгүй гэж зурагласан. “Barclays”-ын шинжээч “Зэс цаашид ч нийлүүлэлтийн талд нэлээд хязгаарлагдмал байх хандлагатай байна. Энэ нь одоогийн нөхцөл байдал ойрын ирээдүйд засварлагдах боломжтойг харуулж буй” хэмээн хэлсэн байдаг.



Жил бүрийн хоёрдугаар улирал зэсийн хувьд хамгийн эрэлттэй үе. Энэ нь мэдээж ахиад л эрхэм хүндэт номер нэг худалдан авагч Хятадтай холбоотой. Энэ жилийн хувьд зэсийн зах зээлд сэргэлт дагуулах хэдэн шинж тэмдэг байна. Банкуудаас хүссэн зээлийг батлах үйл явц удааширсан, үйлдвэрлэгчид бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байгаа, худалдаачид одоо ч удаан хугацааны нийлүүлэлтийн гэрээг хийхээ хүлээж буй. Эдгээр асуудал шийдвэрлэгдвэл зэсийн зах зээлд эерэг нөлөө мэдрэгдэнэ. Гэвч Хятадын хилүүдийн агуулахад байгаа зэсийн нөөц буурна гэж хүлээж байсан ч ийм явдал болоогүй нь эрэлт сул байх дохио болж байна.

Зэсийн урт хугацааны төлвийг сүүдэртүүлж буй нэг том үүл нь хөнгөн цагаан. Кабелийн утас татахад Засгийн газар болон компаниуд зэсээс илүүтэй хөнгөн цагааныг хэрэглэх нь илүү ихэсч байна.

### Хааны титэм хаачих вэ?

Нийлүүлэлтийн тал дээр Чили улсын давамгайлалтай дөхөж очих улс үгүй. Тус улс дангаараа дэлхийн нийт зэсийн гуравны нэгийг үйлдвэрлэдэг. Гэвч зэсийн ирээдүйг тодорхойлогч тус улсын мөнгөн тэмдэгтийн ханш, газрын тосны үнэ буурсан нь Чилийн үйлдвэрлэгчдэд зардлаа багасгах боломжийг бий болж буй. Гэвч тус улсад хоёр сарын өмнө болсон үер олон үйлдвэрлэгчдийг үүдээ түр хугацаанд барихад хүргэсэн. Чили улсын хувьд хөрөнгө оруулалтын ирээдүй нэлээд бүрхэг болж ирж буй. Учир нь, тус орны зэсийн чанар тогтмол буурч байгаа бөгөөд энэ нь хэрэглэгчдийнхээ эрэлтийг хангахын тулд үйлдвэрлэгчид илүү ихийг үйлдвэрлэхийн тулд илүү их зардал гаргах шаардлагыг бий болгожээ. Энэхүү зардлын хэмжээ өсч байгаа. Цаашид ч өснө. “Anglo-American” компани Чили улс дахь гурван жижиг хэмжээний уурхайгаа зарахыг оролдож байна. Тиймээс зарим компани Конго Замби зэрэг хүдрийн

зэрэглэл өндөртэй улсад хөрөнгө оруулж байна. Мөн энэхүү зэсийн зах зээлийн хааны титмийг Монгол Улсын Оюутолгой хуваалцахаар зэхэж байгаа билээ. Гэхдээ дор хаяж долоон жилийн дараа.

### Сайн мэдээ

Үнэ өсөх л юм бол маш олон тохиролцоо, гэрээнүүд дагаад идэвхжих нь тодорхой юм. Учир нь өдгөө үнэ тиймхэн байгаа ч хөрөнгө оруулалтын сангууд маш их мөнгийг зэсийн уурхайн гэрээнүүдээр дамжуулан босгож байна. Дэлхийн зэсийн чуулганд оролцогч нэгэн үйлдвэрлэгч хэлэхдээ “Угаасаа л дэлхий даяар зэсийн чанарын зэрэг буурч байгаа. Гэхдээ та боломжийн хэмжээний эсвэл үйлдвэрлэл эхлэхэд ойртсон уурхай олвол, эрсдэл багатай ашиг олох боломж бий” гэж байна. Зэсээр овоглосон чуулга уулзалтууд дээр одоогийн үнийн уналттай зэсийн зах зээлийг богино хугацааны шаналал

гэж харах хүн олон байгааг анзаарах болно. Харин урт хугацаанд тус бүтээгдэхүүний ирээдүй өөдрөг байгааг үйлдвэрлэгч, шинжээчид амлаж байна. Өндөр зардал гаргаж, бага үйлдвэрлэл явуулдаг жижиг үйлдвэрлэгчдэд үнийн уруудалт хүндхэн тусаж байгаа нь үнэн. Гэхдээ том компаниудын хувьд ашиг буурсан л болохоос улаан гэрлээр орчихоогүй байгаа. Өөрөөр хэлбэл, тэд аюулгүй бүст байсан хэвээр.

Дэлхийн банкны төсөөллөөр зэсийн үнэ ирэх 10 жилийн хугацаанд огцом уналт, өсөлтийг харуулахгүй бөгөөд төдийлэн өмнөх оргил үе шигээ тонн нь 8000-9000 ам.долларын үнэ хүрэхгүй гэнэ. Зэс 2025 он гэхэд хамгийн өндөртөө 6800 ам.доллар хүрч магадгүй гэх тооцоолол гаргасан байна. Олон улсын валютын сан зэсийн үнийг 2020 он хүртэл одоогийн доогуур үнээ хадгална гэж тооцсон бол “Economist” сэтгүүлийн судалгааны алба ч мөн төстэй зураглажээ. /График 1 ба 2-ыг харна уу/

Хэрэглээ талаас нь харвал, Хятад улс “халуун” сэдэв. Тус улс өдгөө массаар нь авч үзвэл хязгаартаа хүрчихээд байгаа. Тиймээс ч Хятадын өсөлт удааширчихаад байхад ч зэс худалдан авалт боломжийн буюу нийлүүлэгчдийг “эцээчихгүй” хэмжээнд өссөөр байгаа юм. Тус улсын хэрэглээ болон хөгжиж буй орнуудад сэргэлт ажиглагдаж байгааг тооцоолбол дэлхийн зэсийн хэрэглээ ирэх 10 жилд долоон сая тонноор нэмэгдэх хүлээлт байна. Харин өнгөрсөн онуудад буюу 2004 оноос хойш өдийг хүртэл таван сая тонноор нэмэгдсэн байдаг билээ.

“Ирэх он гэхэд зэсийн нийлүүлэлтийн илүүдэл 500.000 тонноос багагүй байна гэдэг тооцоо гараад буй. Гэхдээ энэ нь ердөө л дэлхийн нийт хэрэглээний хоёр хувьтай л тэнцүү юм” хэмээн “Financial Times” бичжээ. Зэсийн уурхайг бодол хэмээх шатнаас үйлдвэрлэл болгох хүртэл дунджаар 11 жил шаарддаг.

“Аль хэдийнэ үйлдвэрлэлийн шатанд хүрээд, зах зээлд байр сууриа олчихсон үйлдвэрлэгчдийн хувьд дараагийн том тоглогч гарч иртэл ийм цаг хугацаа, зах зээлийн гайхалтай боломж байна гэсэн үг. Үүнийг шагнал гэж бод” хэмээн “BNP Billiton” корпорацийн зэсийн групп хариуцсан захирал Петер Бивен саяхан хэлсэн юм. ■



ТЭД ХЭН БЭ

## Туркойз Хилл Ресурс

Б.Энхмөнх

Оюутолгойн 66 хувийг “Туркойз Хилл Ресурс” компани эзэмшдэг. Тус компани нь Канадын Ванкувер хотод төвтэй бөгөөд 2012 оны наймдугаар сар хүртэл “Айванхоу Майнз” нэрээр үйл ажиллагаагаа явуулж байжээ. “Айванхоу Майнз” компанийг 1994 онд Роберт Фрийдланд үүсгэн байгуулсан бөгөөд 2011 оныг хүртэл компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. “Рио Тинто” компани анх тус компанийн 35 хувийг эзэмшдэг байсан бөгөөд хувьцаагаа 46.6 хувьд хүртэл буюу гол хувьцаа эзэмшигч болох сонирхолтой байсан. Гэвч “Айванхоу Майнз” өөрийн хувиа зарах сонирхолгүй байсан юм. 2011 оны хоёрдугаар сарын 9-нд “Рио Тинто”-гийн хоёр албан тушаалтныг ТУЗ-ийн гишүүнээр нэмж сонгосноор “Рио Тинто” компани зургаан суудалтай (нийт 14-өөс) болсон нь “Айванхоу Майнз” дахь өсөн нэмэгдэж буй ашиг сонирхлыг илтгэж байсан аж.

2011 оны зургадугаар сард “Рио Тинто” 502 сая ам.доллараар “Айванхоу Майнз”-ын 55 сая хувьцаа буюу тус компанийн 4.5 хувийг худалдаж авснаар 46.5 хувийг эзэмших болжээ. Ийнхүү “Рио Тинто” ТУЗ-д 7/14 гэсэн харьцаатай болсон юм. 2012 он гэхэд “Рио Тинто” тус компанийн 51 хувийг эзэмшдэг болсноор гол хувьцаа эзэмшигч болжээ. Улмаар “Айванхоу Майнз” компани “Туркойз Хилл Ресурс” хэмээн нэрээ өөрчилсөн аж.

Уг компани Оюутолгойгоос гадна

Австралид алт, уран, зэс болон дэлхийн хамгийн өндөр зэрэглэлийн молибден, ренийн нөөцтэй уурхайнуудын хувьцааг эзэмшдэг. Мөн Монгол Улсад нүүрс олборлодог “Саусгоби Ресурс” компанийн 23.3, “Entree Gold” компанийн 14, “Exco Resources” компанийн 14 хувийг тус тус эзэмшдэг аж.

“Рио Тинто”-гийн түүхээс дурдвал Рио Тинто гэдэг үг нь испани хэлнээ “улаан гол” гэсэн утгатай бөгөөд тус компанийн нэрийг Испанийн “Рио Тинто” голын нэрээр нэрлэжээ. Манай эрний өмнөх 3000 оны үеэс эхлэн иберичүүд голын дагуу байрлах баялагтай газраас алт, зэс, мөнгө болон бусад ашигт малтмалыг олборлож эхэлсэн. Тэднээс хойш грек болон ромчууд ашигт малтмал олборлож байсан түүхтэй. Тус уурхай хэсэг хугацаанд үйл ажиллагаагаа зогсоогоод байсны дараагаар Испанийн Засгийн газар 1774 он хүртэл олборлолт хийж байжээ. Харин 1873 онд Испанийн Засгийн газар улс төрийн болон санхүүгийн хямралд орж уурхайг зарах шийдвэр гаргасан байдаг.

“Matheson and Company” тэргүүтэй компаниудын нэгдэл Испанийн Засгийн газраас зохион байгуулсан тендерт ялж, уурхайг 3,680 сая фунт стерлингээр худалдан авчээ. Үүний дараагаар 1873 оны гуравдугаар сарын 29-нд “Рио Тинто” компани албан ёсоор бүртгүүлсэн байна.

### Дэлхийн ТОП таван уул уурхайн компани

#### 5. Anglo American

Их Британийн Лондон хотод төвтэй “Anglo American” нь дэлхийд цагаан алтны үйлдвэрлэлээр тэргүүлдэг бөгөөд алмаз, зэс, никель, төмрийн хүдэр, эрчим хүчний нүүрсний үйлдвэрлэлээр тэргүүлэгч компаниудын нэг юм. Тус компани 2014 онд 27.073 тэрбум ам.долларын орлоготой ажилласан байна.

#### 4. Vale SA

“Vale SA” нь Бразилийн уул уурхайн компани юм. Тус компани нь төмрийн хүдэр үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг бол никель үйлдвэрлэлээр хоёрдугаарт ордог аж. Мөн цахилгаан эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг төдийгүй одоогоор есөн усан цахилгаан станц ажиллуулж байна.

#### 3. Рио Тинто групп

Англи-Австралийн үндэстэн дамнасан уул уурхайн корпораци болох “Рио Тинто” групп нь Их Британийн Лондон хотод төвтэй. Тус групп 1873 онд үүсгэн байгуулагджээ. Тус компани нь хөнгөн цагаан, төмрийн хүдэр, зэс, уран, нүүрс, алмаз зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч компаниудын нэгт зүй ёсоор тооцогддог хэдий ч ашигт малтмал олборлолт тус компанийн гол үйл ажиллагаа аж. “Рио Тинто” 2014 онд 47.664 тэрбум ам.долларын орлоготой ажиллажээ.

#### 2. BHP Billiton

Австралийн Мельбурн хотод төвтэй Англи-Австралийн “BHP Billiton” компани нь 2013 онд уул уурхайн компаниудаас хамгийн ашигтай ажиллаж, дэлхийн хамгийн том уул уурхайн компанид тооцогдож байсан юм. 2001 онд Австралийн “Broken Hill Proprietary” болон Англи-Голландын “Billiton” компани нэгдсэнээр үүссэн түүхтэй тус компани 2014 онд 67.206 тэрбум ам.долларын орлоготой ажилласан аж.

#### 1. Glencore

Англи-Швейцарийн “Glencore” компани нь Швейцарийн Баар хотод төвтэй. 2014 онд дэлхийн 10 дахь том компаниар нэрлэгдсэн удаатай. ■



Бизнес стартапын  
**туршлага**



Хууль эрх зүйн  
**зөвлөгөө**



Хөрөнгө санхүүгийн  
**туслалцаа**



Санхүүгийн иж бүрэн  
**үйлчилгээ**



Маркетингийн  
**шийдэл**



Ня-бо бүртгэлийн  
**дэмжлэг**


Ажлын байрны түрээс

**₮ 300K + НӨАТ**

Дээрхээс гадна ширээ, сандал, уулзалт, сургалтын тасалгаа, интернет, дулаан, цахилгаан, ус, харуул хамгаалалт энэ үнэд багтаж байна.

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж Өнгөт хэвлэл компанийн байр, 2-р давхар





ҮР ДҮН

## Хөгжилд хөглөгч

Г.Түшээ

Телевизийн суваг солин суугаа найман настай охин “Оюутолгой, Оюутолгой гээд байх юм. Энэ юу юм бэ” хэмээн аав, ээжээсээ сониучирхан асуух. Түүний хувьд Оюутолгой нэг талаар олны танил “од” шиг санагдсан биз. Монголчууд төдийгүй дэлхий нийт ийн онцлон ярьж буй нь учиртай.

Ойрын өдрүүдэд олны чихийг хангинуулж, зүрхийг дэлсээж буй Оюутолгойн төсөл ирээдүйд өмнийн говьд гэлтгүй Монгол Улсын хөгжилд одоогийн бүтээснээсээ илүү өгөөжийг хүртээх учиртай. Өмнөговийн “үүдэн” хэсэгт байрлах Тус уурхай өнгөрсөн хугацаанд улсын хөгжлийн түшээ болсоор ирлээ.

Олон улсын валютын сан Оюутолгойн уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах үед Монгол Улсын эдийн засаг гуравны нэгээр өсөх боломжтой гэжээ. Уг уурхай 2013 оны долдугаар сард зэсийн анхны баяжмалаа экспортод гаргаж

байсан бол өнгөрсөн онд нэг сая дахь тонн зэсийн баяжмалаа экспортоллоо. Тэгвэл одоо гүний уурхайн бүтээн байгуулалтын ажлын эхлэл тавигдаад буй. Нэг үгээр, Олон улсын валютын сангийн дээрх тооцоолол биеллээ олох үе айсуу. “Оюу Толгой” компани энэ онд 175-195 мянган тонн зэс, 600-700 мянган унци алтны агуулгатай баяжмал үйлдвэрлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Нийслэлээс урагш 550 орчим км, БНХАУ-ын хилээс хойш 80 гаруй км-ын зайд орших Оюутолгойн уурхайн үйлдвэрлэл 2013 онд эхэлснээс хойш улсын эдийн засаг, говь нутгийн хөгжилд багагүй хувь нэмэр оруулжээ. Өнөөдрийг хүртэлх хугацаанд “Оюу Толгой” ХХК нийт 1.3 тэрбум ам.долларыг татвар, роялти болон бусад төлбөрийн хэлбэрээр Монгол Улсын Засгийн газарт төлсөн аж. Улсын төсөвт төлж буй татвар, хураамж нь цаашид тогтвортой өсөх төлөвтэй

байгааг компанийн зүгээс хэлэв.

Энэ төсөлд манай улсын болон олон улсын мэргэжилтнүүд мөр зэрэгцэн зүтгэж байна. “Оюу Толгой” компанийн зүгээс ажиллах хүчээ монгол ажилтнуудаар түлхүү бүрдүүлж, ирээдүйн уурхайчдыг бэлтгэхэд анхаарч буй гэнэ. 2013 оны эцэст тус компанийн нийт ажиллах хүчний 90-ээс дээш хувийг монголчууд эзэлж байсан бол өнөөдөр эл үзүүлэлт 95 хувьд хүрчээ. Тэдний 21.7 хувийг Өмнөговь аймгийн иргэд эзэлж байна.

Өнгөрсөн хугацаанд бий болсон бүтээн байгуулалтуудаас онцолвол, Оюутолгойн уурхайгаас Ханбогд сумын хооронд 7.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 40 км урттай, 35 кВт-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж байгуулан Ханбогд сумыг байнгын эрчим хүчтэй холбосон. “Оюу Толгой” компани Өмнөговь аймагт 40 орчим сая ам.долларын төсөл хэрэгжүүлсэн

бол Ханбогд суманд уурхайн дэд бүтцийг орон нутгийн иргэдтэй хамтарч хийж байгаа. Энэ нь сумын ажилгүй иргэдийн хувьд ажил, орлоготой болох том боломж. Уурхайгаас урд хөршийн хил рүү хатуу хучилттай зам барьсан төдийгүй сумын төвд ч мөн засмал зам тавьжээ. Түүнчлэн нийт 3250 метр урт, 45 метр өргөнтэй “Ханбумбат” нисэх онгоцны буудал барьсныг онцлох нь зүйтэй. Тус нисэх буудал ашиглалтад

оршин суугчдын тоо 4000 дөхөж явна. Энэ нь арав гаруй жилийн өмнөхөөс 10 дахин өссөн дүн юм. “Оюу Толгой” компанид өнөөдөр 4700 гаруй монгол хүн ажиллаж байна.

Оюутолгойн төслийн тогтвортой бас аюулгүй байх хамгийн чухал хүчин зүйл бол орон нутгийн иргэдийн хамтын ажиллагаа. Энэ ч үүднээс иргэдтэй хамтран орон нутгийн хөгжилд тодорхой дэм үзүүлж явна. Компанийн


“Оюу Толгой” компанийнхны хувьд хамгийн чухал бүтээн байгуулалтын ажил нь тэд орон нутгийн иргэдтэй урт хугацааны тогтвортой хөгжлийн Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан явдал. Уг компанийн удирдлагууд Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдын дарга нартай уг гэрээг үзэглэсэн. Гэрээний хүрээнд “Оюу Толгой” ХХК “Хөгжлийг дэмжих сан”-гаар дамжуулан орон нутагт жил бүр таван сая ам.долларын хөрөнгө оруулалтыг 30 жилийн хугацаанд хийх үүрэг хүлээгээд байна.

Уг гэрээ нь орон нутгийн эдийн засгийн хөгжил, нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах зэрэг асуудалд голчлон чиглэж байгаа аж. “Оюу Толгой” ХХК 2015 оны нэгдүгээр улиралд гэхэд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, орон нутгийн дэд бүтэц, бэлчээрийн менежмент болон хуучин худгийг сэргээх зэрэг ажилд 280 мянга орчим ам.доллар зарцуулжээ. Ойрын ажлаас нь дурьдвал өнгөрсөн сарын 25-нд тэд Ханбогд суманд иргэдийн хөгжлийн төв барьж байгуулснаа хүлээлгэн өглөө.

Оюутолгойн уурхайн төслийн өгөөжөөс Монгол Улсад оруулсан хамгийн том бүтээн байгуулалт боловсролын салбарт чиглэсэн. Энэ нь Мэргэжлийн боловсон хүчнийг дэмжих 126 сая ам.долларын өртөг бүхий төсөл юм.

Уг төслийн хүрээнд Ханбогд сум болон Нийслэлийн Налайх дүүрэгт Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг шинээр байгуулжээ. Мөн Даланзадгад, Эрдэнэт, Улаанбаатар, Дархан, Чойр хотууд дахь мэргэжлийн боловсролын сургуулиудын сургалтын тоног төхөөрөмж, хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад зориулан хөрөнгө оруулсан байх жишээтэй. Тус компани мэргэжлийн боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийж, олон улсад өрсөлдөхүйц, чадварлаг мэргэжилтэн бэлтгэхийг чухалчилж буйн илрэл энэ юм. Тэд энэхүү төслийн үр дүнг энэ онд тайлагнах аж.

Энэ мэт онцлом бүтээн байгуулалтыг Оюутолгой төсөл бидэнд хүлээлгэн өгөөд байна. Уг төслийн цаашдын өгөөж Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөд тодорхой жин үзүүлэх нь дамжиггүй. ■



2015 оны I улиралд боловсрол сургалтын хөтөлбөрт 744.000 ам.доллар зарцуулав.



2015 оны I улиралд орон нутгийн тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдэд 278.800 ам.доллар зарцуулав

орсноор ханбогдчууд, уурхайн ажилчид сумынхаа хаяанаас агаарын хөлгөөр Улаанбаатарыг зорих болсон.

Өмнийн говийн Галбын элсэнд буурилсан ханбогдчууд уурхай дагасан хөгжлийг мэдэрч яваа улс. Одоогоос гурван жилийн өмнө эдийн засагч Д.Жаргалсайхан “Өмнөд бүсэд дэд бүтэц болоод хүн амын шинэ соёл, иргэншил бий болно. Тиймээс бидний хандах чигээс хамаарч уул уурхайг дагасан тогтвортой хөгжил бий болох боломжтой” гэж байсан. Тэгвэл өнөөдөр эл бүсэд хүн амын шинэ иргэншил хэдийн бүрдэж эхэлж. Үүнийг нотлох баримтуудаас нэгийг дурьдахад энэ оны эхний улирлын байдлаар Ханбогд сумын өрхийн тоо 1700 орчимд хүрсэн бол

удирдлагуудаас Оюутолгой төсөл орон нутагт хэчнээн төгрөгийн бүтээн байгуулалт хийсэн талаар тодруулахад “Бид хийсэн бүтээснээ мөнгөн дүнгээр үнэлж хэлэх дургүй” хэмээсэн юм. Тэдний хувьд алив хийж буй бүтээн байгуулалтаа орон нутгийн болон Оюутолгойн тогтвортой хөгжлийн галд тос болохуйц гэж үзэн холч ухаанаар ханддаг гэнэ. Учир нь Оюутолгой бол өнөөдөр, маргаашийн тухай биш урт хугацаанд хэрэгжих төсөл. Тиймээс тэд төслийн өгөөжөөр босч буй бүтээн байгуулалтуудыг зоосны нүхээр харж хийдэггүй аж. Товчхондоо, бидний харж буй боломжийн цаана орших бүтээн байгуулалтууд хөгжлийн хэтийн зорилго агуулдаг байна.

## “Эрдэнийн говь”-ийн эзэд ийн ярьж байна

“Оюу Толгой” компани өнгөрсөн онд үндэсний 800 гаруй ханган нийлүүлэгчтэй хамтран ажиллажээ. Түүнчлэн 457 сая ам.долларын дотоодын худалдан авалт хийсэн нь үйл ажиллагааны нийт зардлын 77 хувь болж байгаа юм. Үүний 301 сая ам.доллар буюу 51 хувийг үндэсний ханган нийлүүлэгчдэд зарцуулжээ.

Өмнөговь аймагт хийсэн худалдан авалтын дүн 2010 оныхоос 28 дахин өсч, өнгөрсөн оны эцэст 42 сая ам.долларт хүрсэн байна. Тус компанид бараа, үйлчилгээ ханган нийлүүлдэг өмнийн говийн аж ахуйн нэгжийн тоо жилээс жилд нэмэгдэж өнгөрсөн оны эцсийн байдлаар

42.5 сая ам.долларт хүрчээ. Тэд уг үзүүлэлтийг энэ онд 60 сая ам.долларт хүргэхийн зорьж байгаа аж.

“Оюу Толгой” компанийнхан шилдэг ханган нийлүүлэгчдийг тодруулдаг “Эрдэнийн говь” арга хэмжээг энэ онд зургаа дахь удаа зохион байгуулсан билээ. Амжилт бүтээл, нийгмийн хариуцлага, бизнесийн өсөлт хөгжил болон нийлүүлэлтийн сүлжээг сайжруулсан байдал зэргийг харгалзан орон нутгийн шилдэг ханган нийлүүлэгч болон шилдгийн шилдгүүдийг шалгаруулдаг уламжлал хэдийн тогтжээ. Тус компанийн шилдэг ханган нийлүүлэгчдийн сэтгэгдлийг уншигч танд хүргэж байна.

*Ж.Түмэн-Аюуш /“Хасу-Мегаватт” компанийн ерөнхий захирал/:*

- Манайх анх эрчим хүчний чиглэлээр ажилладаг, улирлын чанартай үйл ажиллагаатай компани байсан. “Оюу Толгой” компанитай хамтран ажилласнаар байнгын ажилтай боллоо. Манай хамт олон үйл ажиллагаагаа олон улсын стандартад нийцүүлэн гүйцэтгэж ирсэн нь энэ компанитай урт хугацаанд хамтран ажиллах нэг үндэс болсон гэж боддог. Оюутолгойгоор дамжуулан Өмнөговь аймгийн “Говь Уран Шаглаа” оёдлын компанитай хамтран ажиллаж, уурхайн ажилтнуудад ажлын хувцас хийлгэсэн. Цаашдаа компанийнхаа бусад салбарт ажиллаж байгаа хүмүүст ч ажлын хувцас захиалан хийлгэх төлөвлөгөөтэй байгаа төдийгүй Монгол компаниуд бие биенээ дэмжин ажиллахыг зөв гэж боддог. Бид 2013 онд шилдгийн шилдэг ханган нийлүүлэгчээр тодорсон. Оюутолгойн уурхайд 72 мВт-ын усан халаалтын дулааны станц, дизель цахилгаан үүсгүүр болон дулааны шугам сүлжээний ашиглалтыг хариуцан гүйцэтгэдэг.



*Д.Ганбат /“Мехлопат” компанийн гүйцэтгэх захирал/:*

-Манай компани 2010 оноос эхлэн “Оюу Толгой”-д бүтээгдэхүүн нийлүүлэн хамтран ажиллаж байна. Зарласан тендерт нь шударгаар өрсөлдөж шалгараад л ийм үүрэг хүлээж байгаа. Дэлхийн хэмжээний том уурхайд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нийлүүлснээр тэднээс маш их зүйл сурч байна. Аюулгүй ажиллагаа, засаглалын хувьд цэвэр байх, нийгмийн хариуцлагыг эрхэмлэх, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар гээд тоочвол зөндөө юм бий. Оюутолгойнхон ч үндэсний ханган нийлүүлэгчдийг байнга дэмжиж ажилладаг нь сайхан санагддаг. Тийм ч учраас тэдэнтэйгээ нягт хамтарч, харилцан ойлголцож, итгэлийг нь биелүүлэхийг хичээдэг.



*П.Мягмарсүрэн /“Бамбай” секьюрити сэрвис ХХК-ийн дэд захирал/:*

-Манай компани 2013 онд аюулгүй ажиллагааг эрхэмлэгч шилдэг ханган нийлүүлэгчээр шалгарсан. Өөрийн сургалтын төвдөө Монгол Улсын “Гэрээт харуул хамгаалалтын тухай” хуулийн хэрэгжилтээс гадна аюулгүй үйл ажиллагааны сургалт явуулдаг. “Оюу Толгой” компанийн аюулгүй ажиллагааны сургалт хоёр жилийн өмнөөс нэмэгдсэн. Үүгээр энэ компанид мөрдөгдөх дотоод журам, аюулгүй ажиллагааны талаар сургалт явуулж, албан ёсоор шалгалтад тэнцсэн хүмүүсээ “Оюу Толгой” компанийн ханган нийлүүлэгч байгууллагын мэдээллийн санд бүртгүүлж байж уурхай руу явуулдаг. Бид тус компанитай 2002 оноос хамтран ажиллаж байна. Бид маш их зүйл сурсан. ■





**USAID**  
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



**WAGNER**  
ASIA EQUIPMENT LLC



**QSDC**  
БИД ТАНЫ БИЗНЕСИЙН АМЖИЛТАД  
ХӨРӨНГӨ ОРУУЛНА

# “АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ОЛОН УЛСЫН СЕРТИФИКАТ ОЛГОХ СУРГАЛТ.

Сургалт болохоос 10 хоногийн өмнө төлбөрөө төлсөн тохиолдолд 10% хөнгөлөлттэй  
Нэг байгууллагаас 3 буюу түүнээс дээш хүн оролцвол 20% хөнгөлөлттэй  
Нэг байгууллагаас 6 буюу түүнээс дээш хүн оролцвол 30% хөнгөлөлттэй

**ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

**ЧАНАРЫН УДИРДАГЫН  
ХӨТӨЛБӨР**



CIEH

Accredited training centre

Сургалт болох хугацаа:  
2015 оны 6 сарын 29- нөөс  
7 сарын 01 өдөр

Сургалтын төлбөр:

**300.000 ₮**

Бүртгэл авах хаяг:

Утас: 32 13 17; 8949-2828,  
Имэйл: [dolgorsuren@qsdс.mn](mailto:dolgorsuren@qsdс.mn)

**БИД ТАНЫ БИЗНЕСИЙН  
АМЖИЛТАД ХӨРӨНГӨ  
ОРУУЛНА**



## Алдсан боломж

Оюутолгойн ил уурхайн олборлолт ид өрнөж, үүнийхээ үр дүнг урд хөршид нийлүүлж эхэлсэн билээ. Харин 80 хувь нь газрын гүндээ бий гэх тус ордын гүний уурхайн бүтээн байгуулалтын хоёр дахь шатны санхүүжилт зогсоод хоёр жилийг ардаа орхисон. Ийн гацаж, царцалгүй үргэлжилж байсан бол Монголын эдийн засаг өдгөө хэрхэх байсныг тооцоолон үзье.

Өнгөрсөн онууд буюу 2013-2014 онд Оюутолгойн төсөл хоёр тэрбум ам.доллар зарцуулах байж. Ийм хэмжээний мөнгөн дүн эдийн засагт ямар эерэг үр дүн авчрах байсан нь тодорхой аж. Тухайлан хэлбэл, татвар хэлбэрээр төсөвт орох мөнгөний урсгал нэмэгдэх байжээ. Ингэснээр хамгийн наад зах нь төсвийн гэх тодотголтой ажилчид цалиндаа санаа зоволгүй цаг тухайд нь хөдөлмөрийнхөө хөлсийг аваад суух байлаа. Цомхотгол гэх айдасгүй ажилдаа шамдах байсан гэх. Ажилтай бол орлоготой. Тиймд тэд худалдан авалт хийх замаар дотоодын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчдээ дэмжиж, улмаар эдийн засагт эерэг нөлөө шууд мэдрэгдэх учиртай байсанж.

Цаашилбал, төслөөс зарцуулах байсан нэг тэрбум ам.долларын 553 саяыг нь эдийн засаг руу “цутгах”, үүний 40 хувийг дотоодын ханган нийлүүлэгчдээр дамжин зах зээлийн эргэлтэд орох байсныг бид мөн л алдаж орхисон. Мөн ханган нийлүүлэгч компаниудын ажилчдаас татвар хэлбэрээр хүртэх байсан 90 орчим



сая ам.доллараар улсынхаа төсвийг арившуулах боломжтой байв.

Энэ мэтээр эдийн засгийн эргэлтэд орох байсан 1.55 тэрбум ам.доллар тус төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт гацсанаас болж өдгөө монголчууд бүсээ эцэст нь тултал чангалах хэрэгтэй болсон юм. Түүгээр ч зогсохгүй жилд дунджаар 500 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх байтал үүнээсээ ч мөн “сайн дураараа” татгалзжээ. Түүнчлэн ДНБ-ий 4-5 хувьтай дүйх хэмжээний өгөөж хүртээх шинэ бизнесүүд цэцэглэх байсныг дурьдвал халаглахаас өөр хэлэх үг үлдэхгүй болов. Маргаж суусаар бид өнгөрсөн хоёр жилийн дотор ийм боломжуудад “Баяртай” гэж хэлсэн байгаа юм.

Монгол руу чиглэсэн том хөрөнгө оруулалт хүлээлтийн горимд шилжихээд байгаа. Тэд Оюутолгой тэргүүтэй томоохон төслүүд урагшлах эсэхийг харж суугаа.

Монгол Улсын зээлжих зэрэглэл хөрөнгө оруулахад өндөр эрсдэлтэй гэсэн ангилал руу гулссан. Уруудах тусам Монголын компаниудын гадаад зах зээлээс мөнгө босгох боломж хумигдана. Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авах талаар санахын ч эцэсгүй болно. Зээлжих зэрэглэлээ ахиулвал олон улсын зах зээлээс хямд хүүтэй мөнгө босгож эдийн засгаа тэтгэх боломж бий. Ингэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатайг эдийн засагчид дуу нэгтэй хэлсээр ирсэн. Үүнийг биелүүлэх ойрын гарц нь мега төслүүдээ хөдөлгөх ажээ.

Хэрэв төслүүд явахгүй гацсаар байвал 2017 онд эргэн төлөгдөх ёстой “Чингис бонд”-ын төлбөр биднийг боомилох аж. Урдаа барих төслөө аль болох түргэн хөдөлгөвөл тавьсан өрөө эргэн төлөх цаг ирэхэд төсөвт дарамт учрахгүй гэдгийг гадна, дотны шинжээчид сануулсаар байна. ■



## АЛДАГДСАН БОЛОМЖ: 2013, 2014 (2 жил)



**ШУУД ӨГӨӨЖ**  
**610,0**  
тэрбум төгрөг



315,0 мянган  
төгрөгийн дундаж  
цалингаар бодоход

**50,000**

БАГШИЙН 3 ЖИЛ 3  
САРЫН ЦАЛИН

**ШУУД БУС ӨГӨӨЖ**  
**1,800**  
тэрбум төгрөг




315,0 мянган  
төгрөгийн дундаж  
цалингаар бодоход

**50,000**

БАГШИЙН 9 ЖИЛ 6  
САРЫН ЦАЛИН

**ДАМ ӨГӨӨЖ**  
**900**  
тэрбум төгрөг



315,0 мянган  
төгрөгийн дундаж  
цалингаар бодоход

**50,000**

БАГШИЙН 4 ЖИЛ 9  
САРЫН ЦАЛИН



207,000  
төгрөгийн  
тэтгэврийн  
доод  
хэмжээгээр  
бодоход

**200,000**

ХҮНИЙ 1 ЖИЛ 3  
САРЫН ТЭТГЭВЭР



207,000  
төгрөгийн  
тэтгэврийн  
доод  
хэмжээгээр  
бодоход

**200,000**

ХҮНИЙ 3 ЖИЛ 7  
САРЫН ТЭТГЭВЭР



207,000  
төгрөгийн  
тэтгэврийн  
доод  
хэмжээгээр  
бодоход

**200,000**

ХҮНИЙ 1 ЖИЛ 10  
САРЫН ТЭТГЭВЭР



**359**  
СУРГУУЛЬ БУЮУ ЦЭЦЭРЛЭГ



**1200**  
СУРГУУЛЬ БУЮУ ЦЭЦЭРЛЭГ



**600**  
СУРГУУЛЬ БУЮУ ЦЭЦЭРЛЭГ



**20**  
500 ОРТОЙ ЭМНЭЛЭГ



**60**  
500 ОРТОЙ ЭМНЭЛЭГ



**30**  
500 ОРТОЙ ЭМНЭЛЭГ



ТӨСӨӨЛӨЛ

## Эмээ ба Оюутолгой

Э.Зоригт

Эмээгийн хэлснээр Оюутолгой, Тавантолгой гэж хоёр золиг хар, цагаан хэл аманд ороод үйлс нь хазайгаад байгаа аж. Тийм болохоор л хоёр толгойн нэрээр оролдсон хэн гэдэг аавын, ямар сайн хүү байлаа ч буруудаж таараад байгаа гэнэ. Хөгшин эмээгийн минь ингэж бодох нь ч аргагүй биз. Зурагт асаасан ч, радио чагнасан ч, сонин сэтгүүл эргүүлсэн ч толгой тойрсон хэрүүл уруул, хэлцэл талцал сонссор байгаад чих шуугиж, дотор мүүхайртал ярьж байгаа юм чинь. Арга ядахдаа эмээ минь "Хүү минь, чи тэр хэл

амтай хоёр толгойгоос холуур яваарай. Сайд, дарга байсан хүмүүс ажилгүй болоод байхад чи бол бүр бүтэхгүй" гэх вэ дээ. Эмээгийнхээ захисныг бодохоор Оюутолгой, Тавантолгойн талаар бичмээргүй л байна. Гэхдээ Оюутолгойтой биш Оюутолгойгүй Монголын талаар бичих гэж байгаа болохоор нөгөө айхтар хэл ам нь намайг тойроод гарах байх аа.

За тэгэхээр Оюутолгойгүй Монголын талаар төсөөлөөд үзье. Юуны түрүүнд Оюутолгойн тухай ярьдаг олон толгой байхгүй байх байлаа. Олон толгой

байхгүй болохоор энэ олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэдэн толгойн талаарх мэдээллийг улиг болтол нь давтаад байхгүй, бидний чих амрах байсан биз ээ. Олон улстөрч хийх ажил, ярих зүйлгүй фэйсбүүк, твиттер ухаад л өөр хоорондоо селфи хийгээд суух байсан даа. Юун нөгөө Моды, Абетэй манай Элбэгээ Ерөнхийлөгч селфи хийх. Энэ хоёр толгой байгаагүй бол тэд манай орныг бараг зорих ч үгүй байсан гээд хэлчихэд буруудахгүй биз. За тэгээд Ганбаатар гэдэг хүн УИХ-ын гишүүн биш Үйлдвэрчний эвлэлийн



хувьд хүрэхэд нөгөөдүүл чинь албан тушаал ахих нь ахиад Австрали, Америк руу сурахаар, зугаалахаар явсан.

Өнгөрсөн оны эхэнд ДНБ-ий хэмжээ 17.6 тэрбум төгрөгт хүрч нэг хүнд ногдох хэмжээ 6.5 сая төгрөг боллоо гэх сургаар миний танилуудын ихэнх нь орон сууцанд орж, ухаалаг утас, машинаар гангараад авлаа. Юмтай хүн юмаараа гайхуулна гэгчээр найз нөхөд, хамаатан садангууд намайг “Уурхайчин эсвэл барилгачин бол тэгвэл чи. Орох орон, оочих аяга, хөл дүүжлэх унаатай болно. Намайг хар л даа” гэж ятгалаа. Ятгалаганд нь яг ордгийн даваан дээр Оюутолгой, Тавантолгой гацаж эдийн засгийн өсөлт саарч, эгч ах нарын маань ихэнх нь ажилгүй, орон сууцны зээлтэй болоод үлдлээ.

Тэгэхээр өнгөрсөн хэдэн жилийн эдийн засгийн өндөр өсөлт, уул уурхайн салбарыг чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдсэн, Оюутолгой, Тавантолгой зэрэг том ордыг ашиглаж эхэлсэнтэй шууд холбоотой гэдэг нь тэнэг хүн бодсон ч ойлгомжтой байгаа юм. Яах вэ үүнийгээ тоогоор батал гэвэл 2011 онд 4,17 тэрбум ам. долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсний 80 орчим хувь нь уул уурхайн салбарт зарцуулагдсан гэдгийг дурьдахад хангалттай байх.

Монгол Улсын эдийн засаг 2019 он хүртэл дээд хурдаараа урагшлах бөгөөд үүний шатахуун нь Оюутолгой байх юм хэмээн эдийн засагчдын таамаг зөв байсныг цаг хугацаа биш улстөрчдийн шийдвэр батлав. Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын талаарх улс төрийн гэрээ хэлэлцээрийн тодорхой бус байдал Монголын эдийн засаг руу орж ирдэг хөрөнгө оруулалтын урсгалыг зогсоосон.

Товчхондоо, эдийн засаг шатахуунгүй болчихсон. 2012 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 17 хувиар, 2013 онд 47 хувиар, 2014 оны эхний хагаст 64 хувиар тус тус буурсан нь эдийн засаг хүндрэх шалтгаан болсон. Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурснаар эдийн засаг руу дотогшлох гадаад валютын урсгал багасаж, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж, эдийн засгийн гадаад тэнцвэрт байдал алдагдаж эхэлсэн.

Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын хурд саарснаас үүдэж энэ салбартай холбоотой олон салбарын өсөлт саарсан. Энэ нь худалдаа, барилга болон боловсруулах салбарын хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нэмэгдэж байгаагаас харагдаж байна. Үүнийг нь ах, эгч маань амьдралаараа баталж байгаа юм. Ахын оруулж ирдэг машин, эгчийн ажилладаг компанийн орон сууц зарагдахаа больсон. Шалтгаан нь уурхайчин залуус ажилгүй, цалингүй болж орон сууц, автомашин авах нь бүү хэл өнөө маргаашийн талхаа яая гэж байна цаана чинь. Хөөрхий ах, эгч хоёр минь тааз ширтэнгээ энэ “Оюутолгой, Тавантолгойгоо хөдөлгөдөг болоосой. Утсаар ирсэн санал асуулгад нь том төслүүдээ хөдөлгөе гээд санал өгсөн дөө” хэмээн уруу царайлдаг болсон. Эгч урд нь угаагч хийдэг байсан “Irish pub”-д угаагчаар ажилд орох гэтэл “Оюутолгой гацсанаас болоод байнгын үйлчлүүлдэг байсан гадаадууд нутаг буцаад орлогогүй болсон. Чамайг ажилд авах нь бүү хэл, түрүүсээ яаж байна” гэжээ.

Үр хүүхэд, ач зээгээ эрхэлсэн ажилгүй санааширч суугаад эмээ минь халаглаж, цайны дээж өргөхдөө “Дөрвөн зүг, найман зовхис минь хэл амтай хоёр толгойн асуудлыг аврал энэрэлдээ багтааж хайрла. Төрийн минь сүлд өршөө” хэмээн үгэлж сонсогдсон. Эмээгийн өргөсөн цайны дээж эзэндээ хүрч төрийн сүлд нь өршөөсөн үү яасан Оюутолгой урагшилж байгаа тухай сайхан мэдээ гарлаа. Ажилгүй ахан дүү нар маань “гоё дээрээ тавиад” сэтгэл нь сэргэхчхэн “Удахгүй ажилтай болох нь дээ” гэж байна. УИХ-ын гишүүн Г.Баярсайхан хүртэл “Оюутолгойд ажиллаж байсан Чингэлтэй дүүргийн залуус эргээд сая гаруй төгрөгийн өндөр цалинтай ажилдаа буцаад орох нь. Оюутолгой урагшилсны эерэг талыг хамгийн энгийнээр ингэж харж байна” гэв.

Оюутолгойгүй Монголын талаар төсөөлөх нь бүү хэл Оюутолгой нь гацсан Монголын талаар өгүүлэхэд л ийм байна. Тийм болохоор нэгэнт эхлүүлсэн том төслүүдээ хэрүүл уруулгүй хоёр тал харилцан ашигтай урагшлуулаач ээ. Эс бөгөөс эмээдээ хэлж дахиад цайны дээж өргүүлдэг ч юм билүү. ■

дарга хэвээрээ л байж мэдэх юм. Ер нь Ганбаатар гэлтгүй манай эгч Оюун-Эрдэнэ барилгын компанийн маркетингийн менежер биш, цайны газар угаагчаараа, Энхдэлгэр ах минь машин зардаг биш засдаг хэвээрээ л байх байсан биз ээ. Ийнхүү таамаглаж буй нь учиртай. Учир нь 2009 онд эдийн засгийн бодит өсөлт сөрөг 1.3 хувь байсан. Эдийн засгийн өсөлт ийм байхад ах маань засварчин, эгч маань угаагч байсан юм. Гэтэл Оюутолгойн сургаар 2010 онд манай ДНБ-ий бодит өсөлт 6.4 хувиар нэмэгдэхэд ах маань машин зардаг бизнесмэн, эгч минь маркетингийн менежер боллоо. Ах, эгч гэлтгүй хамаатан садны олон залуус уурхайчин эсвэл барилгачин болж цалин мөнгөтэй залгасан юмдаг. Харин арай сүйхээтэй нь бизнесмэн болоод авсан. 2010-2014 оны хооронд эдийн засгийн бодит өсөлт дунджаар 13.6



ТОМИЛОЛТ

Варшав хот

## Монголыг ажиж суугаа Европын “акулууд” ингэж хэлэв

Г.Орхон

“Тэр олон уурхай, үйлдвэр нь хаана байна” гэж асуумаар Польш улсын өмнөд хэсэгт орших Катовице хотын өнөөгийн төрх уурхай байдаг газар гэсэн шиг уул мэт овоолсон шороо, том үйлдвэрүүд энд бараг үзэгдэхгүй. Гагцхүү хаашаа л харна өнгө өнгийн цэцэгс, ногоон модод харагдах тул хотод биш ой модон дунд байна уу гэлтэй. Нэг тэрбум орчим тонн нүүрсний нөөцтэй, машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэлээрээ дэлхийд танигдсан Польш орны хамгийн хурдацтай хөгжиж буй энэ хотод манай улсын уул уурхайн салбарынхан тус орнын бизнес эрхлэгчидтэй өнгөрсөн сард уулзаад ирлээ.

Нийслэл Варшаваас 290 гаруй км-ийн зайд орших тус хотод биднээс гадна Македон, Индонез болон Вьетнамаас

төлөөлөгчид очив. Эдгээр улсын нийт 24 бизнес эрхлэгч болон Польшийн 40 гаруй үйлдвэрлэгчийг тус улсын Эдийн засгийн яамнаас хэрэгжүүлж буй “Зах зээлийн экспортын сэргэлт” нэртэй хөтөлбөр ийн нэгтгэлээ.

Польшийн экспортыг нэмэгдүүлэхэд чиглэж буй эл хөтөлбөрөөр дамжуулан энэ онд тэд 11 улстай илүү нягт хамтарч ажиллахаар болсон бөгөөд үүний нэгээр манай улсыг сонгожээ. Энэ хүрээнд Польшийн тал хоёр улсын хүнс болон уул уурхайн салбарын худалдаа, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг сайжруулахыг зорьж буй. Өнгөрсөн оны байдлаар Польшоос Монгол руу 35 сая еврогийн экспорт хийсэн бол тус улсын нийт импортод 68 мянган еврог манайх нийлүүлжээ. Тэдэнд уг үзүүлэлт чамлалттай байгаа

бөгөөд Польшийн Эдийн засгийн яамныхан нь дээрх зөрүүг аль болох багасгахын зорьж байгаагаа ярьсан.

Уг хөтөлбөрийн хүрээнд хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарынхан дөрөвдүгээр сард уулзсан бол энэ удаа уул уурхайнхан нэгдэв. Катовице хотод орших “Miedzynarodowe” олон улсын хурлын төв ордонд цугласан Польшийн бизнес эрхлэгчдийн алсын хараа Монголын зүгт чиглэжээ. Польшт нэг үе олборлолт явуулж байсан хэд хэдэн уурхайн үйл ажиллагааг зогсоосон. Учир нь, гүний уурхайн олборлолтоор дэлхийд дээгүүрт ордог тус улсын уурхайчид тухайн үеийн тоног төхөөрөмж дийлэхээргүй гүн үхжээ. Гэвч сүүлийн жилүүдэд үйлдвэрлэгчид илүү гүнд ажиллах хүчин чадалтай машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэн,

тэдгээр хаасан уурхайг дахин ашиглаж эхэлсэн байна. Тэдний бүтээл илүү ухаалаг, автомат нөгөө талаар хуучны чанар сайтай, хэрэглэхэд хялбар тал руу чиглэж байгаа гэнэ. Уул уурхайн тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр улсдаа төдийгүй Европын зах зээлд аль хэдийн хөлөө олсон Польш улсын үйлдвэрлэгчид ийн ярьж байна.

**Кшиштоф Каркошка /Krzysztof Karkoszka "Karbo" компанийн маркетингийн захирал/:**



-Бид гүний уурхайн дэлбэрэлтээс сэргийлсэн цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг. Монгол компанитай хамтарч өөрсдийн бүтээгдэхүүнээ танай улсад үйлдвэрлэх сонирхолтой байна. Учир нь эндээс бараа, бүтээгдэхүүнээ байнга зөөх боломжгүй. Казакстан, Орос улсаас илүү Монголыг сонирхож байгаа. Учир нь танай оронд уул уурхай илүү хөгжинө. Манай компани энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр Польшийн зах зээлийн 65 хувийг эзэлдэг. Гүний уурхайн дэлбэрэлтээс сэргийлсэн цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр Вьетнам, Аргентинийн зах зээлийн 50, Украины 20 хувийг эзэлж байна.

**Богдан Кулиш /Bogdan Kulisz "Trans Tel" компанийн ерөнхийлөгч/:**



-Манай компани гүний уурхайд зориулсан мэдээлэл дамжуулах радио

системийг 25 дахь жилдээ үйлдвэрлэж байна. Португал, Турк зэрэг оронд нийт долоон уурхайд манай бүтээгдэхүүнийг хэрэглэж байна. Мөн Англи, Германын компаниудтай хамтарч ажилладаг. Монголын хувьд энэ анхны уулзалт. Бид мөн Туркийн улсын гэрэл үйлдвэрлэгч компаниудтай хамтын ажиллагаатай. Манай үйлдвэрлэж буй гэрэл байршил тогтоох системтэй. Саяхан Польшийн нэг уурхайд метан дэлбэрэхэд тухайн уурхайн ажилчдыг хайж олох гэж томоохон асуудал үүссэн. Харин манай үйлдвэрлэж буй гэрлийг авч явж буй уурхайн ажилтныг хаанаас ч олох боломжтой. Вьетнамын зах зээлд орохын тулд бид таван жилийг зарцуулсан. Монгол Улстай хамтарч ажиллахад энэ хугацааг туулах байх гэж бодож байна. Гэхдээ богино хугацаанд Монголын зэх зээлд нэвтрэхийг хүсч байгаа.

**Валдемар Миклер /Waldemar Mikler "Niwka" компанийн Маркетинг судалгааны дарга/:**



-Монголыг дөнгөж сонирхож эхэлж байна. Бид Хятад, Латин Америк, Колумб болон Европын орнуудын зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. Өмнө нь Вьетнам руу бүтээгдэхүүнээ нийлүүлдэг байсан ч хоёр талын харилцаа нэг үе тасарсан. Энэхүү холбоог дахин сэргээж байгаа. Манайх гүний уурхайн машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг, 180 жилийн түүхтэй. Эдгээрээс зөвхөн газрын гүн дэх хоолойгоор олборлож буй таваарыг татаж авдаг машины үйлдвэрлэлээр гэхэд Польшийн зах зээлийн зуун хувийг эзэлдэг. Нийт 20 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Бид үйлчилгээний компаниа Монголд нээх сонирхолтой байгаа.

**Роберт Злезарчик /Robert Zlezarczyk "TF Kable" компанийн Борлуулалтын**

**албаны дарга/:**



-Манайх кабель үйлдвэрлэлээрээ Европтоо гуравдугаарт ордог. Польшид дөрөвт, Украин болон Сербид тус тус үйлдвэртэй төдийгүй нийт 3000 ажилтантай. Сард дунджаар уул уурхайн зориулалттай 60-100 км кабел үйлдвэрлэж байна. Жилд 800 сая еврогийн нийлүүлэлт хийдгээс 60 орчим хувийг нь экспортолдог. Бид Оюутолгойн уурхай руу эхний хоёр км кабелийг нийлүүлсэн. Уг кабель харанхуйд гэрэлтдэг бөгөөд ил уурхайд түлхүү хэрэглэдэг юм. Монголын "My Mon Source" гэх компанитай хамтарч ажиллаж байгаа.

**Рафал Зарзуски /Rafal Zarzycki "Gonar" компанийн ТҮЗ-ийн дэд захирал/:**



-1974 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй манай компани гүний болон ил уурхайн туннел барих, өрөмдлөгийн үед хэрэглэдэг төрөл бүрийн тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг. Норвеги, Швед, Чех тэргүүтэй Европын ихэнх оронд бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. Бид тоног төхөөрөмжөө Азид зөвхөн Вьетнам руу оруулж байгаа бөгөөд Монголын зах зээлд нэвтрэх тодорхой алхам хийгээгүй байна. Судалж байгаа. Манай компанийн бараа, бүтээгдэхүүн Польшийн уул уурхайн зах зээлийн 80 хувь, зам, барилгын 50 орчим хувийг эзэлдэг. ■



ТЕМАСЕК

Сингапур улс

## Өмчийг үржүүлэх ухаан

А.Бүрэнжаргал

Хөгжиж буй болон өндөр хөгжилтэй улсууд хэдэн мянган компанийг хувьчилж ирсэн түүхтэй. Тухайлбал, ОХУ-т бүх компани төрийн мэдлийнх байсан бол одоо цөөн хэд нь л төрийн мэдэлд үлдэж. Харин /Хятадын улсын үйлдвэрүүд ойролцоогоор 20 мянгад хүрч буурсан гэсэн тоо байна/ өндөр хөгжилтэй гэгдэх Австрали, Канад, Япон, Их Британи, Францад зуун хувь төрийн мэдлийн болон төрийн хагас хяналттай компанийн тоо 100 гаруй байсан бол 10 хүртэл цөөрчээ. Тэгвэл урд хөршийн улсад данстай хөгжлийн гараанд яваа орнуудад төрийн өмч ноёрхож байгаа талаар “Форбес” сэтгүүлийн саяхны нэгэн судалгаанд дурьджээ.

Энэ замналаар манай улс ч явж буй. Монгол Улсын хувьд төрийн өмчийн компани гэхээр алдагдалтай ажилладаг, үйлчилгээ тааруу, хүнд сурталтай гээд муу цол, муухай гүншин ихтэй. Төрийн өмчит компаниудын дийлэнх нь ашигт ажиллагаа бага байдаг учир төсвийн татаасаар “амьдарч” ирсэн. 2012 оны гүйцэтгэлээр манай улсын төрийн өмчийн компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 12 их наяд төгрөг байх атал нийт өгөөж нь нэг хувь хүрээгүй талаар статистик мэдээлэлд дурьджээ. Үүнийг өөрчлөхийн тулд салбар бүрт шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдүүлж, тодорхой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэйг мэргэжилтнүүд

зөвлөсөөр байгаа. Төрийн өмчит компаниудын засаглал бизнесийн зарчимд суурилсан, тэдгээр компани төрөөс онцгой эрх эдэлдэггүй, үндсэн үйл ажиллагаа нь төрд үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэггүй байхад орших ёстой аж. Гэтэл манай улсад энэ жишиг олон талаар дээрх ойлголтоос зөрдөг. Тэгэхээр төрийн өмчийн тогтолцоонд баримтлах гол зарчим нь бизнесийн зарчимд суурилсан бодлого хэрэгжүүлж, төрийн өмчийн тогтолцоонд шинэчлэл хийх асуудал тэргүүн зэргийн зорилт болжээ. Эдгээр бэрхшээлийг давж, санхүүгийн төв болж чадсан Сингапур улсын “Темасек Холдингс” корпорацийн өдөр тутмын үйл ажиллагаандаа баримталдаг зарчмыг нэвтрүүлж

ажиллах талаар манай төрийн өмчийн компаниуд туршлага судалсаар буй. Учир нь “Темасек Холдингс”-ийн засаглалын бүтэц Монголд тохирч, илүү сайн нутагшина гэж шийдвэр гаргах түвшний хүмүүс үзжээ.

Олон улсын туршлагаас харахад төрийн өмч үүсэх хоёр шалтгаан байдаг аж. Тодруулбал, стратегийн ач холбогдолтой салбар, зүй ёсны монополь тогтсон эдийн засгийн салбарт төрийн өмчит компани зонхилдог гэнэ. Түүнчлэн тухайн салбарын технологийн онцлогоос үүдэн тус салбарт хоёр компани байснаас нэг томоохон компани байхад илүү ашигтай ажиллах боломж бүрддэг. Нөгөөтэйгүүр, тухайн улсад стратегийн



Тухайн улсын 10 том компанийн төрийн өмчийн эзлэх хувь

Эх сурвалж: Ковалски болон бусад судлаачид (2013)

ач холбогдолтой салбарт төрийн өмч үүсэх боломжтой. Жишээлбэл, батлан хамгаалах, газрын тос, хий, нүүрс гэх байгалийн нөөцийн ашиглалт мөн олборлолтын салбар байж болно. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын судлаачид “Форбес” сэтгүүлийн жагсаалтад багтсан дэлхийн 2000 том компани, тэдгээрийн 330 мянган салбар нэгжээс судалгаа авч төрийн өмчит компани ямар байр суурьтай байгааг судалжээ. Ингэснээр тэдгээрийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлох оролдлого хийсэн байна. Төр шууд болон шууд бус замаар хувьцааны 50.01 хувийг эзэмшдэг компанийг төрийн өмчит компани гэж тус судалгаанд тодорхойлжээ. Хамгийн том компаниудад төрийн өмчийн хэлбэр хэрхэн ноёрхож байгааг харахад төрийн өмч хамгийн их зонхилсон таван улсад Хятад, Арабын Нэгдсэн Эмират, ОХУ, Индонез болон Малайз улс багтсан байна.

“Темасек Холдинг” компанийн зүгээс Монголын стратегийн ач холбогдол бүхий орд газрууд тэдгээрийн дэд бүтэц боловсруулах үйлдвэрлэлийг шийдвэрлэх чиглэлээр хамтран хэрэгжүүлэх талаар бодлого баримталж буй. Төрийн өмчийн тогтолцоонд Темасек загварыг нэвтрүүлснээр компаниудын засаглалыг бэхжүүлж, удирдлагын хариуцлага сайжирч, хараат бус байдал үгүй болох боломжтой гэдгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан хэллээ. Түүнчлэн өмчийн эрхийг хуулиар хамгаалж, компанийн удирдлагыг мэргэжлийн бөгөөд өндөр түвшинд хөгжүүлэх нөхцөл бүрдэх аж.


Төрийн өмчийн компаниудын ашиггүй ажиллагаа юунаас үүдэлтэй талаар Удирдлагын академийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Д.Долгорсүрэн “Төрөөс хэт хамааралтай байдал, төрийн онцгой эрх ямба эдэлдэг гаж тогтолцоо, эргээд түүнийхээ хариуд төрд үйлчилгээ үзүүлдэг энэ явуургүй байдал нь тухайн компанийн засаглалыг

эрүүл бус болгож байна. Өрсөлдөөний буюу бизнесийн зарчимд суурилсан шийдвэр гаргах үндсэн зарчмыг алдагдуулдаг. Энэ нь төрийн өмчийн компаниудын бүтээмжийг бууруулах, үйл ажиллагааг нь үр ашиггүй болгохын зэрэгцээ бодлого, хүний нөөцийг ч тогтворгүйжүүлж, хээл хахууль, шахааны бизнес гэх мэт зохисгүй үйлдэл гарахад нөлөөлж байна” гэсэн юм.

“Эрдэнэс Монгол” ХК-ийн хувьд Эрдэнэс Таван толгой, Эрдэнэс Оюутолгой, Багануур, Шивээ-Овоогийн

бизнесийн зарчмаар явдаг. Ингэснээр засаглалын хувьд шийдвэр гаргах үйл явц улс төрөөс ангид, илүү шуурхай, үр бүтээлтэй, үйл ажиллагаа нь ил тод, компани өөрөө тогтвортой, өрсөлдөх чадвартай болдог аж.

“Темасек”-ийн хөрөнгө оруулалтын стратеги нь богино хугацаанд гэнэтийн ашиг хайхад бус урт хугацаанд үнэлгээгээ өсгөх, тогтвортой өгөөжтэй байхыг чухалчилдаг. Темасек загвар нь зөвхөн Сингапураар зогсохгүй олон улсын хэмжээнд амжилтад



төрийн мэдлийн хувьцааг эзэмшиж буй толгой компанийн хувьд Сингапурын төдийгүй бүс нутгийн хамгийн том хөрөнгө оруулагч “Темасек Холдинг” компанитай хамтарч ажиллах болсон.

Сингапурын төрийн өмчит хөрөнгө оруулалтын корпораци болох “Темасек Холдинг” нь 1974 онд анх байгуулагдсан. 2013 оны байдлаар нийт активын хэмжээ нь 250 тэрбум ам.долларт хүрч, 12 тэрбум ам.долларын цэвэр ашигтай ажилласан байна. Энэ амжилтаараа “Темасек Холдингс” корпораци дэлхийд төрийн өмчийн компанийн зөв засаглал, оновчтой удирдлагын жишиг болж байна. “Темасек Холдинг” компанийн туршлага манайд илүү тохирох засаглалын хувилбар гээд байгаа учир нь төрийн шууд оролцоог бизнесийн үйл ажиллагаанаас тусгаарлаж, хязгаарлаж өгдөгөөрөө онцлог. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит компанийн үйл ажиллагаа нь улс төрийн нөлөөллөөс ангид, цэвэр

хүрсэн компаниуд ч мөрдлөг болгож ирсэн байдаг. Темасекын бизнесийн загварыг өндөр боловсролтой, үр бүтээлтэй хүний нөөцийг хөгжүүлж, үүгээрээ дамжуулан өөрийн удирдлагад байгаа компаниудын үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй байлгаж чаддаг ажээ. Сингапур улсын эдийн засгийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд тус корпорацийн оролцоо, хувь нэмэр маш өндөр байсан гэж судлаачид үздэг.

Өнгөрсөн хугацаанд улсын төсвийг “Эрдэнэт” зэрэг тоотой хэдэн томоохон компани бий болгож ирсэн. Харин улсын зарцуулж буй мөнгөний үлдсэн хувийг хувийн хэвшил бүрдүүлж буй. Иймээс төрийн өмчийн компаниуд бизнесийн зарчмаар ажиллаж, чөлөөт өрсөлдөөнд оролцон бодлого, үйл ажиллагаагаа тогтвортой авч явах ёстой гэдэг үүднээс тус компанийн туршлага манайд үлгэрлэл болно гэдгийг учир мэдэх хүмүүс тайлбарлаж байна. ■



## Салхи хаашаа чиглэнэ вэ

Г.Орхон

Монгол Улсад хэрэгжиж буй мега төслүүдийн салхи хагалагч Оюутолгой улсын эдийн засгийн чигийг тодорхойлох болж. “Оюутолгой хаашаа, эдийн засаг тийшээ” болоод буйг өнгөрсөн сард үзэглэсэн Гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөнөөс харж болох.

Өнгөрсөн онд манай улсын эдийн засгийн өсөлт нэлээд буурсан. Энэ онд эдийн засаг гурван хувьд, ирэх онд таван хувьд хүрнэ гэж Азийн хөгжлийн банк таамаглаж байна. Гэхдээ ирэх оны өсөлт Оюутолгойн санхүүжилт орж ирэхээс хамаарна хэмээн Азийн хөгжлийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын мэргэжилтэн

Раушан Маматкулов ярилаа.

Бизнес эрхлэгчид Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд гарын үсэг зурсан явдлыг дорвитой алхам гэж үзэж байгаа бөгөөд “Нэг төслийн эерэг нөлөө ингэж мэдрэгдэж буйгаас үзэхэд хүлээгдэж буй бусад томоохон төслийг дэмжин хөдөлгөвөл эдийн засгийн бүхий л салбар хэрхэх нь ойлгомжтой гэж бизнесийнхэн үзэж байна. Харин бүх хандлага, шийдвэрийг цаашид улстөржүүлээд байвал өмнөх гурван жилд бий болсон эдийн засгийн хүндрэлээс хэд дахин ноцтой үр дагаваруудыг бий болохыг мөн оцлов. Тиймээс баялаг бүтээгчид

үүний эсрэг, эдийн засгийн эрх чөлөө, бизнес, хөрөнгө оруулалтын орчноо хамгаалахын төлөө нэгдмэл хүчээр тууштай тэмцэхээ олонд сонордуулсан.

Эдийн засагт нүүрлээд буй хүндрэлийг улстөртэй холбох хүмүүс бий. Мөн Оюутолгойн төсөл болон дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн ханшийн нөлөөтэй холбон тайлбарлах эдийн засагчид ч олон байна. Энэ нь нэг талаар манай улсын эдийн засаг уул уурхайн салбараас хэт хамааралтай байгааг харуулдаг болойг энэ сарын 5-нд болсон “Монголын бизнес форум” олон улсын арга хэмжээний үеэр онцолж байлаа.



“Монголын бизнес форум” олон улсын арга хэмжээ

### Салхины эрчийг хэмжвээс

Хөгжлийн зүг салхилах Монголын эдийн засгийн салхины эрчийг хэмжвээс өдгөө Оюутолгой гол хүч болж байна. Гагцхүү улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлж буй уг төслийн араас хүч нэмэх дараагийн төслүүдээ хөдөлгөж, эдийн засгаа төрөлжүүлэх цаг ирснийг эдийн засагч, бизнесмэнүүд учирлаж байна. Уул уурхайн салбар нь улсын төсвийн 18, экспортын орлогын 84 хувийг бүрдүүдэг. Гэвч өнгөрсөн гурван жилд гарсан эдийн засгийн сөрөг өөрчлөлтөөс манай улс эдийн засгаа төрөлжүүлэхээр зорих болсон. АХБ-ны зүгээс үүнийг дэмжиж хөдөө аж ахуй, автозам, тээвэр, хүнс зэрэг хэд хэдэн салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж буйгаа илэрхийлэв. Тус банкнаас 1991 оноос хойш Монголд 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Одоогийн байдлаар тэд транзит тээврийг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй төслүүдэд Засгийн газартай хамтран ажиллаж байна. Тухайлбал, баруун бүсэд автозам барих ажилд санхүүжилт хийж байгаа аж.

Өнгөрсөн хугацаанд, тэр дундаа 2014 онд Монголын хөрөнгө оруулалтын орчинд таагүй өөрчлөлт нэлээд гарсан. Төрийн зүгээс эдийн засгаа солонгоруулах бодлого барьж байгаа бол Гадаадын хөрөнгө оруулалтын газар олон талт эдийн засгийг дэмжиж буй. Сүүлийн үед дотоодын зах зээлд Зүүн өмнөд Ази болон Европын орнуудаас шинэ хөрөнгө оруулагчид орж ирсэн талаар Хөрөнгө оруулалтын газрын Сурталчилгаа, зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Д.Ирмүүн онцоллоо. Хөрөнгө оруулагчдад Монголыг гэх сонирхол байсаар буйн нэг илрэл нь энэ оны нэгдүгээр улиралд гадаадын хөрөнгө оруулалттай 82 компани бүртгүүлснээс харж болно.

Хууль, эрх зүйн хувьд тодорхой өөрчлөлтийг хийж байж гаднын хөрөнгө оруулагчдыг татах асуудлыг “Монголын бизнес форум”-ын үеэр хөндсөн. “Эдийн засгийн ил тод байдлын буюу Өршөөлийн тухай хуулийг батлах зайлшгүй шаардлагатай. Мөн татварын шинэчлэлээ даруй хийж байж хөрөнгө оруулалтыг дотооддоо шингээж чадах” талаар МҮХАҮТ-ын

ерөнхийлөгч Б.Лхагважав тайлбарлав.

### Зөөлөн газардалт

Оюутолгойн төсөл амжилттай хэрэгжиж, улсын эдийн засаг сэргэвэл олон салбар хүнд байдлаас сэргэнэ. Уг төсөл цаашид хэрхэгийг монголчууд чих тавин хүлээж суугаа. Эдийн засгийн энэ хүнд үед банкны салбар нэлээд эрсдэл хүлээгээд буй. Тухайлбал, чанаргүй зээлийн хэмжээ өссөн. Уул уурхайн салбарын зээл үүний дийлэнхийг эзэлж байгааг “Голомт” банкны гүйцэтгэх захирал Л.Оюун-Эрдэнэ хэлэв. Үүний шалтгаан нь гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан гэж тэрбээр үзэв.

Үл хөдлөх хөрөнгө, барилгын салбар мөн л хүндхэн байгаа. Төвбанкнаас хэрэгжүүлж буй моргейжийн буюу найман хувийн зээл нь эдийн засагт огцом бууралт гаргахгүйн тулд хэрэгжүүлсэн хөтөлбөр гэдэг. Өөрөөр хэлбэл, “зөөлөн газардуулах” үүднээс авсан арга хэмжээ ажээ. Банкны салбарт тулгарч буй дээрх асуудлыг шийдэхийн тулд компаниудтай нягт хамтарч ажиллах шаардлагатайг “Голомт” банкны гүйцэтгэх захирал форумын үеэр дурьдсан. “Компаниуд бүтээмж, зардлаа бууруулах зэрэг арга хэмжээ авч байна. Мөн ажлын байр багасч байгаа. Энэ нь арилжааны банкуудын зээлийн багцын чанарт нөлөөлөхөөр байна” хэмээн Л.Оюун-Эрдэнэ ярьсан юм.

Түүнчлэн Монголын бизнесийн орчны нөхцөл байдал их эмзэг байгааг бизнес эрхлэгчид удаа дараа хэлэх болж. ХААН банкны гүйцэтгэх захирал Норихико Като “Ихэнх харилцагчийн хувьд хэцүү байдалтай байна. Барилгын салбарт төрөөс дэмжлэг үзүүлж байгаа ч байдал хүнд хэвээр. Эдийн засаг буурна гэж байна. Гэсэн ч бид иргэдээ дэмжсэн тухайлбал, найман хувийн зээлийг үргэжлүүлэн хэрэгжүүлнэ. Учир нь олон хүнд хэрэгтэй. Өмнөх жилүүдтэй харьцуулахад уг зээлд хамрагдсан иргэдийн тоо цөөрсөн ч бид компаниудын үр ашгийг чухалчилж байгаа. Хугацаа хэтэрсэн зээлийн өсөлт санасныг бодоход харьцангуй гайгүй байгаа. Тэгэхээр бид эдгээр асуудлыг хяналтад байлгаж чадаж байна гэж харж байна” хэмээн ярилаа.

Банк, санхүүгийн салбар өнөөдөр иймэрхүү асуудалтай нүүр тулж байхад

найман хувийн зээлийн хөтөлбөр цаашид урт хугацаанд хэрэгжих эсэх нь олон хүнд эргэлзээ үүсгэж буй. Монголбанкны ерөнхийлөгчийн зөвлөх, ерөнхий эдийн засагч С.Болд “Манай улсын эдийн засаг дэлхийн зах зээлээс хараат байх нь их аюултай. Тиймээс хуримтлал бий болгох нь чухал. Моргейжийн зээл хуримтлал бий болгох хүсэлтэй иргэдийг дэмжих бодлого. Урт хугацааны хуримтлалын бодлоготой хөтөлбөр” хэмээн “Монголын бизнес форум”-д хэлсэн үгэндээ онцолсон.

Улсын эдийн засгийн нөхцөл байдал иргэдэд нэлээд хүнд тусч буй. Эдийн засгийн хөгжлийн тулгуур багана болдог ажлын байр нэлээд хувиар буураад байна. Өнгөрсөн онд хөдөлмөрийн биржид 40 орчим мянган ажлын байр бүртгэгдэж байсан бол өнөөдөр 20 орчим мянга болон буурчээ. Хувийн хэвшилд бий болж буй ажлын байрны тоол гэхэд 50 хувиар буураад байгаа аж. Монголын ажил олгогч эдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирлын орлогч Ц.Эрдэнэбаатар “Энэ бол хувийн хэвшлийнхэн хөрөнгө оруулалтгүй болсонтой холбоотой. Ажилтан нэмж авах бололцоогүй гэсэн үг. Тиймээс иргэд орлоготой болгх боломж багасч байна” гэсэн юм.

Эдийн засаг энэ хэвээр удааширвал өдгөө хүндхэн байдалтай байгаа олон салбар бүр ч хэцүү байдалд орох нь. Барилгын салбарт л гэхэд татвар төлөлт их хэмжээгээр буурч, дагалдах салбар, тэр дундаа барилгын материалын худалдааны байгууллагуудын хооронд өрийн сүлжээ үүсэх зэрэг эрсдэл үүсэхээр байгааг Монголын барилгын үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Түмэнжаргал хэлсэн.

Ийм нөхцөл байдлаас гарах цаашлаад улсын эдийн засгийг сайжруулахын тулд бизнесийн орчныг улс төрөөс хараат бус болгох, Оюутолгойн араас хүлээгдэж буй томоохон төслүүдээ даруй хөдөлгөх хэрэгтэйг эдийн засагчид зөвлөж байна. Эдгээр төслөө хөдөлгөхийн тулд гаднын хөрөнгө оруулагчдыг Монголын зах зээлд аргамжих таатай орчин бүрдүүлэх шаардлагатай гэдэгт олон хүн санал нийлдэг. Энэ бүхнээс Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн салхи өсөлтийн зүгт хүчтэй үлээх эсэх нь шийдэгдэнэ. ■